1.3.3. Ядуурал .....	33
1.3.4. Нийгмийн даатгал .....	33
1.3.5. Нийгмийн халамж.....	34
1.3.6. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спорт .....	35
1.3.7. Эрүүл мэнд .....	38
1.4. БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖИЛ .....	42
1.4.1. Байгаль орчин, ногоон хөгжил .....	42
1.5. ЗАСАГЛАЛ, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ШИНЭТГЭЛ .....	44
1.5.1. Хууль, эрх зүйн шинэтгэл .....	44

1.5.2. Төрийн өмчийн бодлого, зохицуулалт .....	47
1.5.3. Стандарт, хэмжил зүй .....	47
1.5.4. Улсын мэргэжлийн хяналт .....	48
1.5.5. Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах.....	48
1.5.6. Онцгой байдал .....	49
1.6. ГАДААД ХАРИЛЦАА, БАТЛАН ХАМГААЛАХ.....	51
1.6.1 Гадаад харилцаа .....	51
1.6.2. Батлан хамгаалах .....	54
<b>ХОЁР. МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2020 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ, 2021-2022 ОНЫ ХАНДЛАГА .....</b>	<b>57</b>
2.1 ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГ, ГАДААД ОРЧИН.....	57
2.1.1 Дэлхийн эдийн засгийн төлөв .....	57
2.1.2 Голлох ашигт малтмалын бүтээгдэхүүний зах зээлийн хандлага .....	58
2.2 МАКРО ЭДИЙН ЗАСАГ .....	61
2.2.1 Эдийн засгийн өсөлт .....	61
2.2.2 Хэрэглээ, хуримтлал .....	62
2.2.3 Ажилгүйдэл.....	62
2.2.4 Инфляц .....	63
2.2.5 Гадаад худалдаа .....	63
2.2.6 Төлбөрийн тэнцэл .....	64
2.3 БОДИТ САЛБАРЫН ХӨГЖИЛ.....	65
2.3.1 Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр.....	65
2.3.2 Уул уурхай.....	66
2.3.3 Эрчим хүч.....	67
2.3.4 Зам, тээвэр .....	68
2.3.5 Барилга, хот байгуулалт.....	69
2.3.6 Аялал жуулчлал.....	69
2.3.7 Мэдээлэл, шуудан, харилцаа, холбоо .....	69
2.4 ХҮНИЙ ХӨГЖИЛ.....	69
2.4.1 Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбар.....	69
2.4.2 Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спорт.....	70
2.4.3 Эрүүл мэнд .....	70
2.5 БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖИЛ .....	71
2.5.1 Байгаль орчин, ногоон хөгжил .....	71
2.6 ЗАСАГЛАЛ, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ШИНЭТГЭЛ .....	71
2.6.1 Хууль, эрх зүйн шинэтгэл .....	71
2.6.2 Төрийн өмчийн бодлого, зохицуулалт .....	72
2.6.3 Стандарт, хэмжил зүй .....	72

2.6.4 Улсын мэргэжлийн хяналт .....	72
2.6.5 Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах.....	73
2.6.6 Онцгой байдал .....	73
2.7 ГАДААД ХАРИЛЦАА, БАТЛАН ХАМГААЛАХ.....	73
2.7.1 Гадаад харилцаа .....	73
2.7.2. Батлан хамгаалах .....	74
ГУРАВ. ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД УЧИРЧ БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛҮҮД.....	75
ДӨРӨВ. МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2020 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ШААРДАГДАХ ХӨРӨНГИЙН ТООЦОО .....	76
ТАВ. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД.....	76

## ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

График 1. Ажилгүйдлийн түвшин, улирлаар.....	12
График 2. Инфляцийн түвшин. ....	12
График 3. Мөнгөний нийлүүлэлт /тэрбум төгрөг/. .....	13
График 4. Мөнгөний нийлүүлэлт, гадаад болон дотоод цэвэр активийн жилийн өөрчлөлт. ....	14
График 5. Чанаргүй зээлийн үзүүлэлт /тэрбум төгрөг, эдийн засгийн салбарын ангиллаар/.....	14
График 6. Гадаад худалдааны нийт бараа эргэлт /урьдчилсан гүйцэтгэл, сая ам.доллар/. .....	15
График 7. Төлбөрийн тэнцэл, урьдчилсан гүйцэтгэл /сая ам.доллар/.....	16
График 8. Төлбөрийн тэнцэл, 2019 оны хүлээгдэж буй гүйцэтгэл /сая ам.доллар/....	16
График 9. Арилжааны банкуудын актив, пассивын бүтэц /тэрбум төгрөг/. .....	17
График 10. Хүнсний боловсруулах салбарын үйлдвэрлэл /тэрбум төгрөг/.....	18
График 11. Уул уурхайн салбарын экспортын бүтэц. ....	21
График 12. Дотоодын эрчим хүч үйлдвэрлэл, эх үүсвэрийн бүтэц /2018 он, хувиар/.	23
График 13. Цахилгаан эрчим хүчний нийт импорт /сая.кв.цаг/.	23
График 14. Авто тээврээр тээсэн ачаа болон зорчигчдийн тоо.	24
График 15. Төмөр замаар тээсэн ачаа болон зорчигчдийн тоо.	25
График 16. Агаарын тээврийн ачаа болон зорчигчдийн тоо.	25
График 17. Жуулчдын тоо /мянган хүн/.	27
График 18. Ядуурлын хамралтын хүрээ.	33
График 19. Сургуулийн өмнөх боловсролын хамрагдалтын тоо.	35
График 20. Хүн амын дундаж наслалт.	38
График 21. Эх, нялхас, 5 хүртэл насны хүүхдийн эндэгдэл.	39
График 22. Хүн амын өвчлөлийн шалтгаан.	39
График 23. Халдварт өвчнөөр өвчлөгчид.	40
График 24. Хүн амын нас баралтын тэргүүлэх шалтгаан.	41
График 25. Зэсийн үнийн хөдөлгөөн, төсөөлөл /ам.доллар/тонн/.	58
График 26. Алтны үнийн хөдөлгөөн, төсөөлөл /ам.доллар/твой унц/.	59
График 27. Төмрийн хүдрийн үнийн хөдөлгөөн, төсөөлөл /ам.доллар/тонн/.	59
График 28. Дэлхийн төмрийн хүдрийн үйлдвэрлэл /сая тонн/.	60
График 29. БНХАУ-ын нүүрсний импорт /сая тонн/.	60
График 30. Монгол Улсын нүүрсний экспорт /сая тонн/.	61
График 31. Газрын тосны үнийн төсөөлөл /ам.доллар/баррель/.	61
График 32. Эдийн засгийн өсөлт болон ДНБ-ий хэмжээ.	62
График 33. Хөдөлмөрийн үзүүлэлт, 2020-2022 оны төсөөлөл /хувь/.	63
График 34. Гадаад худалдаа.	64
График 35. Төлбөрийн тэнцэл, 2020-2022 оны төсөөлөл /сая ам.доллар/.....	64

## **ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ**

Хүснэгт 1. Эдийн засгийн өсөлт, салбаруудаар.....	10
Хүснэгт 2. Монгол Улсын малын тоо /мянган толгой/.....	18
Хүснэгт 3. Хураан авсан ургацын хэмжээ /мянган тонн/. .....	18
Хүснэгт 4. Ноос, ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэл.....	19
Хүснэгт 5. Уул уурхайн салбарын голлох бүтээгдэхүүний үйлдвэрлэл. ....	20
Хүснэгт 6. Цахилгаан, дулаан үйлдвэрлэл. ....	22
Хүснэгт 7. Барилга угсралт, их засварын ажлын хэмжээ /тэрбум төгрөг/ .....	26
Хүснэгт 8. Харилцаа холбооны салбарын үндсэн үзүүлэлт. ....	28
Хүснэгт 9. Хөдөлмөр эрхлэлтийн үндсэн үзүүлэлтүүд. ....	32
Хүснэгт 10. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага /тэрбум төгрөгөөр/.....	34
Хүснэгт 11. Нийгмийн даатгалын сангаас олгож байгаа тэтгэврийн дундаж, доод хэмжээ /мянган төгрөг/.....	34
Хүснэгт 12. Ерөнхий боловсролын сургууль болон суралцагчийн тоо. ....	36
Хүснэгт 13. Ерөнхий боловсролын сургуулийн бүлэг, анги болон ээлжээр.....	36
Хүснэгт 14. Улсын тусгай хамгаалалттай нутгийн ангилал /тоо, талбайн хэмжээ/. ....	43
Хүснэгт 15. Тохиолдсон гамшигт үзэгдэл, учирсан хохирол. ....	49

## **МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2018 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

Монгол Улсын Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 7 дахь хэсэг, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийг үндэслэн УИХ-ын 2017 оны 42 дугаар тогтоолоор “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх Үндсэн чиглэл”-ийг баталсан бөгөөд Үндсэн чиглэлийн биелэлтийг 2018 оны жилийн эцсийн байдлаар нэгтгэн, үнэлгээ хийв.

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 136 арга хэмжээнд давхардсан тоогоор Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлалаас 71.9 хувь буюу 97 арга хэмжээ, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрөөс 91.9 хувь буюу 124 арга хэмжээ, бусад бодлогын баримт бичгээс 26.4 хувь буюу 36 арга хэмжээ тусгагдсан.

“Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх Үндсэн чиглэл”-ийн 5 бодлого, 18 зорилт, 136 арга хэмжээний биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 76.7 хувьтай гарлаа.

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөлд тусгасан 5 бүлэг, 18 зорилтын 136 бодлогын арга хэмжээг нийтдээ 7.7 их наяд төгрөгийн санхүүжилтээр, үүнээс улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 683.5 тэрбум төгрөг, гадаад эх үүсвэрээс 1.5 их наяд төгрөг, төр хувийн хэвшлийн түншлэл болон хувийн хөрөнгө оруулалтаар 5.4 их наяд төгрөг, бусад эх үүсвэрээс 110.0 тэрбум төгрөгөөр тус тус санхүүжүүлэхээр төлөвлөн тусгасан.

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийн нийт 136 арга хэмжээнээс:

- 66 арга хэмжээ 100 хувь буюу бүрэн биелж,
- 40 арга хэмжээ 70 хувь,
- 23 арга хэмжээ 40 хувь,
- 6 арга хэмжээ 0 хувь;
- 1 арга хэмжээ нь үнэлэх боломжгүй байна.

\*\*\*oOo\*\*\*

## МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2020 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 7 дахь заалт, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.6 дахь хэсгийг үндэслэн “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн төслийг боловсрууллаа.

Үндсэн чиглэлийн төслийг боловсруулахдаа Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, Салбарын төрөөс баримтлах бодлогын баримт бичигтэй тус тус уялдуулан яамд, агентлагаас ирүүлсэн саналд үндэслэн улсын төсвийн хөрөнгө оруулалт болон бусад хөрөнгийн эх үүсвэртэй уялдуулан боловсруулсан болно. Тухайлбал, Үндсэн чиглэлийн төсөлд тусгагдсан нийт 118 арга хэмжээний 58 хувь нь Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалтай, 90 хувь нь Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй, 23 хувь нь Салбарын төрөөс баримтлах бодлогын баримт бичигтэй тус тус уялдсан байна.

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл нь Макро эдийн засгийн бодлого, Эдийн засгийн өсөлтийг дэмжих салбаруудын бодлого, Бүс нутаг, хөдөөгийн хөгжил, байгаль орчны бодлого, Хүний хөгжлийг дэмжих нийгмийн бодлого, Засаглал, эрх зүйн шинэчлэл, гадаад бодлого, батлан хамгаалах салбарын бодлого гэсэн нийт 5 бүлэг, 20 зорилтын хүрээнд 118 бодлогын арга хэмжээг тусгаснаас гадна зорилт, арга хэмжээ бүрийн шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин, шаардагдах санхүүжилт, хөрөнгийн эх үүсвэр, урт болон дунд хугацааны хөтөлбөр, бодлогын баримт бичгүүдтэй уялдсан байдал, хариуцан хэрэгжүүлэх байгууллагыг мөн тусгасан.

Макро эдийн засгийн бодлогын хүрээнд 2020 онд татварын орчныг шинэчлэх замаар хөрөнгө оруулалтыг дэмжиж эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах; төсөв, мөнгөний бодлогыг хослуулах замаар инфляцийг зорилтот түвшинд байлгах; ажлын байрыг нэмэгдүүлэх замаар ажилгүйдлийн түвшинг бууруулах; нэгдсэн төсвийн тэнцлийг дунд хугацаанд эерэг болгох нөхцөлийг бүрдүүлэх; хөрөнгийн зах зээлийг хөгжүүлж, санхүүгийн тогтвортой байдлыг хангах зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна.

Эдийн засгийн өсөлтийг дэмжих салбаруудын бодлогыг хэрэгжүүлэх чиглэлээр мал аж ахуйн салбарын хөгжлийг эрчимтэй хөгжүүлж, бэлчээрийн менежментийг сайжруулах; хүн амыг эрүүл, аюулгүй хүнсний бүтээгдэхүүнээр хангаж, жижиг, дунд үйлдвэрлэлийг бодлогоор дэмжиж, геологи, уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарыг хөгжүүлж, бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх; эрчим хүчний хэрэглээг дотоодын эх үүсвэрээр хангах бодлого хэрэгжүүлж, хүчин чадлыг нэмэгдүүлэх; бодит салбарын өсөлтийг дэмжих зам, тээврийн бодлого хэрэгжүүлж, логистикийн сүлжээг өргөжүүлэх чиглэлээр тодорхой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх бөгөөд эдгээр салбаруудын өсөлтийн нөлөөгөөр ДНБ-ий бодит өсөлт хангагдах боломж бүрдэнэ.

Бүс нутаг, хөдөөгийн хөгжил, байгаль орчны бодлогыг хэрэгжүүлэх чиглэлээр иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангасан хот, суурин газрыг төлөвлөж, байгаль орчин, хүний эрүүл мэндийн шаардлагад нийцсэн барилгын

үйлдвэрлэлийг дэмжиж, аюулгүй, хүртээмжтэй орон сууцаар хангах; агаар орчны бохирдлыг бууруулах, экосистемийн тэнцвэрт байдлыг хангаж, аялал жуулчлалыг хөгжүүлэх; гамшигаас хамгаалах бие бүрэлдэхүүний чадавхийг сайжруулж, гамшигийн үеийн бэлэн байдлыг нэмэгдүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх чиглэлээр бодлогын арга хэмжээнүүдийг тусгасан.

Хүний хөгжлийг дэмжих нийгмийн бодлогын хүрээнд боловсролын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, ая тухтай сурч, боловсрох орчныг бүрдүүлэх бодлого хэрэгжүүлэх; соёл урлагийн салбарт техник, технологийн ололтыг нэвтрүүлэх; судалгаанд суурилсан их сургуулиудыг хөгжүүлж, дээд боловсролын сургалтын байгууллагын багшийн хөгжлийг дэмжих; шинжлэх ухаан, технологийн салбарыг хөгжүүлж, судалгаа боловсруулалтын ажлын эдийн засаг, нийгмийн үр өгөөжийг нэмэгдүүлэх; харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын үйл ажиллагааг өргөжүүлэх; төрийн цахим үйлчилгээг нэвтрүүлэх; эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, урьдчилан сэргийлэх үзлэгийг нэмэгдүүлэх; хүн амын хөгжил, нийгмийн хамгаалал болон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого хэрэгжүүлэх чиглэлээр арга хэмжээ авч хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна.

Засаглал, эрхзүйн шинэчлэл, гадаад бодлого, батлан хамгаалах салбарын бодлогын хүрээнд эрх зүйн салбарын шинэчлэлийг үргэлжлүүлж, цагдаагийн байгууллагын мэдээ, мэдээллийн нууцлал, аюулгүй байдал, үйл ажиллагааны шуурхай байдлыг хангаж, Улсын бүртгэлийн нэгдсэн тогтолцоог үе шаттай төгөлдөржүүлж; үндэсний стандартыг шинээр боловсруулж, орон нутгийн стандартын байгууллагын чадавхыг бэхжүүлэх; хөрөнгө оруулалт, зураг төслийн хамтарсан төвийг байгуулах үйл ажиллагааг эрчимжүүлж, хилийн чанад дахь монгол иргэдийн эрх ашгийг хамгаалах үйл ажиллагааг бэхжүүлэх; энхийг дэмжих үйл ажиллагааны чадавхийг нэмэгдүүлж, зэвсэгт хүчний барилгын засвар төслийг хэрэгжүүлэх чиглэлээр тодорхой зорилт тавин ажиллана.

Салбарын яамд, агентлагуудаас ирүүлсэн арга хэмжээний саналуудыг үндсэн чиглэлийн төсөлд тусгахдаа бодлогын зорилт, арга хэмжээг улсын төсөв болон бусад хөрөнгийн эх үүсвэрийн боломжтой уялдуулан 20 зорилт 118 арга хэмжээний хүрээнд нийтдээ 10 их наяд 216.3 тэрбум төгрөгийг санхүүжүүлэхээс улсын төсвийн хөрөнгөөр 1 их наяд 325.5 тэрбум төгрөг, гадаад эх үүсвэрээс 2 их наяд 111.9 тэрбум төгрөг, төр, хувийн хэвшлийн түншлэл болон хувийн хөрөнгө оруулалтаар 6 их наяд 174.2 тэрбум төгрөг, бусад эх үүсвэрээс 604.7 тэрбум төгрөгөөр тус тус санхүүжүүлэхээр төлөвлөн тусгасан болно.

-----оОо-----

# МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2020 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ТӨСЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

## НЭГ. МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

### 1.1 МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН 2018 ОНЫ УРЬДЧИЛСАН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН ТОВЧ ШИНЖИЛГЭЭ, 2019 ОНЫ ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ГҮЙЦЭТГЭЛ

#### 1.1.1. Эдийн засгийн өсөлт

Монгол Улсын эдийн засаг 2018 онд сүүлийн дөрвөн жилийн хугацаанд хамгийн өндөр буюу 6.9 хувиар өсөв. Засгийн газар 2018 онд төсвийн сахилга батыг сайжруулснаар Монгол Улсын нэгдсэн төсөв ашигтай гарлаа. Мөн Засгийн газрын бонд гаргаж арилжааны банкнуудаас хөрөнгө татдаг байсныг зогсоосноор хувийн хэвшилд олгох зээл, хөрөнгө оруулалт нэмэгдэж, зээлийн хүү 17 хувь хүртэл буураад байна.

Түүнчлэн, бизнесийн орчин сайжирч Монгол Улсад оруулсан хөрөнгө оруулалт 2018 онд 30 хувиар өсөж, экспортын хэмжээ 13.1 хувиар нэмэгдлээ. Макро эдийн засгийн тогтвортой орчин бүрдэж байгаагийн үр дүнд эдийн засаг цаашид өсөх суурь бүрдлээ.

Өсөлтийн дүнд бизнес эрхлэгчдийн орлого нэмэгдэж, ашигт ажиллагаа сайжирч, улсын төсөвт төвлөрүүлсэн аж ахуйн нэгжийн орлогын албан татвар 2017 оноос 32 хувиар нэмэгдсэн байна. Мөн өсөлтийн үр дүнд ажил эрхлэлт нэмэгдэж, өрхийн орлого 15<sup>1</sup> хувиар өсөөд байна.

Эдийн засгийн өсөлтийг салбаруудаар авч үзвэл боловсруулах аж үйлдвэрийн салбар 2017-2018 онд 16-20 хувиар өсөж, эдийн засгийн бүтцийг сайжруулж байна.

*Хүснэгт 1. Эдийн засгийн өсөлт, салбаруудаар.*

	2015	2016	2017	2018*
<b>Эдийн засгийн бодит өсөлт</b>	2.4	1.2	5.3	6.9
<b>Хөдөө аж ахуй</b>	10.7	6.2	1.8	4.5
<b>Үйлдвэрлэл</b>	9.9	-0.4	0.4	6.2
уул уурхай	14.1	0.2	-5.5	5.1
боловсруулах аж үйлдвэр	2.6	-0.8	20.1	15.7
цахилгаан дулаан	4.5	2.0	5.5	8.2
барилга	-0.2	-4.9	7.3	-5.0
<b>Үйлчилгээ</b>	0.6	1.1	7.9	5.3
Бөөний болон жижиглэн худалдаа	-8.1	-2.6	7.1	3.4
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	5.1	11.5	14.2	6.7
Мэдээлэл, холбоо	-2.5	-6.6	15.8	4.0
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	5.8	1.1	5.4	6.1
<b>Цэвэр татвар</b>	-22.1	0.5	18.5	20.1

Эх үүсвэр: Үндэсний Статистикийн Хороо\* урьдчилсан гүйцэтгэл

Нүүрс, жонш, алтны үйлдвэрлэл нэмэгдсэний зэрэгцээ Оюутолгойн алтны агууламж сайжирснаар уул уурхайн салбарын өсөлт нэмэгдэж, 5.1 хувьд хүрэв.

<sup>1</sup> Нэг өрхийн сарын дундаж орлого 2017 оны 4 дүгээр улиралд 1,041 мянган төгрөг байсан бол 2018 оны 4 дүгээр улиралд 1,202 мянган төгрөг болсон.

Уул уурхайн бус салбар 2018 онд 7.5 хувиар өсөөд байна. Ургацын хэмжээ 2018 онд нэмэгдэж, 453 мянган тонн үр тариа, 170 мянган тонн төмс, 100 мянган тонн хүнсний ногоо хураан авснаар хөдөө аж ахуйн салбар 4.5 хувиар өссөн байна.

Зээлийн хэмжээ нэмэгдэж, санхүү, үл хөдлөх болон үйлчилгээний бусад салбаруудын өсөлт эрчимжиж, 6.1 хувьд хүрсэн.

Засгийн газар 2019 онд эдийн засгийн өсөлтийг эрчимжүүлэх, иргэдийн амьжиргааг дээшлүүлэх бодлого хэрэгжүүлж байна. Энэ хүрээнд:

- Татварын шинэчлэлийг хэрэгжүүлж, бизнесийн орчныг сайжруулж, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.
- Сургууль, цэцэрлэгийн хуртээмжийг нэмэгдүүлэхэд зориулж төсвийн хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлнэ.
- Төрийн албан хаагчдын цалин болон тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг үргэлжлүүлэн нэмэгдүүлж, иргэдийн амьжиргааг сайжруулах замаар өрхийн хэрэглээг өсгөнө.
- Тавантолгой, Газрын тос боловсруулах үйлдвэр, Төв цэвэрлэх байгууламж, ачаа, тээврийн гол авто зам зэрэг олон жил хүлээгдэж байгаа томоохон төслүүдийг хэрэгжүүлж, нийт эдийн засгийн хүчин чадлыг дээшлүүлнэ.

### **1.1.2. Хэрэглээ, хуримтлал**

ДНБ-д эзлэх эцсийн хэрэглээ 2018 оны урьдчилсан гүйцэтгэлээр 60.2 хувь, хөрөнгийн нийт хуримтлал 43.1 хувь, цэвэр экспорт -3.3 хувьтай байна. ДНБ-д эзлэх хөрөнгийн хуримтлал 2015 оноос хойших хамгийн өндөр түвшинд хүрээд байгаа нь эдийн засгийн идэвхжил сайжирч, хөрөнгө оруулалт эрчимтэй өссөнтэй холбоотой. 2018 онд ажлын байр нэмэгдэж, иргэдийн орлого өссөний үр дүнд өрхийн бодит хэрэглээ нь 3.9 хувиар өсчээ.

Дэлхийн эдийн засгийн өсөлт саарч байгаа хэдий ч экспортын гол нэр төрлийн бүтээгдэхүүний үнэ болон эрэлт 2019 онд харьцангуй тогтвортой байх төлөвтэй байна. БНХАУ-ын зах зээлд манай улсын уул уурхайн бүтээгдэхүүний эрэлт тогтвортой байхын зэрэгцээ мах, махан бүтээгдэхүүний эрэлт нэмэгдэх төлөвтэй байна. Эдгээр хүчин зүйлсийг харгалзан үзвэл экспорт 2019 онд 9.1 хувиар өсөхөөр байна.

Засгийн газраас хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх зорилтыг тавин ажиллаж байгаагын үр дүнд эдийн засгийн өсөлтөд хөрөнгө оруулалтын оруулах хувь нэмэр нэмэгдэхээр байна.


Монголбанкнаас хэрэглээний зээлийг хязгаарлах бодлого баримталж байгаа бөгөөд үүний үр дүнд бизнесийн хөрөнгө оруулалтыг дэмжсэн зээл нэмэгдэхээр байна. Энэ нь үйлдвэрлэл, барилга угсралт зэрэг эдийн засгийн бодит салбаруудыг дэмжинэ гэж үзэж байна.

### **1.1.3. Ажилгүйдэл**

Эдийн засаг өсөж, бизнесийн үйл ажиллагаа сэргэлттэй байгаагын үр дүнд 2018 оны дөрөвдүгээр улирлын байдлаар ажиллах хүчний оролцооны түвшин 61.9 хувьтай, ажилгүйдлийн түвшин 6.6 хувьтай байна.

Эдийн засгийн өсөлтийн үр дүнд ийнхүү ажлын байр бий болж байгаа нь иргэдийн орлого нэмэгдэхэд чухал нэмэр болж байна.

График 1. Ажилгүйдлийн түвшин, улирлаар.



Эх үүсвэр: УСХ

#### 1.1.4. Инфляци

Эдийн засгийн өсөлт нэмэгдэж, иргэдийн орлого өссөнөөр хэрэглээ өссөн ч инфляци зорилтот түвшинд буюу 8.1 хувьтай гарлаа. Харин Улаанбаатар хотын инфляци 9.7 хувьтай гарсны тал хувийг нийлүүлэлтийн болон улирлын шинж чанартай өсөлт бүрдүүлжээ. Тухайлбал, хатуу түлш буюу түлээ нүүрсний үнийн өсөлт 2.4 нэгж хувь, махны үнийн өсөлт 1.7 нэгж хувь, шатахууны үнийн өсөлт 1.3 нэгж хувийг бүрдүүлсэн.

Төгрөгийн амдоллартай харьцах ханш өмнөх оны мөн үеэс суларсны зэрэгцээ дэлхийн зах зээл дээрх газрын тосны үнэ өсөлттэй байсан нь шатахууны хилийн үнэ 9.9-30.8 хувиар өсөхөд голлон нөлөөлсөн байна. Харин хатуу түлшний үнэ улирлын онцлогтойгоор өссөн бол махны бүлгийн үнийн өсөлтөд малын зүй бус хорогдол өндөр байсан болон махны экспорт нэмэгдсэн нь нөлөөлжээ. 2018 онд нийлүүлэлтийн шалтгаантай үнийн өсөлт давамгайлсан байна.

График 2. Инфляцийн түвшин.



Эх үүсвэр: УСХ

Инфляцийн түвшин сүүлийн 2 сарын хугацаанд саарч 2019 оны 2 дугаар сарын байдлаар өмнөх оны мөн үеэс 6.9 хувь, өмнөх сараас 0.5 хувийн өсөлттэй гарлаа. Жилийн бууралтад хэрэглээний бараа, бүтээгдэхүүний сарын өсөлтийн хурд саарснаас гадна өнгөрсөн мөн үед бүтээгдэхүүний сарын өсөлт өндөр байсан нь суурь үеийн нөлөөгөөр инфляцийг буурахад гол нөлөө үзүүлсэн.

Хэрэглээний үнийн индексээр илэрхийлэгдсэн инфляци эрэлт талаасаа цалин болон төсвийн зардлаар дамжин дотоод эрэлтийг нэмэгдүүлэхээр байгаа бол байгаль цаг уурын шинжтэй нийлүүлэлтийн хүчин зүйл хэвээр хадгалагдана гэж төсөөлж инфляцийн түвшин 2019 онд зорилтот түвшин буюу 8 орчим хувьд хадгалагдахаар байна.

### 1.1.5. Мөнгөний нийлүүлэлт

Мөнгөний нийлүүлэлтийн хэмжээ 2018 онд 22.8 хувиар өсөж 19.5 их наяд төгрөгт хүрэв. Үүнд, эдийн засгийн идэвхжилтэй холбоотойгоор аж ахуйн нэгжүүдийн ашигт ажиллагаа өссөн, ажил эрхлэлт нэмэгдсэн, зээл олголт өссөн нь голлон нөлөөлжээ.

Монголбанк 2018 оны 3 дугаар сард бодлогын хүүг 1 нэгжээр бууруулсан бол 11 дүгээр сард 1 нэгжээр буцааж өсгөсөн байна. Энэ нь бодит секторын идэвхжил, инфляц, төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн хөдөлгөөнтэй холбоотой байна.

*График 3. Мөнгөний нийлүүлэлт /тэрбум төгрөг/.*



Эх үүсвэр: Монголбанк


*График 4. Мөнгөний нийлүүлэлт, гадаад болон дотоод цэвэр активийн жилийн өөрчлөлт.*

Эх үүсвэр: Монголбанк

### 1.1.6. Зээлийн үзүүлэлт

Хэрэглээ өссөн, бизнесийн үйл ажиллагаа сэргэсний үр дүнд зээлийн өрийн үлдэгдэл 2018 онд 26.5 хувиар өсөж 17.3 их наяд төгрөг боллоо. 2018 оны эцэст арилжааны банкуудын чанаргүй зээлийн хэмжээ 1778.3 тэрбум төгрөг болсон нь активыг үнэлэх аргачлал өөрчлөгдсөнтэй холбоотой байна.

**График 5.** Чанаргүй зээлийн үзүүлэлт /тэрбум төгрөг, эдийн засгийн салбарын ангилаар/.




Эх үүсвэр: Монголбанк

### 1.1.7. Гадаад худалдаа

Гадаад худалдааны нийт бараа эргэлт 2018 онд 12.9 тэрбум ам.доллар болж, өмнөх оноос 22.5 хувиар өссөн бол гадаад худалдааны тэнцэл 1,153.7 сая ам.долларын ашигтай гарч өмнөх оноос 38.1 хувиар буурсан байна.

*График 6. Гадаад худалдааны нийт бараа эргэлт /урьдчилсан гүйцэтгэл, сая ам.доллар/.*



Эх үүсвэр: Үндэсний Статистикийн Хороо

Экспортоор 7.0 тэрбум ам.долларын бараа, түүхий эд гаргасан нь өнгөрсөн оноос 13.4 хувиар өссөн байна. Уг өсөлтөд нүүрс, зэсийн баяжмал, жонш зэрэг уул уурхайн бүтээгдэхүүний экспорт өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Импортоор 5.9 тэрбум ам.долларын бараа, түүхий эд авсан нь өнгөрсөн оны мөн үеэс 35.5 хувиар өсжээ. Импортын өсөлтөд мал, амьтан, ургамлын гаралтай бүтээгдэхүүн, хүнсний зүйл, дизелийн түлш, машин, механик тоног төхөөрөмж, төмөрлөг бүтээгдэхүүн, бүх төрлийн автомашины өсөлт голлон нөлөөлсөн байна.

Монгол Улсын гадаад худалдааны нийт эргэлт 2019 онд 13.9 тэрбум ам.долларт, гадаад худалдааны тэнцэл 1.5 тэрбум орчим ам.долларт хүрэхээр хүлээгдэж байна.

Экспортын хэмжээ 2019 онд 9.1 хувиар өсөж 7.7 орчим тэрбум ам.долларт хүрэхээр хүлээгдэж байна. Олон улсын банк, санхүүгийн байгууллагуудаас дэлхийн зах зээл дэх уул уурхайн эрдэс бүтээгдэхүүний эрэлт, үнэ харьцангуй тогтвортой байхаар төсөөлж байна. Өнгөрсөн оноос Монгол Улс, БНХАУ-ын хилийн боомтууд дээр шинэчлэл хийж, хилийн нэвтрүүлэх чадварыг нэмэгдүүлэх ажлыг эхлүүлээд байна.


Импортын хэмжээ 5.5 хувиар өсөж 6.2 орчим тэрбум ам.долларт хүрэхээр хүлээгдэж байна. Цалин, тэтгэвэр, тэтгэмжийн өсөлтөөс үүдэлтэй өргөн хэрэглээний бүтээгдэхүүний хэрэглээ өсөхөөр байна. Мөн төсвийн хөрөнгө оруулалт нэмэгдсэн, дэд бүтцийн томоохон төслүүдийн хэрэгжилттэй холбоотойгоор импорт өсөхөөр байна.

### 1.1.8. Төлбөрийн тэнцэл

Төлбөрийн тэнцэл 2018 оны урьдчилсан гүйцэтгэлээр 141.2 сая ам.долларын алдагдалтай гарлаа. Дансуудаар авч үзвэл, урсгал данс 1,902.1 сая ам.долларын алдагдалтай гарч, алдагдал өнгөрсөн оны мөн үеэс 64.6 хувиар нэмэгдсэн бол хөрөнгө ба санхүүгийн данс 1,888.1 сая ам.долларын ашигтай гарч, ашиг нь өмнөх оны мөн үеэс 29.5 хувиар буурсан байна.

Урсгал тэнцлийн алдагдал ийнхүү өсөхөд эдийн засгийн идэвхижил сэргэсэнтэй холбоотойгоор импорт 35.5 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна. Харин хөрөнгө ба санхүүгийн дансны хувьд Чингис-1 болон Дим сам бондын эргэн төлөлтийг хийсэнтэй холбоотойгоор багцын хөрөнгө оруулалтын ашиг буурсан бол АХБ, БНСУ-аас орж ирсэн санхүүгийн эх үүсвэр, МУХБ-ны 500 сая ам.долларын гадаад бондын эх үүсвэр санхүүгийн дансны ашигт эзэрэгээр нөлөөлсөн байна.

График 7. Төлбөрийн тэнцэл, урьдчилсан гүйцэтгэл /сая ам.доллар/.



Эх үүсвэр: Монголбанк


Монгол Улсад 2018 онд цэвэр дүнгээр 1,951.5 сая ам.долларын гадаадын шууд хөрөнгө оруулалт орж ирсэн байна.

Оюутолгой төслийн хүрээнд 2018 онд 1,304.3 сая ам.долларын хөрөнгө оруулалт орж ирснээс 1,213.8 сая ам.долларыг далд уурхайн бүтээн байгуулалтад хөрөнгө оруулсан байна.

Төлбөрийн тэнцэл 2019 онд ашигтай гарахаар хүлээгдэж байна. Гадаад худалдааны тэнцэл сайжирч байгаа нь ургал тэнцлийн алдагдал буурахад нөлөөлж байна.

Харин хөрөнгө ба санхүүгийн дансны хувьд 2019 оны 2 дугаар сард МИК гадаад зах зээлд 300 сая ам.долларын үнэт цаас гаргасан нь санхүүгийн дансны ашиг нэмэгдэхэд нөлөөлж байна.

График 8. Төлбөрийн тэнцэл, 2019 оны хүлээгдэж буй гүйцэтгэл /сая ам.доллар/.




Эх үүсвэр: Сангийн яам

2019 онд уул уурхай, олборлолт, бөөний болон жижиглэн худалдааны салбарт хөрөнгө оруулалт нэмэгдсэнээр Монгол Улсад орж ирэх гадаадын шууд хөрөнгө оруулалт 2 тэрбум ам.доллар давах төлөвтэй байна.

#### **1.1.9. Санхүүгийн зах зээл**

Банкны салбарт 2018 оны эцсийн байдлаар нийт 14 банк 1500 гаруй салбар нэгжтэйгээр үйл ажиллагаа явуулж байна. Нийт харилцагчдын тоо давхардсан дүнгээр 8.9 сая, зээлдэгчдийн тоо 1.2 саяд хүрчээ.

*График 9. Арилжааны банкуудын актив, пассивын бутэц /тэрбум төгрөг/.*



Эх үүсвэр: Монголбанк

Арилжааны банкуудын активын хэмжээ 33.1 их наяд төгрөгт хурч, 2017 оноос 15.0 хувиар өссөн байна.

Арилжааны банкуудын нийт пассивын хэмжээ 27.8 их наяд төгрөгт хүрч, 2017 оноос 4.2 их наяд төгрөг буюу 16.3 хувиар өссөн байна. Өөрийн хөрөнгийн хэмжээ 2017 оноос 3.5 хувиар өсөж 3.3 их наяд төгрөгт хүрээд байна.

Ипотекийн зээлдэгчдийн тоо 2018 оны 12 дугаар сарын байдлаар 93.7 мянгад хүрч, зээлийн нийт үлдэгдэл 4,430.2 тэрбум төгрөг буюу ДНБ-ий /2018 оны урьдчилсан гүйцэтгэл/ 13.8 хувьд хүрээд байна.

## 1.2 БОДИТ САЛБАРЫН ХӨГЖИЛ

#### 1.2.1. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр

**Мал аж ахуй.** Мал тооллогын урьдчилсан дүнгээр 2018 оны жилийн эцэст малын тоо 66.5 сая толгойд хүрч, өмнөх оноос 0.4 хувь буюу 244.7 мянган толгой малаар өссөн, үүнээс 3.9 сая адуу, 4.4 сая үхэр, 0.4 сая тэмээ, 30.6 сая хонь, 27.1 сая ямаа тоологдоо. Нийт мал сүргийн 46.0 хувь нь хонь, 40.8 хувь нь ямаа, 6.6 хувь нь үхэр, 5.9 хувь нь адуу, 0.7 хувь нь тэмээ эзэлж, өмнөх оноос хонины эзлэх хувь 0.5 пунктээр өсөж, ямааных 0.5 пунктээр буурч, адуу, үхэр, тэмээнийх өмнөх оны түвшинд байна.

2018 оны эцэст нийт 2.6 сая том мал зүй бусаар хорогдсон байна.

Улсын хэмжээгээр малтай нэг өрхөд ногдох малын тоо 2018 онд дунджаар 286 болж, өмнөх оноос 2 (0.7%)-оор буурлаа. Малтай нэг өрхөд 17 адуу, 19 үхэр, 2 тэмээ,

132 хонь, 117 ямаа ногдож байна. Өмнөх оноос малтай нэг өрхөд ногдох хонь 1-ээр өсөж, ямаа 2-оор буурч, харин адuu, үхэр, тэмээний тоо өөрчлөлтгүй байна.

#### *Хүснэгт 2. Монгол Улсын малын тоо /мянган толгой/.*

Малын төрөл	2013	2014	2015	2016	2017	2018
Тэмээ	321.5	349.3	367.9	401.3	434.1	459.7
Адуу	2,618.5	2,995.8	3,294.6	3,634.9	3,939.4	3,940.0
Үхэр	2,908.5	3,413.9	3,779.5	4,080.3	4,388.2	4,380.8
Хонь	20,060.2	23,214.8	24,933.4	27,853.4	30,108.0	30,554.8
Ямаа	19,218.5	22,008.9	23,582.5	25,572.2	27,346.1	27,124.4
Бүгд	<b>45,127.2</b>	<b>51,982.6</b>	<b>55,957.9</b>	<b>61,542.0</b>	<b>66,215.8</b>	<b>66,460.1</b>

Эх үүсвэр: УСХ

Мал аж ахуйн салбараас жилд дунджаар хонины ноос 33.0 мянган тонн, ямааны ноолуур 10.9 мянган тонн, тэмээний ноос 2.0 мянган тонн, 902.3 сая литр сүү, нядалгааны жингээр 493.4 мянган тонн мах, 18.2 мянган ширхэг арьс, шир үйлдвэрлэсэн.

**Газар тариалан.** Улсын хэмжээнд 2018 онд нийт 508.1 мянган га талбайд тариалалт хийснээс 453.8 мянган га-гаас үр тариа, 168.9 мянган тонн төмс, 100.7 мянган тонныг хураан авч, 1.2 сая тонн хадлан, 51.1 мянган тонн гар тэжээл бэлтгэсэн байна.

Нийт тариалсан талбайн хэмжээ буурсан хэдий ч өмнөх онтой харьцуулахад хураасан үр тариа 215.7 (90.6 %) мянган тонн, төмс 47.1 (38.6 %) мянган тонн, хүнсний ногоо 18.6 (22.7 %) мянган тонн, хадлан 221.2 (21.9%) мянган тонноор өсөж, бэлтгэсэн гар тэжээл 1.2 (2.3 %) мянган тонноор буурсан байна.


#### *Хүснэгт 3. Хураан авсан ургацын хэмжээ /мянган тонн/.*

Таримлын төрөл	2013	2014	2015	2016	2017	2018
Үр тариа	388.7	518.7	215.7	483.5	238.1	453.8
Үүнээс: буудай	373.3	489.4	203.9	467.1	230.6	428.6
Төмс	190.6	164.0	165.2	165.3	121.8	168.9
Хүнсний ногоо	102.2	102.2	72.7	94.4	82.1	100.7
Тэжээлийн ургамал	43.6	40.3	50.3	53.4	47.9	46.3
Тосны ургамал	42.6	51.7	22.4	21.5	12.5	23.4

Эх үүсвэр: УСХ

**Хүнсний үйлдвэрлэл.** Хүнсний боловсруулах салбарын нийт үйлдвэрлэлийн хэмжээ 2018 оны урьдчилсан гүйцэтгэлээр 1.6 их наяд төгрөгт хүрч өмнөх оноос 29 хувь буюу 353.3 тэрбум төгрөгөөр өссөн байна.

#### *График 10. Хүнсний боловсруулах салбарын үйлдвэрлэл /тэрбум төгрөг/.*



Салбарын хэмжээнд 2018 оны байдлаар 1,914 хүнсний үйлдвэр, цех үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд тэдгээрт нийт 12.7 мянган хүн ажиллаж байна. Үүнээс сүү, сүүн бүтээгдэхүүний 235 үйлдвэр, цех, 72 хөргөлтийн төв улирлын чанартай үйл ажиллагаа явуулж, нийт 1,238 хүн ажиллаж байна. Үйлдвэрийн аргаар боловсруулсан сүү, сүүн бүтээгдэхүүний хэмжээ 2017 оны дүнгээр 86.6 сая литр байсан бол 2018 оны урьдчилсан гүйцэтгэлээр 93.0 сая литр сүү, сүүн бүтээгдэхүүнийг үйлдвэрийн аргаар боловсруулсан байна.

2018 оны урьдчилсан гүйцэтгэлээр сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2017 оны мөн үетэй харьцуулахад шингэн сүү 12.7 хувь, тараг 23.7 хувь, зайнраг 60.6 хувь, цөцгий 33.3 хувь, өтгөн цөцгий 12.1 хувь, өрөм зөөхий 46.8 хувь, шар тос 97.7 хувь, бяслаг, аарц 93.9 хувиар тус тус өссөн байна. Харин цөцгийн тос 0.9 хувиар буурсан байна.

Улсын хэмжээнд 2018 оны байдлаар 942.7 мянган тонн үр тариа тээрэмдэх суурилагдсан хүчин чадал бүхий 63 гурилын үйлдвэр, цех байгаагаас 10 гурилын үйлдвэр цех тогтмол үйл ажиллагаа явуулан нийт хүчин чадлын 27 хувийг ашиглан нийт 208.7 мянган тонн гурил үйлдвэрлэсэн байна.

Монгол Улс жилдээ 12-14 сая толгой малыг хүн амын хүнсэнд хэрэглэж байна. Улсын хэмжээнд 2018 онд нийт 54.9 мянган тонн малыг экспортолсон нь 2018 онд хүнсний зориулалтаар бэлтгэсэн нийт 308 мянган тонн малын маҳны 17.8 хувийг бүрдүүлж байна. Max, малан бүтээгдэхүүний экспортын орлого 2018 оны жилийн эцсийн байдлаар нийт 156.8 сая ам. долларт хүрээд байна. Дулааны аргаар боловсруулсан малан бүтээгдэхүүний экспортын хэмжээ 17.6 мянган тонн болж сүүлийн 5 жилийн дундажтай харьцуулахад 23 дахин нэмэгдээд байна.

**Хөнгөн үйлдвэр.** Боловсруулах аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2018 онд 3.4 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 30 орчим хувиар өссөн байна.

Хүнсний үйлдвэрлэл нийт боловсруулах аж үйлдвэрийн 46 хувь, нэхмэл, хувцас, арьсны ширний үйлдвэрлэл 21 хувийг тус тус эзэлж байна.

Хөнгөн үйлдвэрийн салбарт 2018 оны байдлаар 2,000 гаруй аж ахуйн нэгж ноос, ноолуур, арьс шир, мод модон тавилга, оёмол бүтээгдэхүүн, хувцас үйлдвэрлэл, барилгын материал, хэвлэл, сав баглаа боодол, дахин боловсруулах, цахилгаан бараа, гоо сайхан, эм, ахуйн химиийн болон бэлэг дурсгалын гэсэн 14 чиглэлд 57.0 мянган хүнтэйгээр үйл ажиллагаа явуулж байна. Ноос ноолуур, арьс шир, оёдол, мод модон эдлэл нь нийт хөнгөн үйлдвэрлэлийн 60 хувийг эзэлж байна. Үүнээс ноос, ноолуурын салбар нь хөнгөн үйлдвэрийн салбарын 50 хувийг эзэлж, 2018 оны байдлаар 1.2 их наяд төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 75 хувийг нь экспортод гаргасан байна. Угаасан ноос, ноолуурыг Хятад улс руу, самнасан ноолуурыг Итали, Англи, нэхмэл сүлжмэл бэлэн бүтээгдэхүүнийг Америк, Герман, Солонгос, Япон, Бельги, Франц зэрэг 20 гаруй оронд 409 сая ам. долларын бүтээгдэхүүнийг экспортолсон ба нийт ноос, ноолуурын экспортын 80 хувийг угаасан ноолуур эзэлж байна.

#### Хүснэгт 4. Ноос, ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэл.

Бүтээгдэхүүний нэр	Хэмжих нэгж	2014	2015	2016	2017	2018*
1 Самнасан ноолуур	тонн	633.2	754.5	782.1	1108.8	1160.3

2	Тэмээний ноосон хөнжил	мянган метр	18.5	23.0	12,2	30.2	9.4
3	Эсгий	мянган метр	163.1	164	99.9	114.9	112.1
4	хивс	мянган метр	743.6	680.2	432.9	473	528.2
5	Эсгий гутал	Мянган хос	10.8	0.6	0.5	0.3	0.4

Эх үүсвэр: YCX

Монгол Улсын стратегийн түүхий эд болох ноолуурын салбарын хууль эрх зүй, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах, түүхий эд бэлтгэлийн тогтолцоог сайжруулах, нөөцийн ашиглалтыг нэмэгдүүлэх зорилгоор үйлдвэрүүдийн суурилагдсан хүчин чадлын ашиглалтыг дээшлүүлэх, хүчин чадал нэмэгдүүлэх, технологийн шинэчлэл хийх, үйлдвэрлэлийн эргэлтийн хөрөнгийг шийдвэрлэх, гадаад зах зээлд эзлэх хувь хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор “Ноолуур” хөтөлбөрийг Засгийн газрын 2018 оны 47 дугаар тогтоолоор батлан хэрэгжүүлж байна.

Мод, модон эдлэл үйлдвэрлэлийн салбарт 500 үйлдвэр, аж ахуйн нэгж 5,000 орчим хүнтэй үйл ажиллагаа явуулж байна. 2018 оны жилийн эцсийн дүнгээр 15.0 тэрбум төгрөгийн үйлдвэрлэл явуулсан бөгөөд үүний 31.3 хувь нь модон тавилга, 28.3 хувь нь шахмал хавтан, 17.8 хувь нь барилгын модон хийц, 23.8 хувь нь тулээний мод, 14.9 хувь шахмал түлш байна.

### 1.2.2. Уул уурхай, хүнд үйлдвэр

**Уул уурхай.** Уул уурхайн салбарын нийт үйлдвэрлэл 2018 оны жилийн эцсийн байдлаар 11,230.8 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 19.6 хувиар өссөн байна.

*Хүснэгт 5. Уул уурхайн салбарын голлох бүтээгдэхүүний үйлдвэрлэл.*

Бүтээгдэхүүн	2014	2015	2016	2017	2018*
Нүүрс /мянган тонн/	24,927.1	24,148.9	35,421.9	47,101.4	50,009.3
Зэсийн баяжмал /металл агуулгаараа мянган тонн/	1,080.4	1,334.7	1,445.1	1,317.1	1,310.8
Төмрийн хүдрийн баяжмал /мянган тонн/	10,260.5	6,173.4	7,146.1	11,369.7	9,630.9
Газрын тос (мянган баррель)	7,405.3	8,769.3	8,249.8	7,624.1	6,388.6
Цайрын баяжмал /мянган тонн/	93.2	89.6	100.2	82.7	87.9
Алт /кг/	11,503.8	14,556.2	18,435.7	19,846.8	20,655.2


Эх үүсвэр: YCX

Уул уурхайн салбар 2017 оны байдлаар дотоодын нийт бүтээгдэхүүний 23.4 хувийг, нийт экспортын 89.2 хувийг дангаараа бүрдүүлж байсан бол 2018 оны жилийн эцсийн байдлаар дотоодын нийт бүтээгдэхүүний 23.6 хувийг, нийт экспортын 88.8 хувийг дангаараа бүрдүүлж байна.

Монгол Улсын нийт экспорт 2018 оны жилийн эцсийн байдлаар 7.0 тэрбум.ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 13.4 хувиар өссөн байна. Уг өсөлтөд нүүрс, зэсийн баяжмал, жонш зэрэг уул уурхайн бүтээгдэхүүний экспортын өсөлт голлон нөлөөлсөн байна.

Уул уурхайн салбарын голлох нэр төрлийн бүтээгдэхүүнүүдийн экспортод эзлэх хувь хэмжээг авч үзвэл 39.9 хувийг нүүрс өзэлж байна.

График 11. Уул уурхайн салбарын экспортын бүтэц.



Эх үүсвэр: УСХ

**Геологи.** Геологийн салбарыг хөгжүүлэх, эрдэс баялгийн сан хөмрөгийг арвижуулах, геологи эрдэс баялгийн судалгааны ажлыг дэвшилтэт техник, технологиор мэргэжлийн багаар гүйцэтгүүлэх бодлогыг баримтлан ажиллаж байна. Энэ хүрээнд Монгол Улсын нутаг дэвсгэрийн 38.7 хувийг 1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн судалгаанд бүрэн хамруулж, 2018 онд геологийн 8 төслийг хэрэгжүүлж ашигт малтмалын хэтийн төлөвтэй талбайнуудыг ялган тодорхойлоод байна.

Мөн Монгол Улсын нутаг дэвсгэрийг 100 хувь хамруулсан геологийн 1:200000-ны масштабын иж бүрдэл зургийг К хавтгай хэмжээнд нэгтгэх ажлын хүрээнд суурин болон хээрийн судалгааны анхдагч материалыг хүлээн авч, K48, K-49 хавтгайн хэмжээнд геологи, ашигт малтмал, экологи геологийн зургуудыг хийж гүйцэтгэсэн. Үүний үр дүнд улсын геологийн иж бүрдэл зургийг К хавтгайн хэмжээнд нэгтгэх ажлыг нийт нутаг дэвсгэрийн 25 хувьд нь хамруулаад байна.

Томоохон хотуудын геоэкологи, гидрогеологийн судалгаа болон сэдэвчилсэн судалгааны ажлын хүрээнд “Улаанбаатар хотын геоэкологи, гидрогеологи - 2017”, “Голлох ашигт малтмалын судалгаа”, “Хойд, төв, зүүн Азийн гүний геологийн процесс ба металлогени”, “Геомэдээллийн сан-2013”, “Сансрын зургийн тайлалт - 2013”, “Метталогени - 2014”, “Баруун Монголын цул сульфид” зэрэг төслүүдийг хэрэгжүүлж байна.

Мөн “Алт-2” үндэсний хөтөлбөрийн хүрээнд хээрийн судалгааны ажлыг Дорнод, Хэнтий, Сүхбаатар, Говь-сүмбэр аймгийг бүрэн, Сэлэнгэ, Төв, Дундговь аймгийн зүүн хэсэг, Дорноговь аймгийн хойд, зүүн талын сумдыг хамруулан гүйцэтгэсэн бөгөөд нийтдээ 32000 км<sup>2</sup> талбайг хамруулан, мэдээллийн санг үүсгээд байна.

Агаарын геофизикийн цогцолбор судалгааны ажлыг Монгол Улсын баруун өмнөд хэсэгт буюу Баян-Өлгий, Ховд, Говь-Алтай, Баянхонгор, Өмнөговь аймгуудын урд хэсгийн нийт 207,094.0 км<sup>2</sup> талбайд гүйцэтгэв. Судалгааны ажлын үр дүнд хар болон өнгөт, үнэт металлын олон тооны дунд ба томоохон хэмжээний ордуудыг илрүүлэх боломжтой геологийн тогтцуудыг илрүүлж, нийт нутаг дэвсгэрийн 13.2 хувийг агаарын геофизикийн судалгаанд хамруулсан.

**Хүнд үйлдвэр.** Хүнд аж үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх ажлын хүрээнд “Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр”, “Газрын тос боловсруулах үйлдвэр”, “Нүүрс угаах, гүн боловсруулах үйлдвэр” болон “Хар төмөрлөгийн үйлдвэр”-ийн төслийг хэрэгжүүлэх зорилт тавин ажиллаж байна.

Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн урьдчилсан ТЭЗҮ-ийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны дэргэдэх “Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулах төслийн нэгж” боловсруулсан. Мөн төслийн Байгаль орчны ерөнхий үнэлгээний тайланг мэргэжлийн байгууллагаар хийж гүйцэтгүүлээд байна.

Газрын тос боловсруулах үйлдвэрийн нарийвчилсан ТЭЗҮ-ийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны дэргэдэх Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлж, хүлээн авсан. Үйлдвэрийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлууд болох хүнд даацын авто зам, төмөр зам, цахилгаан дамжуулах шугамын барилгын ажлууд 50 хувьтай явагдаж байна.

“Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр барих төсөл”-ийн барилга угсралтын ажлыг гүйцэтгэх компанийг сонгон шалгаруулах гэрээ хэлэлцээрийг хийх ажлын хүрээнд БНХАУ-ын Үндэсний газрын тосны корпораци (CNPC) -ийн охин компанийтай хамтран ажиллах санамж бичгийг байгуулахаар ажиллаж байна. Мөн төслийн хүрээнд Улаанбаатар хотын дүүргүүдтэй хамтран ажиллаж, хотын дулаан хангамжийн ерөнхий төлөвлөлттэй холбоотой баримт материал, зураг схемийг боловсруулан холбогдох урьдчилсан судалгааны ажлыг хийгээд байна.

Дархан-Сэлэнгийн бүсэд хар төмөрлөгийн цогцолборыг дэд бүтцийн хамт байгуулах төслийн “Байгаль орчны нийгмийн нөлөөллийн үнэлгээ”-ний урьдчилсан судалгааны тайланг Монгол Улсын “Экотон”, болон “Ажид”, “Экосфер” ХХК-иудын түншлэлийн баг боловсруулан ажиллаж байна.

**Эрчим хүч.** Монгол Улсын эрчим хүчиний салбарын тасралтгүй, найдвартай ажиллагааг хангах зорилгоор “ДЦС-3-ын өндөр даралтын хэсгийн суурилагдсан хүчин чадлыг 75 МВт-аар өргөтгөх”, “Чойбалсангийн ДЦС-ыг 50 МВт-аар өргөтгөх”, “Тавантолгой 300 МВт-ын цахилгаан станцыг барих”, “Багануурын 700 МВт-ын ДЦС барих”, “Аймгийн төвүүд болон томоохон хот суурин газарт дулааны станц, шугам сүлжээг шинээр барих”, Эрдэнбүрэнгийн 64 МВт-ын усан цахилгаан станц барих”, “Багануур дэд станцаас Чойр хүртэл 220 кВ-ын 2 хэлхээт 178 км ЦДАШ барих”, “Багануур-Өндөрхааны 2 хэлхээт 220 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, Өндөрхаан 220 кВ-ын дэд станцуудыг барих” төслүүдийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэхээр ажиллаж байна.

Эрчим хүчиний салбар 2018-2019 оны өвлийн их ачаалалд батлагдсан горим, төлөвлөгөөний дагуу ажиллаж, системийн оргил ачаалал 1384.8 МВт хүрснээс төвийн эрчим хүчиний системийн оргил ачаалал 1116 МВт-д хүрч ажиллав.


#### *Хүснэгт 6. Цахилгаан дулаан үйлдвэрлэл.*

Эх үүсвэр: YCX

	Нэгж	2014	2015	2016	2017	2018*
Цахилгаан эрчим хүч	сая квт.цаг	4,632.3	4,772.4	4,938.6	5,197.7	5,664.5
Дулааны эрчим хүч	мян.Гкал	9,126.6	9,593.4	10,334.5	10,680.0	11,479.2

Монгол улсын хэмжээнд 2018 онд 5,664.5 сая кВт.цаг цахилгаан эрчим хүч 11,479.2 мян.Гкал дулааны эрчим хүч тус тус үйлдвэрлэн боловсруулж, өмнөх оноос цахилгаан эрчим хүчний боловсруулалт 8.98 хувиар буюу 466.8 сая кВт.цагаар, дулааны эрчим хүч боловсруулалт 7.48 хувь буюу 799.2 мянган Гкал-оор тус тус өссөн байна.


*График 12. Дотоодын эрчим хүч үйлдвэрлэл, эх үүсвэрийн бүтэц /2018 он, хувиар/.*



Эх үүсвэр: ЭХЯ

Эрчим хүчиний системийн 2018 оны үйлдвэрлэл, борлуулалтын 80 хувийг дотоодын эх үүсвэр, 20 хувийг ОХУ болон БНХАУ-аас авсан импортын эрчим хүч эзэлж байна. Харин дотоодын үйлдвэрлэлийн 82.8 хувийг дулааны цахилгаан станц, 11.6 хувийг салхин цахилгаан станц, 2.63 хувийг нарны цахилгаан станц, 1.73 хувийг усан цахилгаан станцууд тус тус үйлдвэрлэсэн байна.

*График 13. Цахилгаан эрчим хүчиний нийт импорт /сая.кв.цаг/.*



Эх үүсвэр: УСХ

Эрчим хүчиний салбар 2018 оны эцсийн байдлаар зөвхөн уул уурхайн салбарт ашиглагдах цахилгаан эрчим хүчийг БНХАУ-аас 1,261.9 сая кВт.цагийг импортоор худалдаж авсан нь өмнөх оноос 3.7 хувиар өссөн байна. Цаашид уул уурхайн ашигт малтмалын олборлолт, үйлдвэрлэлт нэмэгдэх хандлагатай байгаагаас үзэхэд эрчим хүчиний хэрэглээ мөн адил өсөхөөр байна. Харин оргил ачааллын үед аж ахуй нэгж байгууллагууд болон айл өрхүүдийг тогтвортой цахилгаан эрчим хүчээр хангахын тулд 2018 онд ОХУ-аас 403.8 сая кВт.цагийг импортоор худалдаж авсан нь өмнөх оноос 12.8 хувиар өссөн дүн байна.

### 1.2.3. Зам, тээвэр

Эдийн засгийн өсөлтийг хангах зам, тээврийн сүлжээг өргөжүүлэн хөгжүүлэх, хэрэглэгчийн эрэлт хэрэгцээнд нийцсэн аюулгүй, ая тухтай үйлчилгээг үзүүлэх зорилгын хүрээнд авто зам, авто тээвэр, иргэний нисэх, төмөр зам, далай ашиглалт, усан замын тээврийн салбарыг хөгжүүлж байна.

Бүх төрлийн тээврээр 2018 онд 69.8 сая тонн ачаа, давхардсан тоогоор 200.4 сая зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оноос тээсэн ачаа 15.8 сая тонн буюу 29.4 хувиар, зорчигчид 15.3 сая буюу 7.07 хувиар буурсан байна.

**Авто зам.** Монгол Улс нийт 49,695 км авто замын сүлжээтэйгээс 15,244.5 км нь нийслэлийг аймгийн төвтэй, аймгийн төвийг хооронд нь болон хилийн боомттой холбосон улсын чанартай авто зам байна. Улсын чанартай авто замын сүлжээнд нийт 4,300 орчим км-ын 3 чиглэл (АН3, АН4, АН32)-ийн олон улсын чанартай авто зам байна.

Авто замын салбарт 2018 онд Улсын төсөв, Хөгжлийн банк, гадаад зээл, тусlamжийн хөрөнгө оруулалтаар нийт 17 чиглэлийн 1,119.1 км хатуу хучилттай авто зам, 7 байршилд 559.3 урт метр төмөрбетон гүүрний барилга болон их засварын ажлыг хийж гүйцэтгэлээ.

**Авто тээвэр.** Авто тээврийн салбар 2018 онд 44.1 сая тонн ачаа, давхардсан тоогоор 196.9 сая хүн тээвэрлэсэн нь өмнөх оноос тээсэн ачаа 12.9 сая тонн буюу 41.4 хувиар өсөж, харин зорчигчид 15.3 сая хүн буюу 7.3 хувиар буурсан байна. Авто тээврийн орлого 627.8 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 24.0 хувь буюу 121.4 тэрбум төгрөгөөр өссөн байна.

*График 14. Авто тээврээр тээсэн ачаа болон зорчигчдын тоо.*



Эх үүсвэр: УСХ

**Төмөр зам.** Монгол Улс нийт 1920 км төмөр замтай бөгөөд Булган, Орхон, Говь-Сүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Сэлэнгэ, Төв, Дорнод аймгуудын нутгаар дамжин өнгөрч байна.

Төмөр замын тээврээр 2018 онд 25.7 сая тонн ачаа, давхардсан тоогоор 2.6 сая зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оныхоос тээсэн ачаа 2.9 сая тонн буюу 12.9 хувиар өсөж, зорчигчид 64.4 мянган хүн буюу 2.4 хувиар буурсан байна.


*График 15. Төмөр замаар тээсэн ачаа болон зорчигчдын тоо.*



Төмөр замын тээврийн салбарын орлого 2018 онд 616.5 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 86.4 тэрбум төгрөг буюу 16.3 хувиар өссөн.

**Иргэний нисэх, агаарын тээвэр.** Агаарын тээврээр 2018 онд 3.1 мянган тонн ачаа, давхардсан тоогоор 0.9 сая зорчигч тээвэрлэж, өмнөх оноос тээсэн ачаа 2.02 хувиар өсч, зорчигчийн тоо 13.3 хувиар өссөн байна.

*График 16. Агаарын тээврийн ачаа болон зорчигчдын тоо.*



Монгол Улсын иргэний нисэхийн салбарт үйл ажиллагаа эрхэлж буй дотоодын 17 агаарын тээврийн компани байгаа бөгөөд эдгээр нь Монгол Улсад бүртгэлтэй 34, гадаад улсад бүртгэлтэй 4 агаарын хөлгөөр үйл ажиллагаа явуулж байна.

2018 оны байдлаар нислэгт тэнцэх чадварын гэрчилгээтэй агаарын хөлөг 16, олон улсын нисэх буудал 1, орон нутгийн нисэх буудал 21, нийт 15 агаарын хаалга, дээд агаарын зайн 37, доод агаарын зайн 45 агаарын замыг тус тус ашиглаж байна.

Олон улсын өнгөрөлтийн нислэгийн тоо 2018 оны жилийн эцсийн байдлаар 123,296-т хүрч, өнгөрсөн онтой харьцуулахад 12343 нислэг буюу 10 хувиар өссөн байна.

**Далайн тээвэр.** Далайн боомт ашиглалтын хүрээнд БНХАУ, ОХУ, Бүгд Найрамдах Итали Улсын худалдааны далайн боомтуудыг Монгол Улсын гадаад

худалдаанд ашиглах, өөрийн улсын бүтээгдэхүүнийг гуравдагч оронд нийлүүлэх нөхцөлийг бүрдүүлэхээр ажиллаж байна. Тухайлбал, Бүгд Найрамдах Итали Улсын Генуя боомтыг таатай нөхцөлөөр ашиглах талаар харилцан тохиролцоонд хүрээд байна.

БНХАУ-ын Тяньжин дэх Дунзяны эдийн засгийн чөлөөт бүсийн 10 га газарт тээвэр, логистик, үйлдвэрлэл, үйлчилгээний цогцолбор барьж ашиглах талаар Хятадын талтай тохиролцсон бөгөөд одоогоор төслийг “Монголын төмөр зам” ТӨХК 49 хувь, Хятадын тал 51 хувийн оролцоотойгоор хамтран хөрөнгө оруулалтыг шийдвэрлэхээр ажиллаж байна.

#### **1.2.4. Барилга, хот байгуулалт**

Барилга угсралт, их засварын ажил 2018 оны урьдчилсан гүйцэтгэлээр 3.7 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 19.9 хувь буюу 624.0 тэрбум төгрөгөөр өссөн байна. Нийт барилга угсралт, их засварын ажлын 84.6 хувийг дотоодын байгууллага, 15.4 хувийг гадаадын байгууллага гүйцэтгэсэн байна.

Барилга угсралт, их засварын ажлын 32 хувийг орон сууцны барилга, 37 хувийг орон сууцны бус барилга, 28 хувийг инженерийн барилга, байгууламж, 3 хувийг их засварын ажил эзэлж байна.

#### ***Хүснэгт 7. Барилга угсралт, их засварын ажлын хэмжээ /тэрбум төгрөг/.***

<b>Барилга</b>	<b>2014</b>	<b>2015</b>	<b>2016</b>	<b>2017</b>	<b>2018*</b>
Барилга угсралт, их засварын ажил, бүгд	2,750.8	2,837.8	3,084.8	3,130.7	3,754.7
Дотоодын байгууллага	2,559.6	2,628.9	2,871.3	2,944.6	3,175.1
Төрийн өмчийн байгууллага	63.2	46.0	30.5	55.1	93.1
Хувийн байгууллага	2,454.7	2,567.1	2,827.4	2,812.1	3,064.5
Гадаадтай хамтарсан байгууллага	41.7	15.9	13.4	77.3	17.4
Гадаадын байгууллага	191.2	208.8	213.5	186.1	579.5

Эх үүсвэр: УСХ

**Орон сууц.** Монгол Улсын нийт хүн амын 30.0 хувь нь инженерийн хангамжтай орон сууцанд, үлдсэн хэсэг нь инженерийн бус хангамжтай гэр хорооллын сууц, уламжлалт монгол гэрт амьдарч байна. Улсын хэмжээнд 2014 онд 22,546 айлын, 2015 онд 26,340 айлын, 2016 онд 15,923 айлын, 2017 онд 11,023 айлын, 2018 онд 11,161 айлын орон сууц тус ашиглалтад орсон байна.

Засгийн газрын 2013 оны 200 дугаар тогтоолоор “Орон сууцны ипотекийн зээлийн ерөнхий журам”-ыг баталж, мөн оны 6 дугаар сараас жилийн 8 хувийн хүүтэй, орон сууцны зээлийг орон сууц худалдан авах иргэдэд олгож эхэлсэн бөгөөд 2018 оны байдлаар ипотекийн зээлд хамрагдсан иргэдийн тоо 93,865-д хүрсний 82.9 хувь нь Улаанбаатар хотод, 17.1 хувь нь орон нутагт байна.

Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны 28 дугаар тушаалаар батлагдсан “Иргэдийг түрээсийн орон сууцад хамруулах журам”, ТОСК ТӨААТҮГ-ын ерөнхий захирлын 2016 оны А/21 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн түрээсийн орон сууцад иргэдийг бүртгэх, сонгон шалгаруулах, түрээсийн орон сууцад хамруулах ажлыг зохион байгуулах журам”-ын дагуу Улаанбаатар хотод 4,150, орон нутагт 2,222 иргэнд шаардлагатай мэдээллийг өгч, материалыг хүлээн авсан. Үүнээс Улаанбаатар хотод

шаардлага хангасан нийт 2,376 иргэн, орон нутагт шаардлага хангасан 929 иргэн, нийт 3,315 иргэн, айл өрхийг 2017 онд түрээсийн орон сууцанд хамруулсан.

**Хот байгуулалт.** “Аймаг бүрд 1000 айлын орон сууц” төслийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Булган, Өвөрхангай, Завхан, Дорнод, Хэнтий, Ховд, Баян-Өлгий, Дорноговь, Говьсүмбэр, Өмнөговь, Архангай, Баянхонгор, Дархан-Уул, Орхон, Дундговь, Сэлэнгэ, Төв, Хөвсгөл аймгийн төвүүдэд нийгмийн дэд бүтцийн хамт баригдах орон сууцны хорооллыг хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулаад байна.

Монгол Улсын хилээр дамжин гарах ачаа эргэлт нэмэгдсэнтэй холбогдуулан хилийн боомтын шинэчлэлийн хүрээнд Ханги, Бичигт, Бургастай, Булган, Ханх, Зэлтэр боомтуудын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, Гашуунсуухайт, Шивээхүрэн, Боршоо хилийн боомтуудын батлагдсан хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу эхний ээлжийн барилгажилтын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж батлуулах ажлыг үе шаттай зохион байгуулж байна. GNSS (GPS)-ийн байнгын ажиллагаатай 30 ширхэг станцыг аймгийн төв болон сум, суурин газруудад байгуулж улсын хэмжээнд нийтдээ 38 станц ажиллаж байна.

#### 1.2.5. Аялал жуулчлал


Монгол Улсад ирсэн гадаадын жуулчдын тоо 2018 оны жилийн эцсийн байдлаар 529.3 мянгад хүрсэн нь өмнөх онтой харьцуулахад 11.0 хувиар буюу 58.2 мянгаар өсөж, аялал жуулчлалын салбарын орлого 569 сая ам.долларт хүрсэн байна.

Монгол Улсад ирсэн гадаадын жуулчдыг тэргүүлэх 10 улсаар нь авч үзвэл нийт жуулчдын 38 хувийг Хятад, 18 хувийг Орос, 12 хувийг Солонгос, 5 хувийг Япон эзэлж үлдсэн хувийг Америк, Казакстан, Герман, Франц, Их Британи, Австрали зэрэг улсууд бүрдүүлж байна.

Дэлхийн эдийн засгийн форумаас гаргадаг “Аялал жуулчлалын өрсөлдөх чадварын индекс” үзүүлэлтээр Монгол Улс 141 орноос 102 дүгээр байранд эрэмбэлэгдэж байна.

Улсын хэмжээнд 2018 оны байдлаар нийт 310 аялал жуулчлалын компани, 501 зочид буудал, 574 жуулчны бааз үйл ажиллагаа явуулж, тус салбараас 58.0 мянган ажлын байрыг бий болгосон нь нийт ажлын байрны 4.9 хувийг бүрдүүлсэн байна.

*График 17. Жуулчдын тоо /мянган хүн/.*



Эх үүсвэр: УСХ

Монгол Улсад агаарын тээврийн чиглэлээр МИАТ, ХҮННҮ Эйр, Аэро Монголиа зэрэг түрван үндэсний авиа компаниуд үйл ажиллагаа явуулж, Берлин, Франкфурт, Бээжин, Станбул, Бусан, Сөүл, Москва, Токио, Хонгконг, Эрхүү, Хөх хот, Манжуур, Хайлаар, Бишкек, Тианьжин зэрэг нийт 15 чиглэлд тогтмол нислэгтэй бөгөөд Хайнань, Чежу, Бангкок зэрэг чиглэлүүдэд тогтсон хуваарийн дагуу чarter нислэг үйлдэж байна.

### **1.2.6. Мэдээлэл, шуудан, харилцаа холбоо**

Мэдээлэл, харилцаа холбооны салбарын хэмжээнд шуудангийн үндсэн сүлжээг бий болгох, үндсэн сүлжээний дамжуулах чадварыг сайжруулж, сүлжээгээр дамжих уламжлалт үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлж мэдээллийн технологид тулгуурласан шинэ нэр төрлийн үйлчилгээ, хэрэглээг нэвтрүүлэх, шуудангийн үйлчилгээг хүртээмжтэй, шуурхай, найдвартай хүргэх боломжийг бий болгох зорилготой “Өрх бүрд шуудан” хөтөлбөр (2010-2020), мэдээлэл, харилцаа холбооны дэвшлийг бүх нийтийн хүртээл болгох, мэдлэг шингэсэн өндөр технологи, экспортын чиг баримжаатай үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх, хүний хөгжлийг дэмжих, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх замаар Монгол Улсын хөгжлийг хурдаасгах зорилготой “Төрөөс мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлого” (2017-2025)-ыг хэрэгжүүлж байна.

Монгол Улсын мэдээлэл харилцаа, холбооны шилэн кабелийн сүлжээний нийт урт 2018 оны жилийн эцсийн байдлаар 38.4 мянган км болж, 21 аймгийн 312 сум шилэн кабельд холбогдоо.

*Хүснэгт 8. Харилцаа холбооны салбарын үндсэн үзүүлэлт.*

Үзүүлэлтүүд	2014	2015	2016	2017	2018
Нийт орлого (тэрбум төгрөг)	740.3	724.6	764.4	805.8	959.9
Хүн амаас орсон орлого (тэрбум төгрөг)	532.4	538.1	548.0	530.7	614.8
Суурин утасны цэгийн тоо (мянган ширхэг)	226.4	258.9	287.7	313.4	331.4
Үүрэн утас хэрэглэгчдийн тоо (сая хүн, давхардсан тоогоор)	3.0	3.0	3.2	3.9	4.2*
Кабелийн телевиз хэрэглэгчдийн тоо (мянган хүн)	360.9	384.4	418.4	487.2	459.1
Хүргэсэн бичиг, захидал (мянган ширхэг)	672.4	1,032.8	1,246.1	1,585.8	1,530.6

*Эх үүсвэр. Үндэсний статистикийн хороо*

Шуудан, холбооны салбарын орлого 2018 онд 959.9 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 19.1 хувь буюу 154.1 тэрбум төгрөгөөр, 2014 оноос 29.7 хувь буюу 219.6 тэрбум төгрөгөөр өссөн байна. Хүн амаас орсон орлого 2018 онд 614.8 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 15.8 хувь буюу 84.1 тэрбум төгрөгөөр, 2014 оноос 15.5 хувь буюу 82.4 тэрбум төгрөгөөр өсжээ.

Суурин утасны цэгийн тоо 2018 онд 331.4 мянга болж, 2017 оноос 5.7 хувь буюу 18.0 мянгаар, 2014 оноос 46.4 хувь буюу 105.0 мянгаар өссөн байна. Үүрэн утас хэрэглэгчдийн тоо 2018 оны урьдчилсан гүйцэтгэлээр давхардсан дунгээр 4.2 саяд хүрч, 2017 оноос 7.7 хувь буюу 300.0 мянган хүнээр, 2014 оноос 40.0 хувь буюу 1.2 сая хүнээр өссөн байна.

Кабелийн телевиз хэрэглэгчдийн тоо 2018 онд 459.1 мянга болж, өмнөх оноос 5.7 хувь буюу 28.1 мянгаар буурсан бол 2014 оноос 27.2 хувь буюу 98.2 мянгаар өссөн

байна. Орон нутагт IPTV нэвтэрсэн нь кабелийн телевиз хэрэглэгчдийн тоо буурах үндсэн шалтгаан болсон.

Шуудангийн үйлчилгээний үзүүлэлтээс хүргэсэн бичиг, захидал 2018 онд 1.53 сая ширхэг болж 2017 оноос 3.5 хувь буюу 55.2 мянгаар буурсан бол 2014 оноос 3.3 дахин буюу 858.2 мянгаар нэмэгджээ.

**ХҮР төрийн мэдээлэл солилцооны систем.** Захиргааны байгууллага хооронд цахим мэдээлэл солилцох үйл ажиллагааны хүрээнд төрийн цахим мэдээллийн санг бүрдүүлэх, ашиглах, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах, найдвартай ажиллагааг хангах, төрийн үйлчилгээг иргэн, байгууллагад цахим хэлбэрээр шуурхай хүргэх зорилгоор Засгийн газрын 2017 оны 159 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн цахим мэдээллийн санг бүрдүүлэх, ашиглах журам”-ын хэрэгжилтийг хангах хүрээнд “ХҮР” төрийн мэдээлэл солилцооны системийг “Үндэсний дата төв” УТҮГ-аас боловсруулан 2017 оноос үйл ажиллагаанд нэвтрүүлж, 2018 оны байдлаар нийт 84 сервисийг хөгжүүлээд байна. Энэ системд иргэнд үйлчилгээ үзүүлж байгаа төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд холбогдох боломжтой бөгөөд 2018 оны байдлаар төрийн 28, хувийн 40 байгууллагад хандах эрхийг олгосон.

Засгийн газрын 2018 оны “Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэх зарим арга хэмжээний тухай” 259 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар төрийн цахим мэдээлэл солилцооны системд холбох боломжтой 176 үйлчилгээ, 2 дугаар хавсралтаар тус системийг ашиглан цахим хэлбэрээр үзүүлэх боломжтой 320 үйлчилгээ, нийт 496 төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэх жагсаалтад хамруулснаас 168 үйлчилгээг Төрийн мэдээлэл солилцооны [www.service.gov.mn](http://www.service.gov.mn) системээр иргэдээд үзүүлж байна.

**Төрийн цахим ой санамж ба нээлттэй өгөгдөл.** Төрийн цахим ой санамж нь өдрөөс өдөрт нэмэгдэж байгаа мэдээлэл, өгөгдлийг ашиглан судалгаа тооцоотой, цогц шийдвэр гаргах өргөн боломжийг олгодог. Эдийн засгийн салбаруудын төрөлжсөн мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг сүүлийн жилүүдэд эрчимтэй гүйцэтгэж 2018 оны жилийн эцсийн байдлаар гаалийн мэдээллийн сан, оюуны өмч, оюуны үнэт зүйлийн мэдээллийн сан, гадаадын зээл, тусламжийн мэдээллийн сан, газар зүйн мэдээллийн сан, банк, зээлийн мэдээллийн сан зэрэг суурь болон төрөлжсөн өгөгдлийн 23 санг бүрдүүлсэн.

**Төрийн бодлого, шийдвэр дэх иргэдийн цахим оролцоо.** Манай улсын иргэд болон шийдвэр гаргах түвшний оролцогчдыг шаардлагатай үед нээлттэй мэдээллээр хангах, хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор [www.legalinfo.mn](http://www.legalinfo.mn) эрх зүйн мэдээллийн систем, иргэдийг төрийн үйлчилгээ болон бодлогын хэлэлцүүлэгт татан оролцуулах, хуулийн төслүүдэд иргэд, иргэний нийгмийн байгууллага, сонирхлын бүлгүүдийн саналыг авах, нэгтгэх, тусгах, эргэн тайлагнах, харилцан мэдээлэл солилцох зорилгоор [www.forum.parliament.mn](http://www.forum.parliament.mn) цахим хэлэлцүүлгийн систем, төрийн үйлчилгээний агуулгыг шинэчлэх шийдвэр гаргах, оролцоог нэмэгдүүлэх зорилгоор [www.11-11.mn](http://www.11-11.mn) цахим системийг ажиллуулж байна.

Төрийн алба, үйлчилгээг шуурхай, ил тод, хэмнэлттэй болгох, төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээ, системийг сайжруулах, иргэний мэдээлэл авах, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө болон түүний хувийн мэдээллийн өгөгдлийн нууцыг хамгаалах, цахим мэдээллийн аюулгүй байдлыг хангах, мэдээлэл, харилцаа холбооны технологид суурилсан үндэсний үйлдвэрлэл, үйлчилгээг нэмэгдүүлэх, үндэсний мэдээллийн дэд бүтцийг хамгаалах чадавх бий болгох, энэ чиглэлээр

мэргэшсэн хүний нөөцийг бэлтгэх, давтан сургах тогтолцоог боловсронгуй болгох, цахим бодлогын асуудлыг судалж, санал боловсруулах үүрэг бүхий Цахим бодлогын түр хороог Улсын Их Хурлын 2018 оны 38 дугаар тогтоолоор байгуулан ажиллаж байна.

Засгийн газрын 2018 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн 30 дугаар тогтоолоор “Төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээг ашиглах журам”, “Тусгай хэрэглээний мэдээлэл, холбооны сүлжээ байгуулах, ашиглах журам”, 2018 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн “Төрийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах зарим арга хэмжээний тухай” 138 дугаар тогтоол батлагдсан.

### 1.3. ХҮНИЙ ХӨГЖИЛ

#### 1.3.1. Хүний хөгжил

Монгол Улсын хүн ам 2018 оны эцэст урьдчилсан дүнгээр 3,239.5 сая болж, өмнөх оноос 61.6 мянган хүнээр буюу 1.9 хувиар өслөө. Улсын хэмжээнд 2018 оны байдлаар 78993 хүүхэд төрсний 77528 хүүхэд буюу 98.1 хувь нь Монгол Улсад, 1465 хүүхэд буюу 1.9 хувь нь гадаадад төрсөн байна.

**Хүүхдийн хөгжил.** Монгол Улсын нийт хүн амын 36.2 хувийг 0-18 хүртэл насныхан эзэлж байна. Нийт хүүхдийн дунд бүтэн өнчин 3383 хүүхэд, хүүхдийн асрамж, халамжийн төвд 1060 хүүхэд, хараа хяналтгүй 57 хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй 11453 хүүхэд байна. 2018 онд гэмт хэргийн улмаас хохирсон нийт 1688 хүүхэд, хүүхэд оролцсон гэмт хэрэг 741, гэмт хэргийн улмаас хохирч амь насаа алдсан 88 хүүхэд, бэлгийн хүчирхийллийн хохирогч 235 хүүхэд, хурдан морины уралдааны явцад мориноос унаж хөгжлийн бэрхшээлтэй болсон 2, амь насаа алдсан 2 хүүхэд бүртгэгдсэн байна.

Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд эрсдэлт нөхцөл байдалд байгаа хүүхдэд нөхцөл байдлын үнэлгээ хийх, нийгмийн ажилтны ёс зүйн дүрэм, хүүхдийн асуудлаарх мэдээллийн сан бий болгох, хүүхдийн эрхийн улсын байцаагчийн болон Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны ажиллах журам, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэгчдийг магадлан итгэмжлэхтэй холбоотой 12 дүрэм, журам, 3 стандартыг батлан хэрэгжүүллээ.

Мөн гэр бүл, нийгмийн хүрээнд хүүхэдтэй зүй бус харьцах, хүүхдийн эсрэг хүчирхийлэл, хүүхдийг эрсдэлт нөхцөлд орохоос урьдчилан сэргийлэх зорилгоор Хүүхэд хамгааллын бодлогын жишиг баримт бичиг батлан хэрэгжүүллэв.

Хүүхдийн эрх, аюулгүй байдлыг хангах тухай Засгийн газрын 2018 оны 01 дүгээр албан даалгавраар Засгийн газрын гишүүд, холбогдох агентлаг, бүх шатны Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хурал, төрийн болон төрийн бус байгууллагуудад хүүхдийг аливаа осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, аюулгүй ажиллагааны стандарт, шаардлагыг мөрдүүлэх чиглэлээр шаардлагатай арга хэмжээ авч хэрэгжүүлэх үүрэг чиглэл өгч ажиллалаа.

Хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэх хүрээнд Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дэргэд “Хүүхдийн тусlamжийн 108 утасны үйлчилгээний төв”, “Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ түр хамгаалах байр, “Сургалт, судалгаа, мэдээллийн төв”-үүд ажиллаж байна. Хүүхдийн тусlamжийн 108 утасны үйлчилгээний төвд 2018 оны байдлаар нийт 166407 дуудлага хүлээн авч, утсаар анхан шатны нийгэм сэтгэл зүйн тусlamж, үйлчилгээг үзүүллээ.

**Залуучуудын хөгжил.** Монгол Улсын нийт хүн амын 33.7 хувийг 15-34 насны залуучууд эзэлж байна. Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль 2018 оны 01 сарын 01-ний өдрөөс хэрэгжиж байна. Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд Залуучуудын хөгжлийг дэмжих дэд хөтөлбөрийг 16 аймаг, 2 дүүрэгт батлан хэрэгжүүлж байна.

Залуучуудын хөгжлийн 16 төвийг 2018 онд шинээр байгуулж, улсын хэмжээнд нийт 32 төвөөр 7 нэр төрлийн үйлчилгээг залуучуудад үзүүлж байна. 2018 онд дээрх төвүүдээр 116 хүнд ганцаарчилсан зөвлөгөө, 2181 иргэнд бүлгээр зөвлөгөө өгч, 4485 иргэнийг тулгамдсан асуудлаар, тухайлбал, ажлын байранд 2,684, байнгын ажлын байранд 843, сургалтад 919, хөнгөлөлттэй зээлд 6, төсөл хөтөлбөрт 25, халамжийн үйлчилгээнд 8 иргэнийг зуучиллаа. Мөн залуучуудын гарааны бизнесийг дэмжих чиглэлээр 74 багт 569 сая төгрөгийн буцалтгүй болон эргэн төлөх нөхцөлтэй тусlamж, дэмжлэгийг үзүүллээ.

**Ахмад настан.** Монгол Улсын нийт хүн амын 6.5 хувь буюу 20 хүн тутмын нэг нь 60-аас дээш насны өндөр настнууд байна. Одоогоор “хүн ам зүйн цонх үе” үргэлжилж байгаа боловч хүн амын насжих үйл явц аажмаар эхэлж байна.

Ахмад настны тухай хуулийн шинэчилсэн найруулгыг УИХ-аар 2017 онд баталсан бөгөөд энэ хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд 5 журам баталсан. Мөн хөдөлмөрийн чадамжтай ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор тэтгэврийн бус орлогыг нь нэмэгдүүлэх чиглэлээр “Ахмадын зөвлөх үйлчилгээ” төслийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас хэрэгжүүллээ.

“Хүн амын насжилтын асуудлаарх үндэсний стратеги 2009-2030”-ийг хэрэгжүүлэх гурав дахь шатны буюу 2019-2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг боловсруулаад байна.

**Хөгжлийн бэрхшээлтэй иргэн.** Засгийн газрын 2018 оны 250 дугаар тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрыг байгууллаа.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалаар батлан хэрэгжүүллээ.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжихэд төрийн бус байгууллагуудын санаачилгыг дэмжин, хамтран ажиллаж 2018 онд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих чиглэлээр 12 байгууллагатай гэрээ байгуулан 120.7 сая төгрөгийн санхүүжилтийг олгож, 1300 гаруй хүнд холбогдох хууль тогтоомжийн талаарх мэдээллийг хүргэж, 1000 гаруй хүнийг урлаг соёлын арга хэмжээнд хамруулан 60 байгууллагад хүртээмжийн үнэлгээ хийллээ.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлаар олон улсын байгууллага, төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд, БНХАУ-ын буцалтгүй тусlamжаар 250 хүүхдийг хэвтэн эмчлүүлэх, 250 хүүхдэд өдрөөр сэргээн засах үйлчилгээ үзүүлэх “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн төв”-ийн төслийг хэрэгжүүлж, 2019 оны 01 дүгээр сард төвийн барилгын ажлыг хүлээн авлаа.

Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжих “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүргэх үйлчилгээг сайжруулах, оролцоог нэмэгдүүлэх” төслийг УИХ-аар батлууллаа. БНХАУ-ын Засгийн газрын буцалтгүй тусlamжаар 20.4 сая ам долларын

өртөгтэй “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн спорт цогцолборын ордон” барих ажлыг эхлүүлэхээр ажиллаж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх тоо мэдээлэл, үзүүлэлтийн зөрүүтэй байдлыг арилгах, мэдээллийн чанарыг сайжруулах зорилгоор мэдээллийн сан байгуулах үзлэг, тооллогыг Үндэсний статистикийн хороотой хамтран зохион байгуулж байна.

Ерөнхий сайдын 2018 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 107 дугаар захирамжаар Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх Ази, номхон далайн бүсийн 4 дүгээр Конгрессыг зохион байгуулах хороог байгуулан ажиллаж байна.

### 1.3.2. Хөдөлмөр эрхлэлт

Манай улсад 2018 оны 4 дүгээр улирлын байдлаар 15 ба түүнээс дээш наасны 2.2 сая хүн байгаагийн 61.9 хувь нь эдийн засгийн идэвхитэй хүн ам, 38.1 хувь нь эдийн засгийн идэвхигүй хүн ам байна. Хөдөлмөр эрхлэлтийн түвшин 57.8 хувь, ажилгүйдлийн түвшин 6.6 хувьтай байна.

#### Хүснэгт 9. Хөдөлмөр эрхлэлтийн үндсэн үзүүлэлтүүд.

Үзүүлэлт	2014.IY	2015.IY	2016.IY	2017.IY	2018.IY
15 ба түүнээс дээш наасны хүн ам	1870.2	1925.6	2053.9	2189.9	2173.0
Эдийн засгийн идэвхтэй хүн ам	1127.7	1164.1	1239.8	1367.3	1345.3
Ажиллагчид	1040.7	1067.6	1132.8	1266.9	1256.3
Ажилгүй иргэд	87.0	96.5	1070.0	100.3	88.9
Эдийн засгийн идэвхгүй хүн ам	742.5	761.5	814.0	822.7	827.8
Ажиллах хүчний оролцооны түвшин, хувь	60.3	60.5	60.4	62.4	61.9
Хөдөлмөр эрхлэлтийн түвшин, хувь	55.6	55.4	55.2	57.9	57.8
Ажилгүйдлийн түвшин, хувь	7.7	8.3	8.6	7.3	6.6

Эх үүсвэр: YCX

2018 онд Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөр 6 хөтөлбөр, 2 төслийг тус тус батлан хэрэгжүүлэв. Эдгээр хөтөлбөр, төсөл арга хэмжээнд 48.9 мянган хүн хамрагдаж, 22.2 мянган гаруй ажлын байр бий болсон байна.

**Цалин.** Үндэсний статистикийн хорооны тайлан мэдээгээр аж ахуйн нэгж, байгууллагад ажиллагчдын сарын дундаж цалин 2018 оны 4 дүгээр улирлын байдлаар 1120.3 мянган төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 7.8 хувиар өссөн байна.

Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хорооны 2018 оны 5 дугаар тогтоолоор хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2019 оны 01 дүгээр сарын 01-нээс сард 320 мянган төгрөгөөр тогтоов.

Монгол улсын Засгийн газрын 2018 оны “Төрийн зарим албан тушаалын цалингийн сүлжээ, доод жишигийг шинэчлэн тогтоох тухай” 264 дүгээр тогтоолоор багш, эмч нарын албан тушаалын цалингийн доод жишигтэй тэнцүү буюу бага цалинтай 173.1 мянган төрийн албан хаагчдын албан тушаалын цалингийн сүлжээ, доод жишигийг 2018 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс 8.0 хувиар нэмэгдүүлэн тогтоосноор төрийн албан хаагчдын сарын дундаж цалин хөлс 804.0 мянган төгрөгт хүрлээ.

2017-2018 онд эрүүл мэнд, боловсролын салбарт хийсэн ажлын байрны үнэлгээг үндэслэн Засгийн газрын 2018 оны “Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 263 дугаар тогтоолоор 7.7 мянган сувилагч, 16.3 мянган бага ангийн болон цэцэрлэгийн багш, соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний 4.0 мянган ажилтны албан тушаалын зэрэглэлийг ахиулан шинэчлэн тогтоолоо. Төрийн үйлчилгээний


албан тушаалын зэрэглэлийн шинэчлэлээр сувилагч нарын цалин 20.0-30.0 хувиар, бага ангийн болон цэцэрлэгийн багш нарын цалин 12.3 хувиар, соёл урлагийн ажилтнуудын цалин 14.0-32.0 хувиар тус тус нэмэгдсэн.

Уул уурхай, барилга, барилгын материалын салбарт ажлын байранд суурилсан цалин хөлсний тогтолцоог нэвтрүүлэх зорилгоор Багануур, Адуунчулуун, Шарын гол, Баянтээгийн нүүрсний уурхай болон “Хөтөл шохой” ХК цементийн үйлдвэрлэл, нийтийн хоол үйлдвэрлэлийн салбарт ажлын байрыг үнэлэн цалин тогтоох арга зүйг боловсруулан ажлын байрыг үнэллээ.

### 1.3.3. Ядуурал

Өрхийн нийгэм, эдийн засгийн 2016 оны судалгааны дүнгээр Монгол Улсын хүн амын ядуурлын түвшин буюу ядуурлын хамралтын хүрээ 29.6 хувь болсон бөгөөд 907.5 мянган хүн ядууралд өртсөн байна. Өөрөөр хэлбэл, 100 хүн тутмын 30 нь зайлшгүй шаардлагатай хүнсний болон хүнсний бус хэрэглээний зүйлийг худалдан авах чадваргүй байна.

*График 18. Ядуурлын хамралтын хүрээ.*



Эх үүсвэр: УСХ

Ядуурлын түвшин 2011 оноос хойш тасралтгүй буурч байсан бол 2016 онд 29.6 болж 2014 оныхоос 8.0 пунктээр өссөн байна. Ядуурлын хамралтын хүрээ 2016 оны байдлаар хотод 27.1, хөдөөд 34.9 байгаа бол бүсийн хувьд зүүн бүс хамгийн өндөр буюу 43.9, баруун бүс 36.0, хангай бүс 33.6, төвийн бүс 26.8, Улаанбаатар 24.8 хувьтай байна.

Улаанбаатар хот болон Төвийн бүсэд ядуурал хамгийн бага буюу тухайн орон нутгийн нийт хүн амын 24.8-26.8 хувь нь ядуу байна. Баруун, Хангай болон Зүүн бүсэд ядуурлын хамралтын хүрээ хамгийн өндөр буюу тухайн орон нутгийн нийт хүн амын 33.6-43.9 хувь нь ядуу байна. Улаанбаатар хотод ядуурлын хамралтын хүрээ хамгийн бага буюу 24.8 хувь байгаа боловч бусад бүсүүдтэй харьцуулахад хамгийн их ядуу хүн ам буюу 343.1 мянган хүн байна.

### 1.3.4. Нийгмийн даатгал

Өнөөгийн Монгол Улсын нийгмийн даатгалын тогтолцоо нь иргэдийг урт наслах, өвчлөх, хөдөлмөрийн чадвараа алдах, эрүүл мэндээрээ хохирох, ажилгүй болох, тэжээгчээ алдах тохиолдолд тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгох зорилго бүхий тэтгэврийн, тэтгэмжийн, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний, ажилгүйдлийн, эрүүл мэндийн даатгалын гэсэн 5 төрлийн сангаас бүрдэж байна.

Нийгмийн даатгалын сангийн орлогын хэмжээ 2018 онд 2014 оны түвшигээс 2 дахин, зарлага 39.7 хувиар тус тус өссөн байна.

*Хүснэгт 10. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага /тэрбум төгрөгөөр/.*

Нийгмийн даатгалын сан	2015 он		2016 он		2017 он		2018 он	
	Орлого	Зарлага	Орлого	Зарлага	Орлого	Зарлага	Орлого	Зарлага
<b>НИЙТ</b>	<b>1,187.9</b>	<b>1,507.4</b>	<b>1,315.1</b>	<b>1,695.6</b>	<b>1,548.6</b>	<b>1,890.2</b>	<b>2,061.3</b>	<b>1,795.2</b>
Тэтгэврийн	719.1	1,171.8	767.8	1,303.9	877.6	1,416.7	1,684.8	1,619.5
Тэтгэмжийн	81.1	87.0	86.9	92.3	109.0	100.3	136.4	112.2
ҮОМШӨ-ний	109.8	30.1	125.2	29.3	147.6	44.1	181.5	29.1
Ажилгүйдлийн	29.8	22.4	32.5	31.6	43.9	35.2	43.6	34.4
<b>ЭМД-ын</b>	<b>248.1</b>	<b>196.1</b>	<b>302.7</b>	<b>238.5</b>	<b>370.5</b>	<b>293.9</b>	<b>422.3</b>	<b>311.7</b>

Эх үүсвэр: YCX

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан тэтгэвэр, тэтгэмжийг үе шаттайгаар нэмэгдүүлэх зорилтын хүрээнд инфляцийн түвшинтэй уялдуулан Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийг 2018 оны 2 дугаар сарын 01-ний өдрөөс нэмэгдүүлсэн. Уг арга хэмжээний хүрээнд 393 мянган тэтгэвэр авагчийн тэтгэврийг 27-29 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, бүрэн тэтгэврийн доод хэмжээг 280 мянган төгрөгөөр, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээг 243 мянган төгрөгөөр тус тус шинэчлэн тогтоосон.

*Хүснэгт 11. Нийгмийн даатгалын сангаас олгож байгаа тэтгэврийн дундаж, доод хэмжээ /мянган төгрөг/.*

Үзүүлэлт	2014.02	2015.02	2016.06	2018.02	2019.02
Хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээ	172.2	195.0	216.0	243.0	270.0
Бүрэн тэтгэврийн доод хэмжээ	207.3	230.0	251.0	280.0	310.0
Дундаж тэтгэвэр	254.1	283.0	310.7	342.8	372.5

Эх үүсвэр: YCX

Нийгмийн даатгалын багц хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийг байгуулж, Нийгмийн даатгалын багц хуулийн төслийн хүрээнд Нийгмийн даатгалын тухай хуулийн, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн, Хувийн тэтгэврийн нэмэлт даатгалын тухай хуулийн үзэл баримтлалыг 2018 оны 8 дугаар сард батлуулан ажиллалаа.

Гадаад улсад ажиллаж, амьдарч буй Монгол Улсынхаа иргэдийн нийгмийн баталгааг хангах ажлын хүрээнд Бүгд Найрамдах Польш Улс, Бүгд Найрамдах Турк Улстай байгуулсан нийгмийн хамгааллын хэлэлцээрүүдийг 2018 онд УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар соёрхон батлууллаа. Энэхүү нийгмийн хамгааллын хэлэлцээрийг байгуулснаар Польш болон Турк улсад ажил хөдөлмөр эрхэлж буй 5.0 мянга гаруй монгол иргэдийн хоёр улсад шимтгэл төлсөн хугацааг нэгтгэн тооцож, өндөр наасны тэтгэвэр тогтоох, зарим богино хугацааны тэтгэмж авах боломжийг бүрдүүлэв.

### 1.3.5. Нийгмийн халамж

Нийгмийн халамжийн тухай хууль тогтоомжид 2000, 2008 онд нэмэлт өөрчлөлт оруулж, 1998, 2005, 2012 онд шинэчилсэн найруулга хийсэн юм. Мөн Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг 2016 онд, Ахмад настны тухай, Алдар цолтой ахмад настанд нэмэгдэл, хөнгөлөлт олгох тухай хуулиудыг 2017 онд шинэчилсэн


найруулгаар, Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хуулийг шинээр тус тус баталсан. Одоогоор нийгмийн халамж, хүн амын өсөлтийг дэмжих чиглэлийн 6 хууль хүчин төгөлдөр үйлчилж байна.

2018 оны оны байдлаар 619.7 тэрбум төгрөгийг нийгмийн халамжийн арга хэмжээнд зарцуулснаас хүүхдийн мөнгийг оролцуулахгүйгээр нийгмийн халамжийн үйлчилгээнд 410.7 тэрбум төгрөгийг зарцуулжээ. Өнгөрсөн онтой харьцуулахад нийгмийн халамжийн зардал нэмэгдсэн нь эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох хууль 2018 оноос хэрэгжиж 96.8 тэрбум төгрөг, нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн нэмэгдэлд 17.6 тэрбум төгрөг, 2017 онд баталсан Ахмад настны тухай хуульд заасан шинэ төрлийн үйлчилгээг хэрэгжүүлэхэд 1.1 тэрбум, АИХ-ын депутатуудад нэмэгдэл, хөнгөлөлт олгоход 428.4 сая төгрөг тус тус нэмж зарцуулсан нь голлон нөлөөлсөн байна.

### 1.3.6. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спорт

**Сургуулийн өмнөх боловсрол.** Улсын хэмжээнд 2017-2018 оны хичээлийн жилд 1,416 цэцэрлэгт 256.7 мянган хүүхэд хамрагдаж байсан бол 2018-2019 оны хичээлийн жилд 1,435 цэцэрлэгт 261.3 мянган хүүхэд хамрагдаж сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтын бохир жин 83.6 хувьд хүрсэн байна. Улсын хэмжээнд 2017-2018 оны хичээлийн жилд сургуулийн өмнөх боловсролын буюу 2-5 насны хүүхдийн тоо 310.1 мянга байсан бол 2018-2019 оны хичээлийн жилд 312.6 мянга болж 0.8 хувь буюу 2.5 мянган хүүхдээр өссөн байна.

График 19. Сургуулийн өмнөх боловсролын хамрагдалтын тоо.



Эх үүсвэр: Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам

Сургуулийн өмнөх боловсролын 1,435 байгууллагын 62 хувь буюу 889 нь төрийн өмчийн байгууллага бөгөөд үүнд нийт сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж байгаа хүүхдийн 84.9 хувь нь хамрагдаж байна. Төрийн өмчийн цэцэрлэгийн тоо 2018-2019 оны хичээлийн жилд өмнөх оноос 11 цэцэрлэгээр нэмэгдсэн бол хувийн өмчийн цэцэрлэгийн тоо 8-аар нэмэгдэж 546 болсон байна. Улсын хэмжээнд 2018-2019 оны хичээлийн жилд сургуулийн өмнөх боловсролын байгууллагын бүлэг дүүргэлт<sup>2</sup> дунджаар 33.1 байгаа нь өмнөх жилээс 0.2-оор өссөн байна. Төрийн цэцэрлэгт үндсэн сургалтын бүлэг дүүргэлт 36.9 байгаа бол хувийн цэцэрлэгийн үндсэн сургалтын бүлэг дүүргэлт 22.6-тай байна.

<sup>2</sup> “Бүлэг дүүргэлт” нэг бүлэгт суралцаж байгаа хүүхдийн дундаж тоог хэлнэ.

Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад улсын хэмжээнд 27,214 багш, ажиллагчид ажиллаж байгаагаас 7,843 буюу 28.8 хувийг үндсэн багш эзэлж байгаа бол туслах багшийн тоо 6,673 байна. Нийт багш, ажиллагчдын тоо өмнөх оноос 42-оор буюу 0.2 хувиар өссөнөөс, үндсэн багш 98-аар, туслах багш 297-оор нэмэгдсэн байна.

**Ерөнхий боловсрол.** 2017-2018 оны хичээлийн жилд улсын хэмжээнд ерөнхий боловсролын 798 сургууль байсан бол 2018-2019 оны хичээлийн жилд 803 болж өсөж тэдгээрийн 69.5 хувь буюу 558 нь хөдөөд, 30.5 хувь буюу 245 нь нийслэлд байршиж байна. Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн тоо 2018-2019 оны хичээлийн жилд 656 байгаа нь өмнөх оноос 4 сургуулиар нэмэгдсэн бол хувийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн тоо мөн үед 1-ээр нэмэгдсэн байна. Нийт ерөнхий боловсролын сургуулийн 81.6 хувь нь төрийн өмчийн бөгөөд нийт суралцагчдын 93.3 хувь нь төрийн өмчийн сургуульд хамрагдаж байна. Нийт суралцагчдын тоо 2018-2019 оны хичээлийн жилд өмнөх оныхоос 3.5 хувиар өссөн бөгөөд бага ангийн суралцагчдын тоо 5.8 хувь, дунд ангийн 4.5 хувиар тус тус өссөн бол ахлах ангийн суралцагчдын тоо 5.7 хувиар буурсан байна.

#### Хүснэгт 12. Ерөнхий боловсролын сургууль болон суралцагчийн тоо.

Үзүүлэлт		2014-2015	2015-2016	2016-2017	2017-2018	2018-2019
<b>Сургуулийн тоо</b>		<b>762.0</b>	<b>768.0</b>	<b>778.0</b>	<b>798.0</b>	<b>803.0</b>
Өмчийн	Төрийн	628.0	636.0	645.0	652.0	656.0
хэлбэр	Хувийн	134.0	132.0	133.0	146.0	147.0
Байршил	Хот	214.0	215.0	226.0	241.0	245.0
	Хөдөө	548.0	553.0	552.0	557.0	558.0
<b>Суралцагчдын тоо</b>		<b>505.8</b>	<b>535.0</b>	<b>551.9</b>	<b>572.7</b>	<b>593.1</b>
Өдрийн анги	Төрийн	476.6	504.0	520.2	537.7	553.5
	Хувийн	29.1	30.9.0	31.7	35.0	39.6

Эх үүсвэр: Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам

Ерөнхий боловсролын сургуульд 2018-2019 оны хичээлийн жилд 20.5 мянган бүлэг хичээллэж байна. Бүлгийн тоо өнгөрсөн хичээлийн жилээс нийт 1.7 хувиар буюу бага ангийн бүлэг 2.9 хувь, дунд анги 2.9 хувиар тус тус өссөн бол ахлах ангийн бүлэг 3.8 хувиар буурсан байна. Нийт бүлгийн 64.3 хувь буюу 13.2 мянган бүлэг нэгдүгээр ээлжид, 34.6 хувь буюу 7.1 мянган бүлэг хоёрдугаар ээлжид, 1.0 хувь буюу 203 бүлэг гуравдугаар ээлжид хичээллэж байна. Улсын хэмжээнд 25 сургуулийн 203 бүлгийн 8,068 суралцагч гуравдугаар ээлжээр хичээллэж байгаагийн 85.4 хувь нь бага ангийн, 11.8 хувь нь дунд ангийн, 2.8 хувь нь ахлах ангийн бүлэг байна.

#### Хүснэгт 13. Ерөнхий боловсролын сургуулийн бүлэг, анги болон ээлжээр.

Үзүүлэлт	Бүлгийн тоо								
	Бүгд	Бага	Дунд	Ахлах	Бүгд	1-р ээлж	2-р ээлж	3-р ээлж	
2014-2015	<b>18,521</b>	9,132	5,739	3,650	<b>18,521</b>	11,734	6,630	157	
2015-2016	<b>19,304</b>	9,554	5,429	4,321	<b>19,304</b>	12,058	7,071	175	
2016-2017	<b>19,677</b>	9,795	6,171	3,711	<b>19,677</b>	12,215	7,238	224	
2017-2018	<b>20,211</b>	10,214	6,553	3,444	<b>20,211</b>	12,705	7,329	177	
2018-2019	<b>20,574</b>	10,518	6,746	3,310	<b>20,574</b>	13,240	7,131	203	

Эх үүсвэр: Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам

Улсын хэмжээнд гуравдугаар ээлжээр хичээллэж байгаа 25 сургуулийн 20 нь нийслэл хотын 166 бүлгийн 7,044 суралцагч байгаа бол хөдөө орон нутагт 5 сургуулийн 37 бүлгийн 1024 суралцагч байна.

**Дээд боловсрол.** 2018-2019 оны хичээлийн жилийн статистикийн мэдээгээр Монгол Улсад дээд боловсролын 94 байгууллага сургалтын үйл ажиллагаа явуулж байгаагийн 37.2 хувь буюу 35 их сургууль, 52.1 хувь буюу 49 дээд сургууль, 7.4 хувь буюу 7 коллеж, 3.1 хувь буюу 3 гадаадын салбар сургууль байна. Үүнээс 86 нь нийслэлд, 8 нь орон нутагт харьяалагдаж байна. Төрийн өмчийн 18 их дээд сургууль, коллеж, хувийн өмчийн 73, гадаадын 3 их, дээд сургууль, коллеж үйл ажиллагаа явуулж байна. Эдгээрт нийт 157.6 мянган оюутан суралцаж байгаагийн 146.0 буюу 92.6 хувь нь Улаанбаатар хотод, 11.6 буюу 7.4 хувь нь хөдөө орон нутгийн сургуулиудад (салбар сургуулиуд ороод) суралцаж байна. Өмнөх хичээлийн жилтэй харьцуулахад нийслэл хотод суралцагчдын тоо 1,963-аар, хөдөө орон нутгийн сургуулиудад суралцагчдын тоо 415-аар тус тус өссөн бөгөөд тэдгээрийн нийт дунд эзлэх хувь өнгөрсөн оны түвшинтэй харьцуулбал нийт сурагчдын дунд нийслэл хотод суралцагчдын эзлэх хувь өмнөх оноос 0.2 пунктээр буурсан бол, хөдөө орон нутгийнх эсрэгээрээ 0.2 пунктээр өссөн байна.

Дээд боловсролын сургалтын байгууллагад 2018-2019 оны хичээлийн жилд 44.0 мянган суралцагч шинээр элссэний 31.5 мянга буюу 71.5 хувийг тухайн жилд өрөнхий боловсролын сургуулийн 12 дугаар ангийг төгсөж бүрэн дунд боловсрол эзэмшигчид, 3.4 хувийг бусад хэлбэрийн сургуулиас, 21.8 хувийг ажиллагчдаас, 3.2 хувийг ажилгүйчүүдээс элсэгчид бүрдүүлж байна. Нийт төгсөгчдийн 0.2 хувь нь дипломын дээд, 86.1 хувь нь бакалавр, 13.3 хувь нь магистр, 0.3 хувь нь докторын зэргээр төгссөн байна. Өнгөрсөн хичээлийн жилийнхтэй харьцуулахад дипломын дээд 450-аар, бакалавр 5.1 мянгаар тус тус буурсан бол, магистр 96, доктор 18-аар тус тус нэмэгдсэн байна.

Суралцагчдыг суралцаж буй мэргэжлийн чиглэлээр ангилж үзвэл 14.8 хувь нь боловсрол, 8.7 хувь нь урлаг ба хүмүүнлэг, 4.5 хувь нь нийгмийн шинжлэх ухаан, мэдээлэл, сэтгүүл зүй, 27.5 хувь нь бизнес, удирдлага, эрх зүй, 2.7 хувь нь байгалийн шинжлэх ухаан, математик, статистик, 3.2 хувь нь мэдээлэл, харилцаа холбооны технологи, 14.5 хувь нь инженерчлэл, үйлдвэрлэл, зохион бүтээлт, 2.2 хувь нь хөдөө аж ахуй, ой, загасны аж ахуй, мал эмнэл зүй, 14.2 хувь нь эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, 4.0 хувь нь үйлчилгээ, 3.6 хувь нь бусад чиглэлд тус тус суралцаж байна.

2017-2018 оны хичээлийн жилийн нийт төгсөгчдийн 34.4 хувь нь төгссөн даруйдаа ажлын байртай болсон байна. Энэ үзүүлэлт өнгөрсөн хичээлийн жилтэй харьцуулахад 2.2 пунктээр өсжээ. Докторантур төгсөгчид бараг бүхэлдээ (96.2%), магистрантур төгсөгчдийн 80.1 хувь нь ажлын байртай хүмүүс байгаа бол бакалаврын зэргээр төгсөгчдийн ажил эрхлэлтийн байдал 27.1 хувьтай байна.

**Шинжлэх ухаан, технологийн салбар.** Шинжлэх ухаан, технологийн эрдэм шинжилгээ, судалгааны 41 төрийн өмчийн, 20 хувийн хэвшилийн нийт 61 байгууллагууд үйл ажиллагаа явуулж байна. Шинжлэх ухааны салбарт нийт 4,534 хүн ажиллаж байгаагийн 76.7 хувь буюу 3,482 нь үндсэн орон тооны, 23.3 хувь буюу 1,052 нь гэрээт ажиллагчид байна. Үндсэн ажиллагчдын 58.4 хувь буюу 2,033 нь эрдэм шинжилгээний ажилтнууд байна.

Улсын хэмжээнд 2018 оны байдлаар 506 шинжлэх ухаан, технологийн төсөл хэрэгжиж байсан бол 2019 оны байдлаар 317 үргэлжлэн хэрэгжиж, 244 орчим төслийг шинээр эхлүүлэхээр ажиллаж байна.

**Соёл.** Улсын хэмжээнд 2018 оны байдлаар соёл, урлагийн нийт 788 байгууллага 6,783 ажиллагчтай үйл ажиллагаа явуулж байна. Нийт ажиллагчдын 4.2 хувь нь урлагийн байгууллагад, 5.2 хувь нь музей, 45.7 хувь нийтийн номын санд, 41.3 хувь нь соёлын төв ордонд, 3.6 хувь нь кино үзвэрийн байгууллагад байна.


Төрийн өмчийн 9 музейн эзэмшиж байгаа 27 барилга байгууламжийн 4 нь музейн зориулалттай, 16 нь сүм хийд, ордны зориулалттай, 2 нь музейн сан хөмрөг, оффисын зориулалттай, 5 нь орон сууц, агуулах, худалдаа үйлчилгээ, сургуулийн зориулалттай барилга байгууламж байна. Төрийн болон орон нутгийн өмчийн музейн эзэмшиж байгаа барилга байгууламжийн 21.6 хувь нь музейн зориулалтын, 51.8 хувь нь сүм хийд, ордны зориулалтын, 3.6 хувь нь музейн сан хөмрөг, оффисын зориулалттай, 22.9 хувь нь музейн зориулалтын бус барилга байгууламж байна.

**Биеийн тамир, спорт.** Улсын хэмжээнд спортын салбарт 31 төрийн байгууллага, төрийн өмчит улсын үйлдвэрийн 3 газар, 77 тогтмол үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага, 1 төрийн өмчийн биеийн тамирын дээд сургууль, 3 төрийн бус өмчийн биеийн тамирын дээд сургууль, 8 спортын төрөлжсөн сургалттай ерөнхий боловсролын дунд сургуулиуд үйл ажиллагаа явуулж байна. Биеийн тамир, спортын төрийн байгууллагад нийтдээ 566 ажилтан ажиллаж байна.

### 1.3.7. Эрүүл мэнд

Улсын хэмжээнд 2018 онд нийт 78.9 мянган хүүхэд эсэн мэнд мэндэлж Монгол Улсын хүн ам 3.2 саяд хүрсэн байна. Хүн амын дундаж наслалт 2017 оны байдлаар 69.8 байгаа нь 2016 онтой харьцуулахад 0.32 пунктээр нэмэгдсэн байна. Үүнд эмэгтэйчүүдийн дундаж наслалт 0.34 пунктээр нэмэгдэж 75.4, эрэгтэйчүүдийн дундаж наслалт 0.30 пунктээр нэмэгдэж 65.8-д хүрсэн байна.

График 20. Хүн амын дундаж наслалт.



Эх үүсвэр: УСХ

Нялхсын эндэгдэл тогтвортой буурч 2013 онд хамгийн бага түвшинд хүрч 1000 амьд төрөлтөд 14.6 болсон хэдий ч 2016 онд 16.8 болж өсөж, 2018 онд 13.4 болж

буурсан байна. Эхийн эндэгдэл мөн адил 2016 онд өсөж 100000 амьд төрөлтөд 48.6 болсон бол 2018 онд 27.1 болж буурсан байна. 2018 онд 1000 амьд төрөлтөд ногдох тав хүртэлх насын хүүхдийн эндэгдэл 16.9 болж 2016 оны түвшнээс буурсан хэдий ч өмнөх онтой харьцуулахад 66 тохиолдлоор өссөн байна.

*График 21. Эх, нялхас, 5 хүртэл насын хүүхдийн эндэгдэл.*



Эх үүсвэр: Эрүүл мэндийн яам

**Хүн амын өвчлөл.** Монгол Улсын хүн амын өвчлөлийн нийтлэг шалтгаанд урьдчилан сэргийлж, эрт үед нь илрүүлж, эмчлэх боломжтой халдварт бус өвчин зонхилж, хүн амын нас баралтын 77 хувийг эзэлж, салбарын нийт төсвийн 70 гаруй хувийг зарцуулж байна. Нийт хүн амын 10000 хүн тутмаас 1,671.4 нь амьсгалын тогтолцооны өвчнөөр, 1,558.8 нь хоол боловсруулах тогтолцооны өвчнөөр, 1,145.6 нь зүрх, судасны тогтолцооны өвчнөөр, 952.4 нь шээс, бэлгийн тогтолцооны өвчнөөр, 511.2 нь гэмтэл хордлого бусад гадны шалтгаант үр дагавар бүхий өвчний улмаас эмнэлэгт хандаж байна. Хоол боловсруулах тогтолцооны өвчнөөс бусад бүх өвчлөл жил бүр нэмэгдсээр байна.

*График 22. Хүн амын өвчлөлийн шалтгаан.*



Эх үүсвэр: УСХ

Улсын хэмжээнд 2018 онд 27 төрлийн 42,074 халдварт өвчний тохиолдол бүртгэгдсэн нь 2017 онтой харьцуулахад 2,226 тохиолдлоор буурсан байна. Улаанбурхан өвчний дэгдэлт буурсантай холбоотойгоор нийт халдварт өвчний

тохиолдлын тоо буурсан хэдий ч, гонококт халдварт, бактерийн гаралтай хоолны хордлого, трихомониазын тохиолдол нэмэгдсэн байна. Сүрьеэгийн шинэ тохиолдол 2018 онд 3,498 бүртгэгдэж 10000 хүн амд 11.0 болж өмнөх оноос 0.9 пунктээр буурсан байна. Сүрьеэгээр өвчлөгсдийн 70 гаруй хувийг 16-аас 44 наасны залуучууд эзэлж байгаа бөгөөд эмчилгээний үр дүн дунджаар 84 хувтай байна.

**График 23. Халдварт өвчинеэр өвчлөгчид.**




Эх үүсвэр: УСХ

Зонхилон тохиолдох бэлгийн замаар дамжих халварын 16,130 тохиолдол 2018 онд бүртгэгдсэн нь нийт халдварт өвчний 38.3 хувийг эзэлж өмнөх оноос 4.9 хувиар өссөн байна. Нийт өвчлөлийн 33.9 хувийг заг хүйтэн, 38.2 хувийг тэмбүү, 27.8 хувийг трихомониаз, 0.1 хувийг ХДХВ/ДОХ-ын халдварт тус тус эзэлж байна.

Улаанбаатар хотын хүн амын 59.1 хувь нь гэр хороололд суурьшиж, нийслэлийн нийт өрхийн дийлэнх хувь нь төвлөрсөн ус, дулааны хангамжид холбогдоогүй, автомашины тоо жил тутам өсөж байгаа зэрэг нь орчны бохирдлыг нэмэгдүүлж байна. Мөн Улаанбаатар хотын гэр хорооллын хүн амын хэт нягтрал суурьшлаас хамааран агаар, хөрс, газрын гүний усны бохирдол өндөр, ундын усыг зориулалтын бус саванд хадгалж байгаа зэрэг нь усны чанар, аюулгүй байдлыг алдагдуулж хүний эрүүл мэндэд нөлөөлөх сөрөг нөлөөллийг нэмэгдүүлсээр байна.

**Хүн амын нас баралт.** Хүн амын нас баралт 2018 онд 17,407 тохиолдол бүртгэгдэж өмнөх онтой харьцуулахад 1,518 тохиолдлоор өссөн байна. Нас барсан хүн тутмын гуравны нэг нь зүрх судасны өвчинеэр, дөрвөн хүн тутмын нэг нь хорт хавдрын улмаас, 6 хүн тутмын нэг нь осол гэмтэл, хордлого болон гадны шалтгааны улмаас нас барсан байна. Нас баралтын түвшин 10000 эрэгтэй хүн амд 63.2, эмэгтэй хүн амд 39.3 ногдож байна. Нийт нас баралтад эрэгтэйчүүдийн нас баралтын эзлэх хувь эмэгтэйчүүдээс 1.5 дахин их байна. Нийт нас баралтын 52.2 хувийг элэг, цөсний өмөн, зүрх судасны өвчлөлт, тархины цус харвалт эзэлж байгаа бол амиа хорлолт 2.8 хувийг эзэлж байна.

График 24. Хүн амын нас баралтын тэргүүлэх шалтгаан.



Эх үүсвэр: УСХ

Хорт хавдраар өвчлөгчдийн тоо сүүлийн жилүүдэд тогтмол өсөж 2017 онд 17,873-д хүрсэн байна. Үүний 6,073 нь шинээр өвчлөгчид байгаа нь өмнөх оноос 5.8 хувиар өссөн үзүүлэлт байна. Монгол улсад 2017 онд 4,004 хүн хорт хавдрын шалтгаанаар нас барсан бол 5,405 хүн зүрх, судасны өвчлөлтөөр нас барсан байна.

**Эрүүл мэндийн үйлчилгээ.** Улсын хэмжээнд 2017 онд нийт 4,005 эрүүл мэндийн байгууллага үйл ажиллагаа явуулж байгаагаас 13 төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, 5 бүсийн оношилгоо эмчилгээний төв, 16 аймгийн нэгдсэн эмнэлэг, 12 дүүргийн нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төв, 6 хөдөөгийн нэгдсэн эмнэлэг, 39 сум дундын эмнэлэг, 273 сумын эрүүл мэндийн төв, 218 өрхийн эрүүл мэндийн төв, 240 хувийн ортой эмнэлэг, 1,226 үүдэн эмнэлэг эрүүл мэндийн тусlamж үйлчилгээ үзүүлж байна.

Эрүүл мэндийн салбарт нийт 50.5 мяанган эрүүл мэндийн ажилтан ажиллаж байгаагийн 10.5 мянга гаруй нь их эмч, 1.9 мянган эм зүйч, 11.9 мянга нь сувилагч, 7.7 мянга нь эмнэлгийн мэргэжлийн болон техникийн боловсролтой бусад ажилчин байна. Нэг их эмчид 300, нэг сувилагчид 259 хүн ногдож байна.

Хувийн хэвшлийн 1,466 эрүүл мэндийн байгууллагад нийт 9,709 эрүүл мэндийн ажилтан ажиллаж байгаагийн 3,298 нь их эмч, 2,322 нь сувилагч байна.

Эрүүл мэндийн даатгалын санг 2018 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн бие даан үйл ажиллагаагаа явуулахаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын багцаас Эрүүл мэндийн сайдын багцад холбогдох орон тоо, зардал, хөрөнгө болон орлого, эх үүсвэрийн хамт шилжүүлэн, өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн тусlamж, үйлчилгээний санхүүжилтийг 100 хувь улсын төсвөөс олгож байсныг өөрчилж сэргээн засах, гэрээр үзүүлэх тусlamж үйлчилгээ, өдрийн эмчилгээ, оношилгоо, шинжилгээний зардалд эрүүл мэндийн даатгалын сангаас зарцуулах болсон.

Өндөр өртөгтэй зарим төрлийн тусlamж, үйлчилгээнд шаардлагатай эмнэлгийн хэрэгсэл, протез, ортопедийн 484 нэр төрлийг 612 болгон өргөжүүлж, иргэнд зардлын

75 хувь буюу 2.0 мянгаас 20.0 сая төгрөг хүртэлхийг Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлж байна.

Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлэх зайлшгүй шаардлагатай эмийн нэр төрөл, хөнгөлөх хувь хэмжээг шинэчлэн 827 төрлийн эмэнд 20.0-80.0 хувь үүнээс, хүүхдийн 176 гаруй эмэнд хөнгөлөлт үзүүлж байна.

Мөн улсын хэмжээнд 18-аас дээш насны иргэдийн нас, эрүүл мэндийн эрсдэлд үндэслэж зонхилон тохиолдох зүрх судас, хавдар, сүрьеэ, БЗДХ-ыг эрт илрүүлэх, урьдчилан сэргийлэх үзлэгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлж 2018 онд нийт 52.3 мянган хүнийг хамруулав.

“Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэн 2017 онд нийт 353.0 мянган иргэн, 2018 онд 424.0 мянган хүнийг элэгний В, С вирусийн илрүүлэг шинжилгээнд хамруулсан.

## 1.4. БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖИЛ

### 1.4.1. Байгаль орчин, ногоон хөгжил

Монгол Улсын тогтвортой хөгжлийн тулгуур бодлогын нэг болох “Ногоон хөгжлийн бодлого”-ыг Улсын Их Хурлын 2014 оны 43 тоот тогтоолоор батлуулж, үйл ажиллагааны төлөвлөгөөг Засгийн газрын 2016 оны 35 дугаар тогтоолоор батлан хэрэгжүүлж байна.

2013 онд Монгол Улс нь НҮБ-ын “Ногоон эдийн засгийн төлөөх түншлэл” (НЭЗТТ/PAGE) хөтөлбөрт нэгдэн орж дэмжлэг авах анхны улс болсон. Энэ хүрээнд сургуулийн ногоон барилгын жишиг зураг төсөл боловсруулах, ногоон хөгжлийн шалгуур үзүүлэлт боловсруулах, засгийн газрын худалдан авалтыг “ногоон” болгоход чиглэсэн тогтвортой худалдан авалтын эрх зүйн, зах зээлийн судалгаа хийж үе шаттайгаар нэвтрүүлэх, ногоон эдийн засгийн мэдлэг олгох, байгаль хамгаалал, цэвэр технологийн стандарт, норм нормативыг олон улсын жишигт нийцүүлж шинэчлэх зэрэг ажлуудыг хэрэгжүүлж байна.

*Уур амьсгалын өөрчлөлт.* Уур амьсгалын өөрчлөлт дэлхийн дунджаас хэд дахин хүчтэй явагдаж байгаа, эмзэг өртөмтий Монгол Улсын хувьд олон улсын дэмжлэг туслалцаанд хамрагдах шаардлага өндөр байгааг анхаарч, Парисын хэлэлцээрийг 2016 онд УИХ-аар соёрхон батлуулсан. Уг конвенцийн хүрээнд уур амьсгалын өөрчлөлтөд өртөмтий, хөгжиж байгаа улс орнуудад санхүү, техник технологи, арга зүйн дэмжлэг туслалцаа үзүүлэх механизмууд бий болж НҮБ-ын Уур амьсгалын ногоон санд жил бүр 100 тэрбум ам доллар бүрдүүлж, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох арга хэмжээнд зарцуулахаар төлөвлөж байна.

*Тусгай хамгаалалттай газар нутаг.* Монгол Улсын тусгай хамгаалалттай газар нутаг 2017 оны байдлаар 102 байршилд 27.9 сая га талбайг хамарч, Монгол Улсын газар нутгийн 17.8 хувийг эзлээд байна. Монгол Улсын ойн сангийн 36.8 хувь, гол, горхи, булаг шанд, нуур, томоохон гол, мөрний урсац бүрэлдэх эх, гадаргын усны 44.7 хувь, Цэвдгийн 5.7 хувь, устах аюулд орсон болон устаж болзошгүй 300 гаруй амьтан, ургамлын үндсэн тархац нутаг, байгалийн үзэсгэлэнт газар, үндэсний түүх, соёлын үнэт өв бүхий газар нутгийн 80 орчим хувийг улсын тусгай хамгаалалтад хамруулан хамгаалж байна.

**Хүснэгт 14. Улсын тусгай хамгаалалттай нутгийн ангилал /тоо, талбайн хэмжээ/.**

№	Тусгай хамгаалалттай газрын ангилал	Тусгай хамгаалалттай газрын тоо	Талбайн хэмжээ, сая га	Нийт газар нутагт эзлэх хувь
1	Дархан цаазат газар	20	12.4	7.9
2	Байгалийн цогцолборт газар	32	11.8	7.6
3	Байгалийн нөөц газар	36	3.5	2.3
4	Дурсгалт газар	14	0.12	0.09

Эх үүсвэр: Байгаль орчин, аялал жуулчлалын яам

Тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаад 2018 оны байдлаар нийт 607 орон тоотой үйл ажиллагаа явуулж байна.

**Ус.** Монгол Улсын гол мөрний урсац бүрэлдэх эхийн нийт талбайн 44.7 хувь улсын тусгай хамгаалалтад хамрагдаж байна.

2012-2016 онуудад хот суурин газрын хүн амын ус хангамжийн эх үүсвэрийн хайгуул судалгааны ажлын хүрээнд 12 аймаг, сумын төвийн ус хангамжийн эх үүсвэрийн судалгааны ажлуудыг хийсэн байна. 2016 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Өвөрхангай аймгийн Гучин-Ус сумын төвийн, 2017 онд Дундговь аймгийн Сайхан-Овоо сумыг төвийн ус хангамжийн эх үүсвэрийн нөөцийг тогтоо газрын доорх усны хайгуул судалгаа хийсэн. 2018 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Баян-Өлгий аймгийн Өлгий хотын ус хангамжийн эх үүсвэрт газрын доорх усны ашиглалтын хайгуулын ажлын үр дүнгээр усны нөөцийг 100 л/с-ээр, Ховд аймгийн Дөргөн сумын төвийн хүн амын унд, ахуйн ус хангамжийн эх үүсвэрийн нөөцийг 7.0 л/с-ээр тогтоож, баталгаажуулсан.

Баталгаат ундны усаар хангагдсан хүн амын эзлэх хувь аймаг, нийслэлд ихээхэн ялгаатай байна. Улаанбаатар хотод баталгаат ус хангамж өндөр хувьтай байгаа ч хотын захын гэр хорооллууд, Баян-Өлгий, Баянхонгор, Архангай, Ховд, Хөвсгөл, Завхан, Увс зэрэг аймгийн ихэнх хүн ам гадаргын усыг ахуйн зориулалтаар шууд хэрэглэж байгаа нь ундны ус хангамжийн эрүүл ахуй, чанаарын шаардлагыг хангахгүй байна. Иймд гидрогоеологийн судалгааны ажлын хэтийн төлөвлөгөөний чиглэлийн дагуу хүн амын ус хангамжийн эх үүсвэрийн хайгуул судалгааны ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх зайлшгүй шаардлага тулгарч байна.

2018 онд Алтайн өвөр говийн сав газрыг хамруулсан нийт 7 лист бүхий 36,980 км<sup>2</sup> талбайд гидрогоеологийн 1:200.000-ны масштабтай усны нөөцийн тархалтыг тогтоо ажлыг гүйцэтгэсэн.

Монгол орны хэмжээнд 2007-2016 оны хооронд улсын төсвийн хөрөнгөөр болон төсөл хөтөлбөрөөр бороо, цасны усыг хуримтуулах нийт 117 хөв, цөөрмийг барьж байгуулав. Хөв цөөрөм байгуулж усны нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр 2017 онд Баянхонгор, Дорнод, Төв, Увс аймгуудад шинээр хөв цөөрөм байгуулан Булган, Дорнод, Увс аймгуудын хуучин хөв цөөрмийг сэргээн засварлав. Булган аймаг 4, Говь-Алтай аймаг 1 хөв цөөрөм байгуулах зураг төсвийн ажлыг боловсруулан батлуулаад байна.

Улсын хэмжээнд 2018 онд нийт 165 булаг шандын эхийг хашиж, хамгаалах ажлыг орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийж гүйцэтгэв.

**Агаарын бохирдол.** Улаанбаатар хот болон аймгийн төвүүдийн агаарын бохирдол ихсэж, ялангуяа өвлийн улиралд Улаанбаатар хотын хэмжээнд нийт

ажиглалтын 50 гаруй хувьд Монгол Улсын Агаарын чанарын стандартаас давсан бохирдолтой байна. 2018-2019 оны хүйтний улирал буюу 2018 оны 10-12 дугаар сар, 2019 оны 1 дүгээр сарын Улаанбаатар хотын агаар дахь агаар бохирдуулах бодисын дундаж агууламжийг өмнөх оны мөн үеийн дундаж агууламжтай харьцуулахад PM10 тоосонцор 18мкг/м3-ээр буюу 10 хувиар, PM2.5 тоосонцор 29мкг/м3-ээр буюу 19 хувиар, хүхэрлэг хий 17мкг/м3-ээр буюу 32 хувиар тус тус бага, азотын давхар ислийн агууламж өмнөх жилийн түвшинд байлаа.

Улаанбаатар хотын агаарын бохирдлын 80 хувийг гэр хорооллын 196.5 мянган айл өрхийн зуух болон аж ахуйн нэгж, байгууллагын 2742 халаалтын зуух гаргаж, 10 хувийг замын хөдөлгөөнд оролцож байгаа 501.6 мянга гаруй авто тээврийн хэрэгсэл, 5-6 хувийг дулааны цахилгаан станцууд гаргаж, 4 хувийг үнсэн сан, замын тоос шороо, ил задгай хаясан хог хаягдал зэрэг бусад эх үүсвэрээс ялгарч байна.

Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийг боловсруулж Засгийн газрын 2017 оны 98 дугаар тогтоолоор, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017 оны A/107 тоот тушаалаар батлан хэрэгжүүлж байна.

**Ой.** Ойн сан бүхий газар 18.5 мянган га буюу нийт нутаг дэвсгэрийн 11.8 хувийг эзэлдэг бөгөөд үүний 12.3 мянган га нь ойгоор бүрхэгдсэн, 543.5 мянган га нь ойн сан доторх ойн бус талбай байна. Ойн сангийн талбайн 14.7 мянган га буюу 79.5 хувь нь хамгаалалтын бүсийн ой, 3.8 мянган га буюу 20.5 хувь нь ашиглалтын бүсэд хамарагдаж байна.

Ой зохион байгуулалтын судалгаагаар тогтоосон сүүлийн 5 жилийн статистик мэдээллийг харьцуулж үзэхэд ойгоор бүрхэгдсэн талбай 637.2 мянган га-гаар багасаж, ойгоор бүрхэгдээгүй талбай 918.4 мянган га-гаар нэмэгдсэн байна.

Цаг уурын дулаарлаас шалтгаалж ойд шавьж олширсноор жилд 450.0-500.0 мянган га талбайд хөнөөл учруулж асар их хэмжээний ойн сан дахин сэргэн ургахгүй нөхцөл үүсээд байна. Ойн хөнөөлт шавьж өвчний тархалтыг тогтоох судалгааны ажлыг 2015-2016 онд 4,617.4 мянган га талбайд явуулж 901.1 мянган га талбайд хөнөөлийн голомт байгааг тогтоосон. Улсын төсвийн хөрөнгөөр 2018 онд ойн хөнөөлт шавжийн судалгааны ажлыг 2970.5 мянган га ойд явуулж, 600.0 мянган га-д хөнөөлийн голомт байгааг тогтоож тэмцлийн ажлыг 236.0 мянган га-д хийсэн.

**Хөрс хамгаалал.** Хот суурин газрын хөрсний бохирдлын гол эх үүсвэр нь гэр хорооллын ариун цэврийн байгууламжаас гадна хог хаягдал, уул уурхайн хаягдал, малын гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэрийн хаягдал, агаарын бохирдол зэргээс үүдэлтэй байна.

Улаанбаатар хотын хөрсний бохирдол, экогеохимийн судалгаагаар 360 цэгээс сорьц авч шинжлэхэд 88 хувьд нь нян, хөгц мөөгөнцөр илэрсэн байна. Хот, суурин газарт гэр хорооллын ариун цэврийн байгууламжтай (жорлон, муу усны нүх) холбоотой нянгийн бохирдол өндөр байдаг бол орон нутагт уул уурхайн үүдэлтэй хөрсний бохирдол болон боловсруулах үйлдвэрлэл, машин засвар, хогийн цэгийн ойр орчмын хөрсөнд хар тугалга, хром, цайр зэрэг хүнд металлын бохирдол их байна.

## 1.5. ЗАСАГЛАЛ, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ШИНЭТГЭЛ

### 1.5.1. Хууль, эрх зүйн шинэтгэл

Нийгмийн үнэт зүйл, зарчим, улс орны хөгжлийн шаардлагад нийцсэн, авлига, албан тушаалтын болон шинэ төрлийн гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан

сэргийлэх, хариуцлага тооцох чадавхтай эрүүгийн хууль тогтоомжийн тогтолцоог бүрдүүлэх, авлига, ашиг сонирхлын зөрчилтэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх, төрийн байгууллагын үйлчилгээг иргэдэд хүнд сурталгүй, ил тод, шударга, хүртээмжтэй болгох, хүний эрх, эрх зүйт ёсны зарчимд нийцүүлэх механизмыг бий болгоход чиглэсэн багц хуулийн төслүүдийг боловсруулан УИХ-аар батлуулсан.

Эрх зүйн шинэтгэлийн хүрээнд Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай, Цагдаагийн албаны тухай, Дотоодын цэргийн тухай, Галт зэвсгийн тухай хууль, Өршөөл үзүүлэх тухай хууль, Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Хууль тогтоомжийн тухай хууль, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Прокурорын тухай хуулийн шинэчилсэн найруулга, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулга, Арбитрын тухай, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн шинэчилсэн найруулга, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, Иргэний улсын бүртгэлийн тухай, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай, Согтуурах, мансуурах донтой хүнийг захиргааны журмаар албадан эмчлэх тухай хуулиудыг боловсруулан, УИХ-аар хэлэлцүүлэн батлууллаа.

Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтийн эсрэг үндэсний хөтөлбөр, Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөр, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дунд хугацааны хөтөлбөр, Бүх нийтийн эрх зүйн боловсрол хөтөлбөр, "Нэг-иргэн, нэг-бүртгэл" үндэсний хөтөлбөр зэрэг томоохон хөтөлбөрүүдийг батлуулж, хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулж байна. Мөн "Цахим гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний хөтөлбөр"-ийг боловсруулж, батлуулахаар ажиллаж байна.

**Цагдаагийн байгууллага.** Цагдаагийн байгууллага нь хуулиар хүлээсэн гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргээ бүх шатны төрийн болон төрийн бус байгууллага, иргэд, олон нийтийн дэмжлэг туслалцаанд түшиглэн, хэрэгжүүлж байна.

"Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтийн эсрэг үндэсний хөтөлбөр, Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөр, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дунд хугацааны хөтөлбөр зэрэг томоохон хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж ажиллалаа.

2018 онд 17 аймгийн 25 сум, нийслэлийн 2 дүүрэгт замын хөдөлгөөний хяналтын постын барилгыг барьж, ашиглалтад оруулахад 2.1 тэрбум, хурд хэмжигч, Драгер маркийн согтуурлын зэрэг тогтоогч багаж хэрэгсэл, тавилга хэрэгслээр хангаж, бэлэн бус торгуулийн системийг өргөжүүлэх тоног төхөөрөмжийг худалдан авахад 5.1 тэрбум төгрөгийг зарцууллаа.

**Хил хамгаалал.** Монгол Улсын Засгийн газрын 2012 оны н/110 дугаар тогтоолоор батлагдсан "Бүсчилсэн хил хамгаалалт хөтөлбөр"-ийн дагуу улсын хил хамгаалалтыг физик газар зүй, байгаль цаг уурын онцлогт нийцүүлэн тал хээр,.gov цөл, уул, ой тайгаар бүсчлэн зохион байгуулж байна. Үндсэн чармайлтаа төвлөрүүлэх чиглэлийн Баян-Өлгий, Увс, Завхан, Хөвсгөл, Дорноговь аймгууд дахь хилийн ангиудын улсын хил хамгаалалтын нягтралыг нэмэгдүүлэх, хүч хэрэгслийг

төвлөрүүлэх шаардлагатай хилийн анги, салбарын бүтэц, орон тоог нэмэгдүүлэх, холбоо, уналга, автотехник хэрэгслээр хангах, дохиолол-хяналтын систем, хилийн инженерийн байгууламжийг шинээр байгуулах, засварлах цогц арга хэмжээ авч хэрэгжүүлсэн.

**Улсын бүртгэл.** Засгийн газрын 2018 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 144 дүгээр тогтоолоор “Нэг иргэн-нэг бүртгэл” үндэсний хөтөлбөрийг батлан, хэрэгжилтийг ханган ажиллав.

УИХ-ын 2018 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн чуулганы хуралдаанаар Улсын бүртгэлийн багц хууль /Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тухай, Иргэний улсын бүртгэлийн тухай, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай/-ийн шинэчилсэн найруулгын төслийг хэлэлцүүлэн батлуулж, 2018 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хуулийг мөрдөн ажиллаж байна. Улсын бүртгэлийн багц хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан иргэний 10 төрлийн бүртгэлийг иргэдэд харьялал харгалзахгүйгээр үзүүлж байна.

Бүртгэлийн үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх, үйлчилгээний шат дамжлагыг бууруулж, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор 2018 оны 04 дүгээр сарын 09-ны өдрөөс эхлэн гадаадад зорчих эрхийн бүртгэлийн үйлчилгээг 9 дүүрэг, нийслэлийн үйлчилгээний нэгдсэн 4 төв, нийт 13 нэгжээр дамжуулан хүргэдэг болсон. 2018 онд гадаадад зорчих эрхийн бүртгэлийн чиглэлээр 378 997 иргэнд үйлчилгээ үзүүлэн ажилласан байна.

Улсын бүртгэлийн багц хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд бүртгэлийн лавлагаа, үйлчилгээг түргэн шуурхай хүргэх зорилгоор бүртгэлийн үйлчилгээний цахим систем [/www.burtgel.mn/](http://www.burtgel.mn/)-ийг нэвтрүүлсэн.

**Архив.** Архивын байнга хадгалах баримтын 19.2 хувийг цахим хэлбэрт шилжүүлэн иргэд, байгууллагад үйлчилгээ үзүүллээ.

Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааны эрх зүйн орчинг боловсронгуй болгохоор Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн төслийг боловсруулж, батлуулахаар ажиллаж байна;

БНСУ-ын Засгийн газраас Монгол Улсын Засгийн газарт олгох урт хугацаатай, хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр “Архивын Ерөнхий газрын цогцолбор барилгын тоног төхөөрөмж, техник хэрэгслийн хангалт” төслийг хэрэгжүүлэхээр бэлтгэл ажлууд үе шаттай хийгдэж байна.

**Гадаадын иргэн харьяатын асуудал.** Бүгд Найрамдах Солонгос Улсын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага /КОЙКА/-ын 5.0 сая ам.долларын буцалтгүй тусlamжаар “E-immigration” төсөл хэрэгжсэн. Төсөл хэрэгжсэнээр Монгол Улсад оршин суугаа гадаадын иргэд болон хилээр нэвтэрсэн иргэдийн тоо, бүтцийг үнэн зөв тогтоох, гадаадын иргэдийн шилжилт хөдөлгөөнийг бүртгэх, хянах асуудлыг Монгол Улсын хэмжээнд уялдуулан зохицуулах, иргэд хилээр нэвтрэх шалгагчгүй шалган нэвтрүүлэх цахим системийг бий болгох, гадаадын иргэдийн бүртгэл, хяналтын тогтолцоо, бүтэц зохион байгуулалтыг олон улсын нийтлэг жишигт нийцүүлэх, байгууллагын үйл ажиллагааг нээлттэй, ил тод, шуурхай болгох зэрэг олон зорилтыг шийдвэрлэх бүртгэл, хяналтын цогц систем Монгол Улсын хэмжээнд бий болсон.

Засгийн газрын 2018 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 145 дугаар тогтоолоор “Монгол Улсын виз олгох журам”, 146 дугаар тогтоолоор “Гадаадын иргэн Монгол Улсад оршин суух болон түүнийг бүртгэх журам”-ыг шинэчлэн, 147 дугаар тогтоолоор “Гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах болон Монгол Улсад дахин

оруулахгүй байх хугацаа тогтоох журам"-д нэмэлт, өөрчлөлт оруулан батлуулж, 2018 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн бөгөөд тусгай төлөвлөгөөний дагуу сургалт, сурталчилгааны ажлууд хийж гүйцэтгэн, тогтоолын хэрэгжилтийг ханган, хяналт тавин ажиллаж байна.

### **1.5.2. Төрийн өмчийн бодлого, зохицуулалт**

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын хүрээнд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийг хангах, төрийн өмчийн талаарх бодлого боловсруулан хэрэгжүүлэх, менежментийг сайжруулах, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд сайн засаглалыг хөгжүүлэх замаар өмчийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, худалдан авах ажиллагааг олон улсын жишигт хүргэж, ил тод, өрсөлдөх тэгш боломжийг хангах чиглэлээр ажиллаж байна.

### **1.5.3. Стандарт, хэмжил зүй**

Монгол Улсын хэмжээнд 2014 онд 5,872 стандарт мөрдөж байсан бол 2018 онд нийт 6,295 стандарт болж 7.2 хувь буюу 423-аар өссөн байна.

Тохирлын үнэлгээний 238 байгууллага итгэмжлэгдэн ажиллаж байгаагаас сорилтын 165, шалгалт тохируулгын 15, эмнэлгийн 9 лаборатори, техникийн хяналтын 19, бүтээгдэхүүн баталгаажуулалтын 26, менежментийн тогтолцоо баталгаажуулалтын 3, хүлэмжийн хийн магадалгаа, нотолгооны 1 байгууллага байна. Тохирлын үнэлгээний итгэмжлэгдсэн байгууллага 2017 онд 227 байсан бол 2018 онд 238 болж нэмэгджээ.

“Үндэсний стандартын шинжлэх ухаан техникийн түвшинд улсын үзлэг явуулах тухай” Улсын Их хурлын 2017 оны 87 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий Сайдын 2018 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн 97 дугаар захирамжийн дагуу стандартын улсын үзлэгийг явуулж, улсын хэмжээнд мөрдөгдөж байгаа нийт 6,217 стандартыг хамруулснаас 1,709 бүтээгдэхүүний, 2,528 шинжлэх турших аргын, 670 нэр томьёоны, 1,310 бусад стандарт байна. Үзлэгт хамрагдсан нийт стандартын 40.8 хувь буюу 2,540 стандартын шинжлэх ухаан техникийн өнөөгийн түвшин олон улс, бус нутаг, гадаад орны түвшинд хүрсэн байна. Үзлэгийн үр дүнд үндэслэн стандартын үзүүлэлт, шаардлагыг дээшлүүлэх, стандартчиллын ажлын хэтийн чиглэлийг тодорхойлох зорилгоор одоо мөрдөж буй 367 стандартыг хүчингүй болгох, 2,074 стандартыг дахин хянаж шинэчлэх, 591 стандартыг шинээр боловсруулахаар ажиллаж байна.

Монгол Улсын Стандарт, хэмжил зүйн газар 2018 оны 10 дугаар сард Олон улсын итгэмжлэлийн форум (IAF)-д гишүүнээр элсэж, Харилцан хүлээн зөвшөөрөх гэрээнд итгэмжлэлийн 4 төрлөөр нэгдсэн нь олон улсын итгэмжлэлийн байгууллагуудын хоорондох харилцаа, хамтын ажиллагааг бэхжүүлэх, олон улсын худалдаан дахь техникийн саад тогторыг арилгахад чиглэсэн чухал ач арга хэмжээ болсон.

Үнэт металл, сорьцын хяналтын хүрээнд эрдэнийн чулуу, үнэт металлаар хийсэн эдлэлд шинжилгээ хийх, сорьц тогтоох ажлыг жилд дунджаар 1,000 гаруй удаа, мөнгөн эдлэлд сорьц тогтоох шинжилгээ, дотоодын болон импортын 60.0 мянган ширхэг эдлэлд сорьцын баталгаа олгож байна.

Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг Улсын Их Хурлаас 2017 оны 12 дугаар сарын

21-ний өдөр батлуулж, 2018 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хэрэгжүүлж эхэлсэнтэй холбоотойгоор Засгийн газрын 2018 оны 10 дугаар сарын 3-ны өдрийн 291 дүгээр тогтоолоор “Тохирлын баталгаанд заавал хамруулах бүтээгдэхүүн үйлчилгээний жагсаалт”, “Тохирлын баталгаатай бүтээгдэхүүн, үйлчилгээг Монгол Улсын зах зээлд нийлүүлэх, улсын хилээр нэвтрүүлэх журам”-ыг батлуулсан.

Стандарт, хэмжил зүйн газрын итгэмжлэлийн бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, тохирлын үнэлгээний байгууллагын үйл ажиллагааг үндэсний хэмжээнд уялдуулан зохицуулах чиг үүргийг Үндэсний итгэмжлэлийн төвөөр гүйцэтгүүлж Монгол Улсын Шадар сайдын харьяанд ажиллуулах шийдвэрийг Засгийн газрын 2018 оны 8 дугаар сарын 29-ний 270 дугаар тогтоолоор гаргуулав.

Засгийн газрын 2018 оны 9 дүгээр сарын 5-ны өдрийн 275 дугаар тогтоолоор орон нутагт үнэт металлын сорьц тогтоох чиг үүргийг хэрэгжүүлэх төвийн бүсийн лабораторийг Дархан-Уул аймагт, баруун бүсийн лабораторийг Баянхонгор аймгийн Стандарт, хэмжил зүйн газрын бүтцэд байгууллаа.

#### **1.5.4. Улсын мэргэжлийн хяналт**

Мэргэжлийн хяналтын байгууллага нь Монгол Улсын нутаг дэвсгэрт иргэдийн эрүүл, аюулгүй орчинд ажиллаж амьдрах, чанартай бүтээгдэхүүн үйлчилгээ хэрэглэх, бизнес эрхлэх таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэх, хуулийг сахин мөрдүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлж, Монгол Улсын 106 хууль, олон улсын гэрээ конвенц 42, Улсын Их Хурлын 23 тогтоол, Засгийн газрын 300 тогтоол, 1,200 стандарт, техникийн зохицуулалт, 434 дүрэм, журмын хэрэгжилтийг хангуулахад 27 чиглэлийн хяналтыг 2008 орон тоотойгоор хэрэгжүүлж байна.

Монгол Улсын Шадар сайдын 2016 оны 129 дүгээр тушаалаар Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын бүрэлдэхүүнд 9 газар, мэн орон нутагт Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар, аймгуудын мэргэжлийн хяналтын газар, хилийн мэргэжлийн хяналтын албад, Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори ажиллаж байна. “Монгол Улсын Шадар сайдын 2018 оны 17 дугаар тушаалаар “Мэргэжлийн хяналтын байгууллагын дунд хугацааны төлөвлөгөө”-г батлуулан хэрэгжүүлж байна.

Эрсдэлийн үнэлгээнд 2018 онд 140.5 мянган объектыг хамруулснаас эрсдэл ихтэй объект 21.3 мянга буюу 15.2 хувь, дунд эрсдэлтэй 80.8 мянга буюу 57.6 хувь, эрсдэлтэй багатай объект 38.3 мянга буюу 27.3 хувийг эзлэв. Эрсдэлийн үнэлгээнд 2018 онд 140.5 мянган объект хамруулсан нь 2014 оноос 2.1 дахин буюу 74.6 мянгаар нэмэгдсэн байна. Харин 2018 онд гүйцэтгэсэн хяналт шалгалтаар 6,175 албан шаардлага, 4,954 зөвлөмж, 1,748 дүгнэлт гаргаж, 193 объектын үйл ажиллагааг түр, 25 объектын үйл ажиллагааг бүрэн зогсоосон байна.

#### **1.5.5. Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах**

Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар Өрсөлдөөний тухай хууль, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль, Зар сурталчилгааны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Монгол хэлний тухай хууль, Сонгуулийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Өрсөлдөөн, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах хүрээнд 2018 оны байдлаар 3,103 өргөдөл, гомдлыг шийдвэрлэж, 180 хяналт шалгалт гүйцэтгэж 382 аж ахуйн нэгж байгууллагыг хамруулснаас 34 аж ахуйн нэгжид 1.8 тэрбум төгрөгийн торгууль ногдуулсан байна. Улсын хэмжээнд давамгай байдалтай аж ахуйн нэгжийн тоо 2018 онд 13 байгаагаас хүнс, мэдээлэл, харилцаа холбоо, газрын тос, эрүүл мэнд зэрэг салбарт үйл ажиллагаа явуулж байна. Засгийн газрын 2016 оны 233 дугаар тогтоолоор батлагдсан “Хэрэглэгчийн эрхийг хамгаалах үндэсний хөтөлбөр (2016-2020)”—ийн хэрэгжилтийг хангаж байна.

“Зах зээлийн өрсөлдөөнийг дэмжих үндэсний хөтөлбөр”-ийг 2019 онд батлуулж, “Хэрэглэгчийн эрхийг хамгаалах үндэсний хөтөлбөр”-ийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

#### **1.5.6. Онцгой байдал**

Монгол Улсын хэмжээнд 2018 онд 4,373 удаагийн аюулт үзэгдэл, ослын тохиолдол гарсан нь өнгөрсөн оноос 4.3 хувь буюу 179-өөр өссөн бол 2014 оноос 11.2 хувь буюу 555 тохиолдоор буурсан байна. Ой, хээрийн түймэр 2018 онд нийслэл, 13 аймгийн 48 суманд 77 удаа гарсан нь өнгөрсөн оноос 2.9 дахин, 2014 оноос 3.6 дахин буурчээ. Объектын түймэр 2018 онд 3,826 удаа гарч өнгөрсөн оноос 8.2 хувь буюу 290-ээр өссөн бол 2014 оноос 9.4 хувь буюу 396-аар буурсан байна. Аадар бороо, үерийн аюул 2018 онд 74 гарсан нь өнгөрсөн оноос 4.3 дахин, 2014 оноос 2.3 дахин өсжээ.

**Хүснэгт 15. Тохиолдсон гамшигт үзэгдэл, учирсан хохирол.**

<b>Үзүүлэлтүүд</b>	<b>2014</b>	<b>2015</b>	<b>2016</b>	<b>2017</b>	<b>2018</b>
Гамшигт үзэгдлийн тохиолдлын тоо	4,928	5,422	4,381	4,194	4,373
Ой, хээрийн түймэр	281	354	138	225	77
Шатсан ой, хээр (сая га)	2.9	6.5	3.2	0.59	0.57
Объектын түймэр	4,222	4,561	138	3,536	3,826
Хүчтэй цасан болон шороон шуурга	25	21	14	23	22
Аадар бороо, үерийн аюул	32	23	21	17	74
Газар хөдлөлт	63	54	59	42	35
Хорогдсон мал, амьтан (мянган толгой)	15.1	175.3	1,059.4	539.1	1,400.0
Гамшигийн улмаас нас барсан хүн	175	198	230	203	206
Гамшигийн улмаас учирсан хохирлын хэмжээ (тэрбум төгрөг)	25.2	79.9	43.1	96.7	81.9
Зарцуулсан хөрөнгө (тэрбум төгрөг)	0.84	0.85	1.4	14.5	10.4

Эх үүсвэр. Үндэсний статистикийн хороо

Гамшигт үзэгдлийн улмаас учирсан шууд хохирлын хэмжээ 2018 онд 81.9 тэрбум төгрөг болж өнгөрсөн оноос 15.3 хувь буюу 14.8 тэрбум төгрөгөөр буурсан бол 2014 оноос 3.2 дахин буюу 56.7 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

Гамшигтай тэмцэх хор уршгийг арилгах хүрээнд 1,125 хүний амь нас, төрийн болон аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн 41.9 тэрбум төгрөгийн эд хөрөнгийг авран хамгаалахад 2018 онд 10.4 тэрбум төгрөг зарцуулсан нь өнгөрсөн оноос 28.3 хувь буюу 4.1 тэрбум төгрөгөөр буурсан бол 2014 оноос 12.4 дахин нэмэгджээ.

Улсын хэмжээнд гамшигаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах чиглэлээр 2018 онд 268.0 мянян хяналт шалгалт хийж 95.2 мянян зөрчил илрүүлснээс 40.2 мянян зөрчлийг газар дээр нь арилгуулж, бусад зөрчлийг

арилгуулахаар 15.0 мянган албан шаардлага, мэдэгдлийг холбогдох газар, албан тушаалтанд хүргүүлсэн.

Гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, учирсан хор уршгийг арилгах арга хэмжээнд аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс 393.3 сая, олон улсын байгууллагаас 395.1 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 1.8 тэрбум, нийт 2.6 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

*Техник, тоноог төхөөрөмжийн хангальт.* Салбарын хэмжээнд Онцгой байдлын ерөнхий газар, аймаг, нийслэл, сум, дүүргийн 22 онцгой байдлын газар, 15 хэлтэс, 67 гал унтраах, аврах анги, 29 эрэн хайх, аврах анги, салбар, бүлэг, 24 Улсын нөөц, хүмүүнлэгийн тусламжийн анги, салбар, Гамшиг судлалын хүрээлэн, Үндэсний аврах бригад, Давтан сургалт, сэргээн заслын төв, “Аврагч” биеийн тамир, техник спортын хороо гэсэн салбар, нэгжтэйгээр ажилладаг.

Монгол Улсын “Гал унтраах анги, хэсэг, аврах нэгжид тавих шаардлага” MNS 6412-2013: стандартад зааснаар улсын хэмжээнд 80-90 гал түймэр унтраах, аврах анги үйл ажиллагаа явуулах шаардлагатайгаас 2018 оны жилийн эцсийн байдлаар 67 гал түймэр унтраах, аврах анги үйл ажиллагаа явуулж байна.

*Дадлага, сургууль.* Орон нутгийн удирдлага, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, иргэд олон нийтийн гамшгаас хамгаалах мэдлэгийг дээшлүүлэх удирдлага, зохицуулалт, харилцан ажиллагааг сайжруулах үүднээс Сүхбаатар, Төв, Увс аймагт гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль, Булган, Хэнтий аймагт гамшгаас хамгаалах команд штабын сургууль, “Говийн чоно-2018” Олон улсын сургалт, дадлага сургуулийг Ховд аймагт зохион байгуулж 65.2 мянган хүн, нүүлгэн шилжүүлэх дадлага сургуульд 3 аймгийн 3 сумын 54.9 мянган иргэн хамрагдлаа.

Монгол Улсын Засгийн газар, НҮБ-ын Гамшигийн эрсдэлийг бууруулах газартай хамтран “Гамшигийн эрсдэлийг бууруулах Олон Улсын стратегийн Азийн түншлэлийн хурал”-ыг 2018 оны 4 дүгээр сарын 24-25-ны өдрүүдэд, “Гамшигийн эрсдэлээс урьдчилан сэргийлснээр тогтвортой хөгжлийг хамгаалах нь” уриатай Гамшигийн эрсдэлийг бууруулах Азийн Сайд нарын II бага хурлыг НҮБ-ын Эрсдэлийг бууруулах газар, ОБЕГ-тай хамтран 2018 оны 7 дугаар сарын 3-6-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгуулж, хурлаар “Сендайн үйл ажиллагааны хүрээ” баримт бичгийн эхний 3 жилийн Азийн бүсийн төлөвлөгөөний хэрэгжилт, гамшигийн эрсдэлийг бууруулах чиглэлээр бус нутгийн улс орнуудын хүлээсэн үүрэг, амлалт, авч хэрэгжүүлж буй арга хэмжээний ахиц дэвшлийг дүгнэж, “Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичгийг хэрэгжүүлэх Азийн бүсийн 2018-2020 оны төлөвлөгөө”, “Улаанбаатарын тунхаглал”, “Оролцогч талуудын сайн дурын мэдэгдэл” баримт бичгийг баталсан.

“Гамшигийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээг Монгол Улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги /2018-2030/-ийг Засгийн газрын 2017 оны 355 дугаар тогтоолоор батлуулан хэрэгжүүлж байна.

Засгийн газрын 2018 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн 40 дүгээр тогтоолоор “Гамшгаас хамгаалах улсын хяналтын дүрэм”, 2018 оны 3 дугаар сарын 7-ны өдрийн 63 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар “Гамшигийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөлийн дүрэм”, хоёрдугаар хавсралтаар “Гамшигийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөлийн ажиллах журам”, 2018 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 67 дугаар тогтоолоор “Гамшигийн эрсдэлийн үнэлгээ хийх журам”, 2018 оны 8 дугаар сарын 29-ний өдрийн 271 дүгээр тогтоолоор “Гамшгаас хамгаалах дотоодын хүмүүнлэгийн

тусlamжийг зохицуулах журам”, 2018 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 327 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар “Гамшгийн зэрэглэл тогтоох журам”, хоёрдугаар хавсралтаар “Гамшгийг тодорхойлох шалгуур үзүүлэлт”-ийг батлуулан мөрдөж байна.

## 1.6. ГАДААД ХАРИЛЦАА, БАТЛАН ХАМГААЛАХ

### 1.6.1 Гадаад харилцаа

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Гадаад бодлогын үзэл баримтлал, үндэсний язгуур эрх ашиг, тогтвортой хөгжлийн зорилгод нийцсэн энхийг эрхэмлэсэн, нээлттэй, бие даасан, олон тулгуурт гадаад бодлогыг тууштай хэрэгжүүлж байна. Гадаад бодлогын нэг цонхны бодлого, гадаад бодлогын нэгдмэл байдал, залгамж чанарыг хадгалах чиг шугамаа тууштай баримталж, гадаад харилцааны үр өгөөжийг дээшлүүлж, улс орны хөгжлийн гадаад таатай нөхцөлийг хангахад үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллаа.

Олон улстай харилцаагаа бэхжүүлэх хүрээнд НҮБ-ын бүх гишүүн орнуудтай дипломат харилцаа тогтоох чиглэлийг баримталж, 2018 оны жилийн эцсийн байдлаар дипломат харилцаатай улсын тоо 192-д хүрлээ. Эдгээр орнуудтай болон олон улсын байгууллагуудтай хоёр талын хийгээд олон талын харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлж байна.

**Хөрш орнуудын харилцаа.** Гадаад бодлогын тэргүүлэх чиглэл болох ОХУ, БНХАУ-тай тогтоосон харилцааны түвшинг баталгаажуулж, чингэхдээ ОХУ-тай Стратегийн түншлэл, БНХАУ-тай Иж бүрэн стратегийн түншлэлийг бүхий л салбарт гүнзгийрүүлж, шинэ агуулгаар баяжуулж байна. Монгол, ОХУ, БНХАУ-ын төрийн тэргүүн нарын 4 дэх уулзалт БНХАУ-ын Чиндао хотноо зохион байгуулагдсан Шанхайн хамтын ажиллагааны байгууллагын гишүүн орнуудын төрийн тэргүүн нарын зөвлөлийн хуралдааны үеэр 2018 оны 6 дугаар сарын 9-10-ны өдрүүдэд болсон. Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга 2018 оны 9 дүгээр сарын 11-13-ны өдрүүдэд ОХУ-ын Владивосток хотноо болсон Дорнын эдийн засгийн IV чуулга уулзалтад оролцож, ОХУ-ын Ерөнхийлөгч В.В.Путинтэй хоёр талын уулзалт хийсэн.

Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх 2018 оны 4 дүгээр сарын 8-12-ны өдрүүдэд БНХАУ-д албан ёсны айлчлал хийж, Азийн төлөөх Баогийн чуулга уулзалтад оролцов. Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар 2018 оны 5 дугаар сарын 16-17-ны өдрүүдэд ОХУ-д ажлын айлчлал хийж, мөн ОХУ-ын Сочи хотноо 2018 оны 10 дугаар сарын 20-ны өдөр Олон улсын хэлэлцүүлгийн “Валдай” клубийн XV бага хуралд оролцов. БНХАУ-ын Төрийн зөвлөлийн гишүүн бөгөөд Гадаад хэргийн сайд Ван И 2018 оны 8 дугаар сарын 23-25-ны өдрүүдэд Монгол Улсад айлчлав. Эдгээр уулзалт, айлчлал, арга хэмжээний үр дүнгээр хөрш орнуудтай хэрэгжүүлэх хамтын ажиллагааны механизмуудын тогтмол үйл ажиллагааг хангах, худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны үр өгөөжийг нэмэгдүүлэх, бүс нутгийн хөгжлийн ирээдүйг тодорхойлоход чухал ач холбогдолтой боллоо.

**Гуравдагч хөршийн харилцаа.** “Гуравдагч хөрш”-тэй харилцах хүрээнд Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх 2018 оны 9 дүгээр сарын 18-28-ны өдрүүдэд АНУ-д албан ёсны айлчлал хийж, айлчлалын дүнгээр гаргасан Хамтарсан мэдэгдэлд талууд Монгол, Америкийн харилцаа Өргөтгөсөн иж бүрэн түншлэлийн түвшинд хүрснийг тунхаглан зарлав. Мөн түүнчлэн Мянганы сорилтын Хоёр дахь Компакт гэрээг баталгаажуулсан Хамтарсан тунхаглалд 2018 оны 9 дүгээр сарын 20-ны өдөр гарын үсэг зурав. АНУ-ын Засгийн газраас олгож буй 350.0 сая ам.долларын буцалтгүй

тусlamжийг Улаанбаатар хотын нийт ус хангамжийг нэмэгдүүлэх дэд бүтцийн хөтөлбөрт зарцуулахаар хоёр тал тохиролцсон. Монгол Улсын Засгийн газар, Америкийн Нэгдсэн Улсын Мянганы сорилтын корпорацын хооронд байгуулсан хоёр дахь компакт гэрээний хэрэгжилтийг хангах чиг үүрэг бүхий “Монголын мянганы сорилтын сан”-г Засгийн газрын 2018 оны 10 дугаар сарын 3-ны өдрийн 297 дугаар тогтоолоор байгуулан ажиллаж байна.

Гадаад харилцааны сайд 2018 оны 5 дугаар сарын 22-ны өдөр Монгол, Америкийн Эдийн засгийн бодлогын II зөвлөлдөх уулзалт, мөн Төрийн нарийн бичгийн дарга М.Помпеогийн урилгаар Вашингтон хотноо 2018 оны 7 дугаар сарын 25-26-ны өдрүүдэд болсон Шашны эрх чөлөөг дэмжих тухай Сайд нарын олон улсын анхдугаар бага хуралд оролцлоо.

Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх 2018 оны 12 дугаар сарын 12-15-ны өдрүүдэд Япон Улсад хийсэн албан ёсны айлчлалын үеэр хоёр улсын Стратегийн түншлэлийг хөгжүүлэх тухай Дунд хугацааны хөтөлбөр (2017-2021)-ийн хэрэгжилтийн явцад үнэлэлт, дүгнэлт өгч, Ерөнхий сайд нар Хамтарсан мэдэгдэл гаргасан нь чухал ач холбогдолтой болсон.

Монгол Улс, АНУ, Япон Улсын гурван талт ээлжит уулзалт 2018 оны 4 дүгээр сард Токио хотноо болж, гурван тал хамтарсан мэдэгдэл гарган, энэхүү уулзалт нь санал солилцох чухал механизм болж байгаагийн ач холбогдлыг талууд дахин нотолсон.

Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар Бүгд Найрамдах Словак Улсад 2018 оны 4 дүгээр сарын 20-ны өдөр айлчлал хийсэн нь Словак Улсад манай улсаас хийгдсэн анхны өндөр түвшний айлчлал болж, Швейцарийн Холбооны Улсын Гадаад хэргийн сайд И.Кассис 2018 оны 4 дүгээр сарын 4-6-ны өдрүүдэд Монгол Улсад албан ёсоор айлчилсан нь тус улсын сайдын түвшинд манай улсад хийсэн анхны айлчлал болов. Мөн түүнчлэн Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар 2018 оны 3 дугаар сарын 12-ны өдөр Баку хотноо Бүгд Найрамдах Азербайжан Улсын Гадаад хэргийн сайд Э.Мамедарьятай уулзаж, Гадаад хэргийн яамд хоорондын харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурав.

БНСУ-ын Засгийн газраас ОУВС-ийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн хүрээнд манай улсад 500.0 сая ам.долларын зээл олгох тухай Засгийн газар хоорондын ерөнхий хэлэлцээрт гарын үсэг зурж, зээлийн хөрөнгийг Улаанбаатар хотын агаар, орчны бохирдлын асуудлыг шийдвэрлэхэд ашиглахаар тогтов.

Монгол, Энэтхэгийн улс төрийн яриа хэлэлцээ эрчимтэй өrnөж, тус улсаас Монгол Улсыг “Зүүн Азийн бүс нутгийн тогтвортой байдлыг хангахад чухал хүчин зүйл болж байна” хэмээн тэмдэглэсэн. БНЭУ-ын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлээр байгуулах Газрын тос боловсруулах үйлдвэр ашиглалтад орсноор гадны улс орны хамаарлаас гарч, аж үйлдвэрийн нэгэн шинэ салбар бий болох юм.

Америк, Ойрх Дорнод, Африк тивийн улс орнуудтай явуулж ирсэн харилцаа, хамтын ажиллагаа 2018 онд идэвхтэй өrnөж, энэхүү бүс нутгийн улс орнуудаас 2018 онд нийт 400.0 орчим сая ам.долларын буцалтгүй тусlamж, хандив цугласан. Аргентин, Уругвай, Чили, Эквадор, Бразил Улстай бүх төрлийн паспорт эзэмшигчдийг визийн шаардлагаас чөлөөлөх тухай хэлэлцээр, Колумби, Перу Улстай дипломат, албан паспорт эзэмшигчдийг визийн шаардлагаас чөлөөлөх тухай хэлэлцээрийг байгуулж, ингэснээр Монгол Улсын иргэд визийн хөнгөлөлттэй нөхцөлөөр латин америкийн 6 улсад зорчих боломж бүрдсэн.

**Олон талт хамтын ажиллагаа.** НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 73 дугаар чуулганы Ерөнхий санал шүүмжлэл, АСЕМ-ын Дээд түвшний 12 дугаар уулзалт зэрэг НҮБ болон олон улсын бусад байгууллагын үйл ажиллагаа, олон талт яриа хэлэлцээнд дээд, өндөр түвшний төлөөлөгчид оролцуулж, олон улсын тулгамдсан асуудлуудаар байр сууриа илэрхийлэв.

Зүүн хойд азийн Аюулгүй байдлын “Улаанбаатарын яриа хэлэлцээ” олон улсын V бага хурлыг 2018 оны 6 дугаар сарын 14-15-ны өдрүүдэд зохион байгуулж, бага хурлын нэр хүнд өсөж, бус нутгийн улсуудын оролцоог хангасан, албаны хүмүүс болон эрдэмтэн судлаачдын өргөн оролцоотой нээлттэй механизм болон төлөвшиж байна.

Далайд гарцгүй хөгжиж буй орнуудын Олон улсын судалгааны төвийн Захирагчдын зөвлөлийн анхдугаар хурлыг 2018 оны 5 дугаар сарын 21-ний өдөр Улаанбаатар хотноо зохион байгуулсан. Улаанбаатар хотноо үүсгэн байгуулагдсан Далайд гарцгүй хөгжиж буй орнуудын Олон улсын судалгааны төв нь албан ёсны нээлтээ 2018 оны 6 дугаар сарын 11-ний өдөр хийж, Далайд гарцгүй хөгжиж буй орнуудын Олон улсын судалгааны төвийн албан ёсны нээлтийн бага хурлыг зохион байгуулсан.

**Худалдаа эдийн засгийн харилцаа.** Хөрш орнууд болон голлох түнш орнуудтай худалдаа, эдийн засгийн харилцааг өргөжүүлэн хөгжүүлэх, Монголын экспортын бараа бүтээгдэхүүний гадаад зах зээлийг өргөтгөх, худалдааг хөнгөвчлөх асуудлыг анхаарч ажиллав. Энэ хүрээнд үйлдвэрлэл, экспортын таатай, тогтвортой орчин бүрдүүлэх замаар уул уурхайн бус бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний экспортыг дэмжих, экспортын бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, худалдааг хөнгөвчлөх, экспортын зах зээлийн хүрээг тэлэх арга хэмжээг шат дараатай авч хэрэгжүүлж Монгол Улсын эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах зорилготой “Монгол Экспорт” үндэсний хөтөлбөрийг Засгийн газрын 2018 оны 9 дүгээр сарын 5-ны өдрийн 278 дугаар батлуулж, хэрэгжилтийг хангаж байна.

Худалдааны эргэлтийг нэмэгдүүлэх, худалдааг төрөлжүүлэх, хөрөнгө оруулалтыг татах, монголын бараа, бүтээгдэхүүнийг экспортлох худалдааны нэмэлт гарц бий болгох, бараа бүтээгдэхүүний татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэх боломжийг бүрдүүлэх зорилгоор Владивосток, Бээжин, Токио хотуудад Монгол Улсын Худалдааны төлөөлөгчийн газар нээн ажиллуулах шийдвэрийг Засгийн газрын 2018 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 338 дугаар тогтоолоор гаргалaa.

**Гадаад сурталчилгаа, соёлын харилцаа.** Улс орнуудтай хамтын ажиллагааг хөгжүүлэхдээ улс төр, эдийн засгийн харилцааны түвшинг соёлын хамтын ажиллагаатай цогцоор нь бодлогын түвшинд уялдуулах, Монгол Улсын түүх, соёл, ёс зан заншил, өв уламжлал болон хөгжил дэвшилийг хилийн чанадад сурталчлах, гадаад орнуудтай соёлын харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх, гадаад сурталчилгаанд үндэсний нэгдсэн тогтолцоог бий болгох хүрээнд “Монгол Улсыг гадаадад сурталчлах хөтөлбөр”, “Дэлхийн Монголчууд хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж байна. Өнгөрсөн 2018 онд Монгол Улсыг сурталчилсан 86 арга хэмжээг 24 улсад болон дотооддоо зохион байгуулав. Монгол Улсын Соёлын элчээр 13 иргэнийг Австри, Испани, ХБНГУ, БНТУ, БНСУ, Нидерланд зэрэг улсад шинээр томилж, Соёлын элч нарын уулзалтыг 2018 онд Токио, Берлин хотуудад тус тус зохион байгуулав.

## **Иргэдийн эрх ашигийг хамгаалах, гадаадад зорчих нөхцөлийг хөнгөвчлөх.**

Дипломат, албан паспорт олгох ажиллагааг хөнгөвчилж, шуурхай болгох, хяналтыг сайжруулах зорилгоор “Монгол Улсын дипломат, албан паспорт олгох, эзэмших, хадгалах журам”-ыг Засгийн газрын 2018 оны 8 дугаар сарын 22-ны өдрийн 260 дугаар тогтоолоор батлуулж, 2018 оны 11 дүгээр сарын 1-ний өдрөөс мөрдөж эхэллээ.

АНУ-д хөдөлмөр эрхлэх эрх бүхий H2 ангиллын визийн олголт 2018 оны 4 дүгээр сараас хэрэгжиж эхэлсэн бол БНСҮ-аас олон удаагийн визийг зохих иргэдэд 2018 оны 10 дугаар сараас олгож эхэлсэн.

Хилийн чанадад өнөөдрийн байдлаар нийт 41 дипломат төлөөлөгчийн газар үйл ажиллагаа явуулж байна. Гадаадад зорчих, түр болон удаан хугацаагаар оршин суугаа монгол иргэдийн тоо тогтмол нэмэгдэж, 2019 оны 1 дүгээр сарын байдлаар гадаадын 76 улсад 175.0 мянган иргэн амьдарч байна. Засгийн газрын 2018 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн 179 дүгээр тогтоолоор Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сангийн дүрэм болон тус сангийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан.

Монгол Улсад зорчих гадаадын иргэдэд цахим виз (e-visa) олгох ажлыг эхлүүлж, тогтвортой, найдвартай, аюулгүй байдлыг хангах, [www.consul.mn](http://www.consul.mn) цахим хуудсыг бэхжүүлэх, дотоодын байгууллагуудын ажлын уялдаа холбоог сайжруулахад анхаарч байна.

**Олон улсын гэрээ, эрх зүйн харилцаа.** Манай улс 2018 онд “Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын Хүнс, хөдөө аж ахуйн ургамлын генетик нөөцийн олон улсын гэрээ”, “Азийн авто замын сүлжээгээр олон улсын авто тээвэрлэлт гүйцэтгэх тухай Монгол Улс, Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”, “Швейцарын Холбооны Улсын Женев хотод 1979 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр байгуулсан Дэлхийн худалдааны байгууллагын “Иргэний агаарын хөлгийн худалдааны хэлэлцээр”, “Олон улсын маргааныг энхийн замаар шийдвэрлэх тухай 1907 оны конвенц” зэрэг олон талт гэрээнд нэгдэн орж, Засгийн газар хоорондын 22 гэрээ байгуулж, өмнө нь байгуулсан 9 гэрээг хүчин төгөлдөр болгож, байгууллага хоорондын 65 гэрээ байгуулж бүртгэсэн бөгөөд гэрээний төсөлд санал өгөх, орчуулгыг хянах зэрэг нийт байгууллага хоорондын 128 гэрээ байгуулахтай холбоотой процесст оролцсон нь 2017 онтой харьцуулахад даруй 60.0 орчим хувиар нэмэгдсэн байна.

### **1.6.2. Батлан хамгаалах**

Батлан хамгаалах салбар төрийн батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааг улс орны хэмжээнд уялдуулан зохицуулах, Зэвсэгт хүчинээ хөгжүүлэн бэхжүүлэх, Монгол Улсын хуулиар хүлээсэн эх орноо гадны зэвсэгт халдлага, түрэмгийллээс өөрийгөө хамгаалах бэлтгэлийг хангах, агаарын хилийн халдашгүй дархан байдал, агаарын зайд хяналт тавих болон улс орноо улс төр, дипломатын аргаар хамгаалах төрийн бодлогыг хэрэгжүүлж ажиллаа.

Мөн тайван цагийн бусад чиг үүргээ хэрэгжүүлэхийн зэрэгцээ Монгол Улсын Их Хурал, Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний ерөнхий командлагч, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Засгийн газраас гаргасан тогтоол, зарлиг, зөвлөмж, шийдвэрийн хэрэгжилтийг ханган ажиллаж, улсыг хөгжүүлэх бүтээн байгуулалтын ажлуудад Зэвсэгт хүчиний бие бүрэлдэхүүн идэвхтэй оролцож байна.

**Эрх зүйн орчны шинэчлэл.** “Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-д тусгагдсан “Орон нутгийн хамгаалалтын тухай”, “Дайчилгааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”, “Улсын нисэхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”, “Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай”, “Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” зэрэг хуулиудын төслийг боловсруулан Улсын Их Хурлын 2018 хаврын чуулганаар батлуулж, хэрэгжилтийг хангаж байна.

“Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс” баримт бичгийн Зэвсэгт хүчний үүрэг, түүнийг хөгжүүлэх чиглэлүүд болон “Төрийн цэргийн байгууллагын хөгжлийн стратеги-2030”-д тусгагдсан зорилго, зорилтуудтай уялдуулан “Зэвсэгт хүчний байгуулалтыг 2020 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр”-ийг боловсруулан баталгаажуулж, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Батлан хамгаалахын сайдын тушаалаар батлуулж, хэрэгжилтийг хангаж байна.

Засгийн газрын 2018 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн 11 дүгээр тогтоолоор “Цэргийн гэрээт алба хаах журам”, 2018 оны 3 дугаар 27-ны өдрийн 80 дугаар тогтоолоор “Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах журам”, 2018 оны 8 дугаар сарын 15-ны өдрийн 249 дүгээр тогтоолоор 2019 онд цэргийн дүйцүүлэх алба хаах иргэдийн тооны дээд хязгаар, 2018 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 376 дугаар тогтоолоор “Аюулгүй байдал, батлан хамгаалах асуудлаар төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагын удирдах бүрэлдэхүүнтэй сургалт, дадлага явуулах журам”-ыг баталсан.

**Зэвсэгт хүчний шинэчлэл.** Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо болон Төсвийн байнгын хорооны гишүүд Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штабын үйл ажиллагаатай танилцаж, түүний мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний дагуу Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2018 оны “Чиглэл өгөх тухай” 2 дугаар тогтоол гарч, тогтоолын хэрэгжилтийг хангахыг Засгийн газарт даалгаад байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Оюутан цэрэг-2018” хөтөлбөрт Улаанбаатар хотоос 650 оюутан, хөдөө орон нутагт 350 нийт 1,000 орчим оюутанд “Цэргийн ерөнхий бэлтгэл” шатны сургалтыг орон нутагт, улмаар “Цэргийн мэргэжлийн бэлтгэл” сургалтыг Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн харьяа Шархад дахь Хээрийн сургалтын төв, Ховд аймаг дахь Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн хээрийн сургалтын төв, Дорнод аймаг дахь Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн хээрийн сургалтын төвд зохион байгуулж, нийт 980 оюутан-цэрэгт цэргийн мэргэжил олгосон байна.

Зэвсэгт хүчний цэргийн баг оролцуулах энхийг дэмжих ажиллагаа болон олон улсын хамтарсан сургалт, дадлага зохион байгуулах арга хэмжээний жагсаалтын дагуу Монгол Улсад болон бусад улсад зохион байгуулагдаж байгаа энхийг дэмжих ажиллагаа, олон улсын хамтарсан сургалт, дадлага, хээрийн сургуулийг амжилттай зохион байгууллаа. Тухайлбал, энхийг дэмжих ажиллагааны чиглэлээр бусад улс орнуудтай “Шийдвэртэй дэмжлэг”, “Хааны эрэлд-2018” олон улсын сургуулилт, Орос-Монголын хамтарсан “Сэлэнгэ 2018”, Монгол, Энэтхэгийн зэвсэгт хүчний хамтарсан “Нүүдэлчин заан 2018”, Катар Улстай хамтарсан “Шийдэмгийн шийдвэр”, “Анчин бүргэд” зэрэг сургалтуудыг хамтран зохион байгуулав.

Олон улсын энх тайван, аюулгүй байдлын асуудлаар зохион байгуулдаг бус нутгийн болон олон улсын дээд хэмжээний уулзалтад Батлан хамгаалах салбарын

төлөөлөгчид тогтмол оролцож Монгол Улсын аюулгүй байдлыг улс төр-дипломатын аргаар хангах төрийн бодлогыг хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулан ажиллаж байна.

# ХОЁР. МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2020 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ, 2021-2022 ОНЫ ХАНДЛАГА

## 2.1 ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГ, ГАДААД ОРЧИН

### 2.1.1 Дэлхийн эдийн засгийн төлөв

АНУ болон БНХАУ-ын хоорондын худалдааны маргаан, БНХАУ-ын эдийн засгийн өсөлтийн сааралтаас үүдэлтэй эмзэг байдлууд, Евро бүсийн эдийн засгийн сулрал, дэлхийн худалдаа болон үйлдвэрлэлийн бууралт, бодлогын тодорхой бус байдал, санхүүгийн зах зээлийн эрсдэл зэрэг нь дэлхийн эдийн засгийн өсөлтийг сааруулж болзошгүй гол хүчин зүйлс болоод байна.

ОУВС 2018 оны 10 дугаар сард нийтэлсэн “Дэлхийн эдийн засгийн төсөөлөл” тайландаа дэлхийн эдийн засгийн өсөлтийг 2019 болон 2020 онд 3.7 хувь байхаар төсөөлж байсан бол 2019 оны 4 дүгээр сард шинэчлэхдээ 3.3 болон 3.6 хувь болгон бууруулжээ.

*Хүснэгт 17. Дэлхийн эдийн засгийн өсөлт /хувь/.*

Бүс нутаг	2018	2019	2020
Дэлхий	3.6	3.3	3.6
Өндөр хөгжилтэй орнууд	2.2	1.8	1.7
АНУ	2.9	2.3	1.9
Евро бүс	1.8	1.3	1.5
Япон	0.8	1.0	0.5
Хөгжих буй орнууд	4.5	4.4	4.8
Хөгжих байгаа азийн орон	6.4	6.3	6.1
ОХУ	2.3	1.6	1.7
БНХАУ	6.6	6.3	6.1

Эх үүсвэр: ОУВС, “Дэлхийн эдийн засгийн төсөөлөл” тайлан, 2019 оны 4 дүгээр сар.

**АНУ-ын эдийн засгийн өсөлтийг ОУВС 2019 онд 2.3 хувь, 2020 онд 1.7 хувь байхаар төсөөлж байна.** 2018 онд тус улсын эдийн засгийн өсөлт харьцангуй өндөр 2.9 хувь байхад нөлөөлсөн төсвийн тэлэх бодлогоос үүдэлтэй эдийн засгийн идэвхжил ирэх онуудад саарах төлөвтэй байна. Түүнчлэн ажилгүйдлийн түвшин нам дор түвшинд хэвээр байгаа ба татварын шинэчилсэн бодлогын нөлөөгөөр хөрөнгө оруулалт нэмэгдэж, эдийн засаг эрчимжиж гадаад худалдааны алдагдал нэмэгдэх төлөвтэй байна. Гэвч БНХАУ-тай өрнүүлж буй худалдааны маргаан нь тус хоёр улс төдийгүй дэлхийн эдийн засгийн өсөлтийн төлөвт нөлөөлөхөөр байна.

**Евро бүсийн эдийн засгийн өсөлт буурч 2019 онд 1.3 хувь, 2020 онд 1.5 хувь байх төлөөвтэй байна.** Худалдааны маргаан, Хятадын эдийн засгийн өсөлтийн сааралт зэрэг гадаад орчны эрсдэлээс гадна Герман дахь автомашины түлшний хаягдлын шинэ стандартаас үүдэлтэй үйлдвэрлэлийн сааралт, Франц болон Италийн дотоодын эрэлтийн бууралт зэрэг нь Евро бүсийн эдийн засгийн өсөлтийг сааруулж болзошгүй байна. Түүнчлэн Брекситийн хэлэлцээрийн тодорхой бус байдал нь бизнесийн орчны итгэлцэл буурахад нөлөөлж байна. Мөн Европын Төв банк 2019 онд бодлогын хүүгээ хэвээр хадгалахаа зарлаад байгаа нь тус бүсийн эдийн засгийн төлөв сайнгүй байгааг илтгэж байна.

**Япон улс эдийн засгийн тэлэх бодлогоо хэвээр үргэлжлүүлнэ.** Япон улсын эдийн засгийн өсөлтийн төсөөлөл 2019 онд 1.0 хувь, 2020 онд 0.5 хувь байхаар төсөөлж байна. Тус улс төсвийн тэлэх бодлого хэрэгжүүлж байгаа бөгөөд 2019 оны 10 сараас хэрэгжиж эхлэх хэрэглээний татварын өсөлтөөс үүдэж болзошгүй эдийн

засгийн идэвхжлийн бууралтаас сэргийлэх зорилготой арга хэмжээнүүд бүхий 2019 оны төсвийн төсөл нь анх удаа 100 триллион иен давсан байна. Гэвч БНХАУ-ын эдийн засгийн өсөлтийн сааралт болон АНУ, БНХАУ-ын хоорондох худалдааны маргаан нь Японы өсөлтийн хурдыг сааруулж болзошгүй байна. Тус улсын БНХАУ руу чиглэсэн экспорт буурснаар худалдааны алдагдал өсөх хандлагатай байна.

**БНХАУ-ын эдийн засгийн өсөлтийн сааралт үргэлжилнэ.** БНХАУ-ын эдийн засгийн өсөлт 2018 онд сүүлийн 28 жилд байгаагүй доод түвшин буюу 6.6 хувьд хүрсэн ба худалдааны маргаан болон засгийн газраас нь хэрэгжүүлж буй санхүүгийн салбарын зохицуулалтыг чангараулах арга хэмжээнүүдээс шалтгаалан тус улсын эдийн засгийн өсөлт 2019 болон 2020 онд үргэлжлэн саарах төлөвтэй байна. БНХАУ-ын гадаад худалдааны эргэлт, аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлийн өсөлт сүүлийн саруудад буураад байна.


**ОХУ-ын эдийн засгийн өсөлтт саарна.** ОХУ-ын статистикийн хорооноос мэдээлснээр тус улсын эдийн засаг 2018 онд 2.3 хувиар өссөн бөгөөд үүнд барилгын салбарын идэвхжилт болон газрын тосны экспортын өсөлт нөлөөлсөн байна. Газрын тосны үнийн хэлбэлзэлээс шалтгаалан тус улсын эдийн засаг 2019, 2020 онд 1.6 болон 1.7 хувиар өсөх төлөвтэй байна гэж ОУВС үзжээ.

## 2.1.2 Голлох ашигт малтмалын бүтээгдэхүүний зах зээлийн хандлага

Зэс. Зэсийн үнэ 2018 онд дундажаар 6,530.0 ам.доллар байж, өмнөх оны дундажаас 6 орчим хувиар өссөн байна. Олон улсын мэргэжлийн шинжээчид зэсийн үнэ 2019 онд буурах, харин 2020 онд эргээд өсөхөөр төсөөлсөн байна.

2018 он хүртэлх зэсийн хэрэглээний статистикаас харахад БНХАУ-ын зэсийн хэрэглээ тогтвортсон бөгөөд энэ онд огцом өсөхөөргүй хандлагатай байна. Блуумбергийн мэргэжлийн байгууллагууд 2019 оны зэсийн үнийн төсөөллөө сүүлийн гурван сарын хугацаанд бууруулаад байна. Энэ нь дэлхийн эдийн засаг энэ онд саарч байгаатай холбоотой юм. Харин 2020 оны зэсийн үнийн талаар эерэг хүлээлттэй байгаа бөгөөд дийлэнх судлаачид үнэ өснө гэж таамаглажээ.

График 25. Зэсийн үнийн хөдөлгөөн, төсөөлөл /ам.доллар/тонн/.




Эх сурвалж: Блуумбэр

Зэсийн үнийг 2019 онд дундажаар 6,270.0 ам.доллар байхаар төсөөлж байна. Мөн зэсийн үнийг 2020 онд 6,340.0 ам.доллар буюу 2019 оны үнийн төсөөллөөс 70 ам.доллар буюу 1 хувиар өндөр байхаар төсөөлж байна.

**Алт.** Нэг унци алтны үнэ 2018 онд дундажаар 1270 ам.доллар байж, өмнөх оны дундажаас 1 хувиар өссөн. Алтны эрэлт 2018 онд 4,345.1 тонн хүрч, өмнөх оноос 4.5 хувиар нэмэгдсэн нь алтны үнийг өсөхөд нөлөөлсөн байна. Төв банкууд 2018 онд 651.5 тонн алт худалдан авч нөөцөлсөн нь 1971 оноос хойшхи хамгийн өндөр үзүүлэлт болж байна.

Олон улсын шинжээчид алтны ханшийг 2019 онд үргэлжлэн өснө гэж таамаглаж байна. Дэлхийн зах зээл дээрх алтны үнэ 2019 онд дундажаар 1,320.0 ам.доллар, 2020 онд дундажаар 1,330.0 ам.доллар байх төлөвтэй байна.

*График 26. Алтны үнийн хөдөлгөөн, төсөөлөл /ам.доллар/трай унц./*




Эх сурвалж: Блүүмбэр

Европ дахь эдийн засаг, улс төрийн тогтвортгүй байдал, хөгжингүй орнуудын төв банкны хэрэгжүүлж буй зөвлөн бодлого, зах зээл дээрх өндөр савалгаа зэрэг нь хөрөнгө оруулагчдыг алт худалдан авах шалтгаан болж байна. Бие даасан, мэргэжлийн олон шинжээчид 2019 болон 2020 оны алтны үнийн төсөөллөө өмнө таамаглаж байснаас нэмэгдүүлсэн байна.


**Төмрийн хүдэр.** Төмрийн хүдрийн үнэ 2018 онд дундажаар 64.8 ам.доллар байж, өмнөх оны дундажаас 20 орчим хувиар өссөн байна. Олон улсын байгууллагуудын төсөөллөөр төмрийн хүдрийн үнэ 2019 онд үргэлжлэн өсөх бол 2020 онд буурахаар байна. Сүүлийн жилүүдэд төмрийн хүдрийн үнэ өсч байгаа нь дэлхий нийтийн болон БНХАУ-ын гангийн эрэлт өндөр байгаатай холбоотой байна.

*График 27. Төмрийн хүдрийн үнийн хөдөлгөөн, төсөөлөл /ам.доллар/тонн/.*



Эх сурвалж: Блүүмбэр

График 28. Дэлхийн төмрийн хүдрийн үйлдвэрлэл /сая тонн/.




Эх сурвалж: Блүүмбэрг

Дэлхийн гангийн үйлдвэрлэл нь сүүлийн дөрвөн жилд дараалан өсч байгаа бөгөөд 2019 оны нэгдүгээр сард өмнөх оны мөн үеэс мөн өсөлттэй байна. 2019 оны 1 дүгээр сарын төмрийн хүдрийн эрэлт өнгөрсөн оны мөн үеэс өссөн бөгөөд дэлхий нийтийн гангийн эрэлтийн нэмэгдэх хандлагатай байна. Иймд шинжээчид 2019 оны төмрийн хүдрийн үнийг 70 ам.долларт хүргэж нэмэгдүүлээд байна.

**Нүүрс.** Австралийн сайн чанарын коксжих нүүрсний үнэ 2018 онд 10 орчим хувиар өсөж, 212 ам.долларт хүрсэн байна. Судалгааны байгууллагууд 2019, 2020 онд Австрали нүүрсний үнийг буурахаар төсөөлж байна.

БНХАУ-ын нүүрсний импорт сүүлийн 4 жил дараалан өсөөд байна. Нүүрсний импорт тогтвортой өндөр хэвээр байгаа ч шинжээчид нүүрсний үнийг буурна гэж төсөөлж байна. Энэ нь ойрын ирээдүйд нүүрсний нийлүүлэлт нэмэгдэхээр байгаатай холбоотой байна.


График 29. БНХАУ-ын нүүрсний импорт /сая тонн/.



Эх сурвалж: Блүүмбэрг

БНХАУ-ын нүүрсний импортын өсөлтийг дагаад манай улсын нүүрсний экспорт мөн сүүлийн 4 жил дараалан өссөн байна.


График 30. Монгол Улсын нүүрсний экспорт /сая тонн/.



Эх сурвалж: Блүүмбэр

**Газрын тос.** Газрын тосны үнэ 2018 онд дундажаар 62.0 ам.доллар байж, өмнөх оны дундажаас 20 орчим хувиар өссөн байна. Судлаачдын таамгаар газрын тосны үнэ 2019 онд буурах бол 2020 онд эргээд өсөхөөр байна. Сүүлийн саруудад ихэнх олон улсын судалгааны байгууллагууд 2019 оны газрын тосны үнийн төсөөллөө бууруулж, харин 2020 онд өсгөсөн байна.

График 31. Газрын тосны үнийн төсөөлөл /ам.доллар/баррель/.



Эх сурвалж: Блүүмбэр

## 2.2 МАКРО ЭДИЙН ЗАСАГ

### 2.2.1 Эдийн засгийн өсөлт

Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг 2020-2022 онд урт хугацааны өсөлтийн түвшинд буюу 6 орчим хувьд хүргэхээр зорьж байна.


Татварын шинэчлэлийн үр дүнд татвар төлөх үйл ажиллагаа хялбаршиж, татварын ачаалал буурахаас гадна Монгол улсад хөрөнгө оруулах бизнесийн орчин сайжруулсан. Үүний үр дүнд бизнесийн ашигт ажиллагаа дээшилж, хөрөнгө оруулалт нэмэгдэж, эдийн засгийн өсөлтийг дэмжихээр байна.

Оюутолгойн далд уурхайн бүтээн байгуулалтын ажил 2020 оноос дуусах шатандаа орж, хөрөнгө оруулалтын хэмжээ багасах хэдий ч газрын тосны үйлдвэр

барих, цэвэрлэх байгууламж барих төслүүд эрчимжиж, барилга, угсралтын ажил идэвхэжнэ. Ингэснээр эдийн засгийн өсөлтийг дэмжинэ.

Худалдааны дайн дэлхийн эдийн засаг, ялангуяа, манай худалдааны гол түнш орон болох БНХАУ-ын эдийн засгийн өсөлтийг сааруулж, экспортын гол нэр төрлийн бүтээгдэхүүний эрэлтэд сэргээр нэлөөлөхөөр байгаа хэдий ч зах зээлд ойр байдал, түүхий эдийн чанар, өртгөөр өрсөлдөх чадвараа тогтвортой хадгалах замаар экспорттоо нэмэгдүүлэх бодлого баримталж байна.

*График 32. Эдийн засгийн өсөлт болон ДНБ-ий хэмжээ.*



Эх үүсвэр: Сангиин яам

### 2.2.2 Хэрэглээ, хуримтлал


ДНБ-д эзлэх нийт хэрэглээний түвшин 2020-2022 онд тогтвортой байх хандлагатай байна. Дунд хугацаанд нийт хуримтлалын хэмжээ тэр дундаа үндсэн хөрөнгийн хуримтлалын хэмжээ өсөх төлөвтэй байна. Энэ нь Засгийн газраас Газрын тосны үйлдвэр, ДЦС-уудын өргөтгөл, Төв цэвэрлэх байгууламж, зам, гүүр зэрэг дэд бүтцийн томоохон төслүүдийн бүтээн байгуулалтыг эрчимжүүлэх, мөн хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт өсөхтэй холбоотой байна.

### 2.2.3 Ажилгүйдэл

Эдийн засгийн өсөлт, хүн амын хэтийн төлөвт үндэслэн тооцоход ажиллагчдын тоо жилд дунджаар 5.0 орчим хувиар өсөхийн зэрэгцээ ажиллах хүчний оролцооны түвшин сэргэх төлөвтэй байна. Энэ нь “Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030”-ын 2.2.1 зорилтын нэгдүгээр үе шаттай нийцтэй юм.

Дунд хугацаанд уул уурхай, эрчим хүч болон дэд бүтцийн томоохон төслүүдийг эрчимжүүлж, эдийн засгийн үндсэн зорилтуудыг хангасны үр дүнд ажилгүйдлийн түвшин 6.0-7.5 хувьд байхаар байна.

График 33. Хөдөлмөрийн үзүүлэлт, 2020-2022 оны төсөөлөл /хувь/.



Эх үүсвэр: Сангийн яам


#### 2.2.4 Инфляц

Инфляцийн түвшин дунд хугацаанд буюу 2020-2022 онд 8 орчим хувьд байхаар байна. Эдийн засгийн өсөлт идэвхжиж байгаа нь хүн амын худалдан авах чадвараар дамжиж, эрэлтийн гаралтай инфляци нэмэгдэх дарамтыг бий болгож байгаа бол ОПЕК-ийн орнууд нийлүүлэлтээ танах бодлого хэрэгжүүлж байгаатай холбоотойгоор гадаад зах зээлд газрын тосны үнэ өсөж болзошгүй байна. Гэсэн хэдий ч Засгийн газраас татварын багц хуулийн шинэчлэл хийж, бизнесийн орчныг сайжруулах, 1.5 тэрбумаас бага орлоготой аж ахуйн нэгжүүдийн орлогын албан татварыг 90 хувиар хөнгөлж байгаа зэрэг нь бизнесийн зардлыг бууруулж, үйлдвэрлэл, нийт нийлүүлэлтийг нэмэгдүүлэхээр байгаа тул инфляцийн түвшинг зорилтод хэмжээнд, тогтвортой байлгах боломж бүрдэхээр байна.

#### 2.2.5 Гадаад худалдаа

Монгол Улсын гадаад худалдааны нийт бараа эргэлт 2020 онд 14.5 тэрбум ам.долларт, 2021 онд 15.2 тэрбум ам.долларт, 2022 онд 15.9 тэрбум ам.долларт тус тус хүрч, гадаад худалдааны тэнцэл 2020-2022 онд дунджаар 1.5 тэрбум ам.долларын ашигтай гарахаар төсөөлж байна.

График 34. Гадаад худалдаа.




Эх үүсвэр: Сангийн яам

Экспорт 2020 онд өсөж, 7.8 орчим тэрбум ам.долларт хүрэхээр байна. Импорт 2020 онд 8.0 хувиар өсөж 6.7 тэрбум ам.долларт хүрэхээр төсөөлж байна. Дэд бүтцийн салбарт хийгдэх томоохон төслүүдийн хэрэгжилттэй холбоотойгоор барилгын материалын импорт өсөх төлөвтэй байна. Мөн уул уурхайн салбарын үйлдвэрлэл, экспортын өсөлтийг дагасан автобензин, дизель түлшний импорт өсөх төлөвтэй байна.

## 2.2.6 Төлбөрийн тэнцэл

Дунд хугацаанд уул уурхайн болон дэд бүтцийн томоохон төсөл, хөтөлбөрүүд хэрэгжихтэй холбоотойгоор импортын хэмжээ өсөх, үйлчилгээний дансны алдагдал нэмэгдэх төлөвтэй байгаа нь төлбөрийн тэнцлийн урсгал дансны алдагдлыг нэмэгдүүлэхээр байна.

График 35. Төлбөрийн тэнцэл, 2020-2022 оны төсөөлөл /сая ам.доллар/.



Эх үүсвэр: Сангийн яам

Дунд хугацаанд мөн хөрөнгө, санхүүгийн дансны ашиг буурахаар байгаа тул төлбөрийн тэнцлийн дарамт нэмэгдэж болзошгүй байна. Иймд Тавантолгой цогц төслийн хөрөнгө оруулалтыг шийдвэрлэж, хэрэгжилтийг эрчимжүүлнэ. Хөрөнгө,

санхүүгийн дансны өөрчлөлтөд нөлөөлөх гол хүчин зүйлс нь ГШХО, гадаад үнэт цаас, ОУВС-гийн ӨСХ-ийн хүрээнд орж ирэх төсвийн дэмжлэг зэрэг байна.

## 2.3 БОДИТ САЛБАРЫН ХӨГЖИЛ

### 2.3.1 Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр

Монгол малын ашигтай онцлог шинж чанарыг бататган сайжруулах цөм сүргийг баталгаажуулах үзлэг, ангилалтыг зохион байгуулах, малын үржил, селекцийн ажлын хүртээмж, үр дүнг дээшлүүлэх арга хэмжээний хүрээнд үзлэг ангилалт хийх малын тоог 1.5 сая толгойгоор нэмэгдүүлнэ.

Малын бүртгэл, мэдээллийн сан сүлжээг өргөтгөх, бүртгэлжүүлэлтийн ажилд дэвшилтэт технологи нэвтрүүлж, олон улсын шаардлагад нийцүүлэх арга хэмжээний хүрээнд малын бүртгэл мэдээллийн үндэсний нэгдсэн санд бүртгэх, яланг тэмдэглэх, хээлтүүлэгч болон цөм сүргийн малын тоог 1.5 сая толгойд хүргэнэ.

Мал, амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, мал сүргийг эрүүлжүүлэх хүрээнд урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамрагдах малын тоог 59 сая толгойд хүргэх, вакцинжуулалтын дараах тандалт шинжилгээнд хамруулах малын тоог 200 мянгад хүргэх, өвчнийг хяналтад авах, эрүүлжүүлэх стратегийг бүсчлэн хэрэгжүүлэх, халдварт өвчний тохиолдлыг эрт илрүүлэх, шуурхай хариу арга хэмжээ авах чадавхийг сайжруулна.

Бэлчээрийн ашиглалт, хамгаалалтын эрх зүй, хариуцлагын тогтолцоог, бэлчээрийн менежментийг сайжруулах арга хэмжээнд 1.7 тэрбум төгрөг төсөвлөн бэлчээрийн ашиглалтыг хариуцлагажуулсан аймгийн тооны өсөлт 50 хувиар өсөх, бэлчээрийн менежментийг хэрэгжүүлэхэд зарцуулсан хөрөнгийн санхүүжилтийг 30 хувиар нэмэгдүүлнэ. Ингэснээр малчид орон нутагтаа тав тухтай амьдрах, отор нүүдэл багасах, бэлчээрийн ургамал сэргэх, бэлчээрээс малын тэжээл нэмэгдэх ач холбогдолтой юм. Мөн малчид орон нутгаа хамгаалах, бэлчээр хамгааллын арга хэмжээг хэрэгжүүлэх технологи эзэмшиж суралцахын зэрэгцээ түр ажлын байраар хангагдан орлогоо нэмэгдүүлэх боломжтой болно.

Хүн амыг эрүүл, аюулгүй хүнсний бүтээгдэхүүнээр хангах хүрээнд “Эрүүл хүн-Эрүүл Монгол хүн” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, стратегийн хүнсний нийлүүлэлтийн улирлын хамаарлыг бууруулах зорилгоор “Max, сүүний анхдугаар аян”-ыг зохион байгуулсан. Хүн амын мах, сүүний хэрэгцээг тогтвортой хангах, улирлын хамаарлыг бууруулах зорилгоор гарал үүсэл нь баталгаажсан, эрүүл ахуй, ариун цэврийн шаардлага хангасан мал, сүүг үйлдвэр, цехэд нийлүүлсэн малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдэд дэмжлэг үзүүлэх эдийн засгийн механизмыг бий болгох, үйлдвэрийн аргаар боловсруулсан мах, сүүний хэмжээг нэмэгдүүлэх, мах, сүүний нөөцийг эдийн засгийн эргэлтэд оруулах, малчдын орлогыг нэмэгдүүлэх бодлого, арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Үр тарианы талбайн хөрсний үржил шимийг сайжруулах, ургацын хэмжээг нэмэгдүүлэх хүрээнд хураан авах үр тарианы хэмжээг 400 мянган тонноор нэмэгдүүлэх, усалгаатай талбайн хэмжээг 2500 мянган га-гаар нэмэгдүүлнэ.

Жижиг, дунд, үйлдвэрийг дэмжих, загвар хоршоодыг санхүү, зээлийн бодлогоор дэмжих хүрээнд ажлын байрны тоог нэмэгдүүлэх, импортыг орлох, экспортыг дэмжсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих, хоршоодын тоог нэмэгдүүлснээр хөдөө орон

нутгийн хөгжлийг дэмжих, төвлөрлийг сааруулах ялангуяа нийгэм, эдийн засгийн хөгжилд чухал хувь нэмэр оруулах юм.

Дотоодын үйлдвэрийн бараа, бүтээгдэхүүнийг сурталчлах, борлуулалтыг нэмэгдүүлэх зорилгоор гадаад орнуудад “Монголд үйлдвэрлэв” үзэсгэлэн худалдааг зохион байгуулж, экспортын чиг баримжаатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлнэ.

### 2.3.2 Уул уурхай

Уул уурхайн салбарт 2020 онд Оюу-Толгойн далд уурхайн бүтээн байгуулалт болон Тавантолгойн ордын ашиглалтыг өргөжүүлэн, хүчин чадлыг нэмэгдүүлэх төслийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлнэ.

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Геологи, уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлэх, уул уурхайн салбарын тогтвортой хөгжлийг хангах, олон улсын эрдсийн зах зээл дэх Монгол Улсын өрсөлдөх чадварыг дээшлүүлэх” гэсэн зорилтын хүрээнд эрдэс баялгийн салбарт хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлж, харилцан үр ашигтай төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, эрдэс баялгийн нөөцийг байгаль орчинд ээлтэй технологиор бүрэн ашиглаж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээ, нэр төрлийг нэмэгдүүлнэ.

Мөн уул уурхайн дэд бүтцийн хөгжлийн урт хугацааны төлөвлөлтийг боловсруулж, салбар хоорондын уялдааг хангах, хоёрдогч ашигт малтмал ашиглах эрх зүйн орчныг бий болгож, уурхайн нөхөн сэргээлт, хаалтыг олон улсын жишигт хүргэх, өнгөт болон хар төмөрлөг, нүүрс-хими, барилгын материалын үйлдвэрлэлийг дэмжиж ажиллана.

**Геологи.** Геологийн 1:50000-ны масштабтай зураглал, ерөнхий эрлийн ажлын хүрээнд үргэлжлэх 27 төслийг хэрэгжүүлснээр нийт нутаг дэвсгэрийн 7.6 хувийг, шинээр 10 төслийг хэрэгжүүлснээр нийт нутаг дэвсгэрийн 2.5 хувийг тус тус хамруулан, 2020 онд 1:50000-ны масштабтай зураглал, ерөнхий эрлийн ажлыг нийт нутаг дэвсгэрийн 45 хувьд хүргэнэ. Судалгааны ажлын хүрээнд 2021-2022 онд нийт 20 төслийг хэрэгжүүлснээр, нийт нутаг дэвсгэрийн 48 хувийг хамруулахаар төлөвлөж байна.

Улсын геологийн 1:200000-ны масштабын иж бүрдэл зургийг 2020 онд К хавтгайн хэмжээнд нэгтгэх ажлыг эхлүүлэн, 2020 онд К хавтгайн хэмжээнд нэгтгэх ажлыг дуусган, L хавтгайн хэмжээнд нэгтгэх ажлыг үргэлжлүүлнэ.

2021-2022 онд L хавтгайн хэмжээнд нэгтгэх ажлыг үргэлжлүүлэн, M болон И хавтгайн хэмжээнд нэгтгэх ажлыг шинээр хэрэгжүүлж ажиллана.

Геохимийн 1:1000000-ын масштабын зураг зохиох ажлын хүрээнд 2020 онд нутаг дэвсгэрийн 40 хувьд гүйцэтгэх бөгөөд 2021-2022 онд үлдсэн хэсгийн судалгааны ажлыг үргэлжлүүлнэ.

Ашигт малтмалын тархалтын зүй тогтол, хэтийн төлөвийг судлах ажлын хүрээнд 2020 онд “Томоохон хотуудын геоэкологи, гидрогеологийн судалгаа”, “Монгол орны голлох ашигт малтмалын хэтийн төлөвийн судалгаа”, “Геомэдээллийн сан төслийн судалгаа”, “Гадаад хамтын ажиллагааны судалгаа”, “Стратегийн ашигт малтмалын судалгаа” зэрэг сэдэвчилсэн судалгааны ажлуудыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

**Хүнд үйлдвэр.** Хүнд үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх зорилтын хүрээнд 2020 онд газрын тос боловсруулах үйлдвэрийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг дуусгаж, үйлдвэрийн барилгын ажлыг эхлүүлнэ. Мөн үйлдвэрийн түүхий тос дамжуулах хоолойн нарийвчилсан ТЭЗҮ-ийг хийж гүйцэтгэнэ.

Зэсийн баяжмал хайлуулах, цэвэршүүлэх үйлдвэр байгуулах ажлын хүрээнд үйлдвэрийн нарийвчилсан зураг төслийн ажлыг дуусгаж, үйлдвэрийн барилгын ажлыг эхлүүлэх хүрээнд хөрөнгө оруулагч талтай холбогдох гэрээ хэлэлцээрийг хийх ажлыг зохион байгуулж, үйлдвэрийн барилга угсралтыг ажлыг эхлүүлнэ.

Дархан, Сэлэнгийн бүсэд хар төмөрлөгийн цогцолбор байгуулах нөхцөлийг бүрдүүлэх зорилтын хүрээнд Төмөртэйн уурхайд хуурай болон нойтон соронзон баяжуулах үйлдвэр байгуулж, шууд ангижруулсан төмрийн үйлдвэр байгуулан, гангийн үйлдвэрийн өргөтгөл хийж, хүчин чадлыг нь нэмэгдүүлнэ.

Нүүрс угаах, гүн боловсруулах үйлдвэр болон нүүрснээс нийлэг байгалийн хий боловсруулах төслийн хөрөнгө оруулагч талтай холбогдох гэрээ хэлэлцээрийг хийж, үйлдвэрийн барилгын ажлыг эхлүүлнэ.

Мөн 2020 онд шатахуун импортлох, үйлдвэрлэх, хадгалах, бөөн болон жижиглэнгээр борлуулах үеийн чанарын хяналтын тогтолцоог сайжруулан, Евро-5 стандартын шаардлага хангасан шатахууны эзлэх хувийг нэмэгдүүлнэ.

### 2.3.3 Эрчим хүч

Эрчим хүчний салбарт 2020 онд дотоодын эрчим хүчний хэрэгцээг хангах эх үүсвэрүүдийн бүтээн байгуулалтын ажлуудыг үргэлжлүүлэн, сэргээгдэх эрчим хүчийг бодлогоор дэмжиж, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татах таатай нөхцөлийг бүрдүүлнэ.

Эрчим хүчний найдвартай хангамж, аюулгүй байдлыг хангах зорилтын хүрээнд “Чойбалсангийн дулааны цахилгаан станц”-ыг 50 МВт-аар өргөтгөх”, “Дулааны гуравдугаар цахилгаан станц”-ын өндөр даралтын хэсгийн суурилагдсан хүчин чадлыг 75 МВт-аар өргөтгөх, “Хоёрдугаар дулааны цахилгаан станц”-ын хүчин чадлыг 300 МВт-аар өргөтгөх, “Амгалангийн дулааны цахилгаан станц”-ыг 50 МВт-ыг өргөтгөх төслүүдийн барилга угсралтын ажлыг эхлүүлнэ.

Өмнийн бүсийн өсөн нэмэгдэж байгаа хэрэглээг хангах “Тавантолгойн 300 МВт-ын хүчин чадалтай цахилгаан станц”-ын барилгын ажлыг эхлүүлж, Багануурын 700 МВт-ын ДЦС барих төслийн барилга угсралтын ажлыг үргэлжлүүлнэ.

Мөн шинээр баригдахаар төлөвлөж буй томоохон цахилгаан станцууд болон үйл ажиллагаа явуулж буй дулааны цахилгаан станцуудыг нүүрсээр тасралтгүй хангах ажлын хүрээнд 2020 онд Шивээ Овоо, Багануурын нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх ажлыг үргэлжлүүлнэ.

Шивээ Овоо, Тэвшийн говь болон бусад нүүрсний ордыг түшиглэн экспортын зориулалттай том хүчин чадлын цахилгаан станц, тогтмол гүйдлийн цахилгаан дамжуулах шугам барих төслийн гэрээ хэлэлцээрийг хийж, санхүүжилтийг асуудлыг шийдвэрлэнэ.

Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг зохистой харьцаагаар хөгжүүлэх хүрээнд Эрдэнэбүрэнгийн УЦС барих төслийн санхүүжилтийг шийдвэрлэн, баруун бүсэд сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэх төслийн барилга угсралтын ажлыг үргэлжлүүлнэ.

Бүс нутгийн эрчим хүчний эх үүсвэрүүдийг холбосон цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцыг барьж эрчим хүчний нэгдсэн систем байгуулах ажлыг үргэлжлүүлнэ. Энэ хүрээнд 220 Кв-ын Дархан дэд станцыг өргөтгөх төсөл болон Төвийн бүсийн дамжуулах сүлжээний үр ашгийг нэмэгдүүлэх төслийн барилга угсралтын ажлыг тус тус эхлүүлнэ.

Аймгийн төвүүдэд байгаль орчинд ээлтэй дулааны станц, шугам сүлжээ барих ажлын хүрээнд Сүхбаатар аймгийн дулааны станцын хүчин чадлыг нэмэгдүүлэх, Архангай, Баянхонгор, Говь-Алтай, Говьсүмбэр, Дундговь, Завхан, Өвөрхангай, Хэнтий, Төв аймгуудад байгаль орчинд ээлтэй дулааны станц, дулааны шугам сүлжээний барилга угсралтын ажлыг үргэлжлүүлнэ.

Эрчим хүчний хэмнэлт, үр ашгийг дээшлүүлэх ажлын хүрээнд Багануур, зүүн өмнөд бүс, Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээний алдагдлыг бууруулах төслийг хэрэгжүүлнэ.

#### 2.3.4 Зам, тээвэр

Азийн авто замын сүлжээний АН4 чиглэлийн авто замыг бүрэн ашиглалтад оруулах, үлдэж буй таван аймаг болох Говь-Алтай, Ховд, Завхан, Увс, Баян-Өлгий аймгийг нийслэл хоттой хатуу хучилттай авто замаар холбож дуусгах, хилийн боомтуудыг аймгийн төвүүдтэй холбох ажлыг эхлүүлж, зарим боомтыг холбож дуусгах, орон нутгийн хөгжил болон тухайн бүс нутгийн ард иргэдийн амьжиргааг дээшлүүлэхэд чиглэгдсэн орон нутгийн чанартай авто замыг үе шаттайгаар барьж байгуулах, нийслэл хотын авто замын сүлжээг өргөтгөн хөгжүүлэх хүрээнд авто зам, гүүрэн гарц барих зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэнэ.

*Хүснэгт 18. Олон улс, улсын чанартай авто замын сүлжээн дэх хатуу хучилттай авто зам /км/.*

Үзүүлэлт	Хэмжих нэгж	Дараах онуудад					
		2015	2016	2017	2018	2019	2020
Хатуу хучилттай авто замын сүлжээний урт	км	5684.62	6402.72	6934.12	7294.52	7923.82	8663.8
Сүлжээнд эзлэх хувь	хувь	44.7	50.3	54.5	57.4	62.3	68.1

Эх үүсвэр: Зам, тээврийн хөгжлийн яам

Улаанбаатар хотын хүн амын өсөлттэй уялдуулан хотын иргэдийн эрэлт хэрэгцээг бүрэн хангахуйц автозамын сүлжээ, тээврийн дэд бүтцийг бий болгох, хотын замын хөдөлгөөний зохион байгуулалтыг сайжруулж, түгжрэл, агаарын бохирдлыг бууруулах зорилготой нийтийн тээврийн шинэ төрөл болох Тусгай замын автобусны үйлчилгээг нэвтрүүлэхээр төлөвлөж байна.

Төмөр замын салбарт гадаадын зээл, тусламж болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар “Тавантолгой-Гашуунсухайт”, “Нарийнсухайт-Шивээхүрэн”, “Эрдэнэт-Овоот”-ын чиглэлийн төмөр замын томоохон төслийдийн бүтээн байгуулалтын ажлыг үргэлжлүүлнэ.

Говь-Алтай, Завхан, Өмнөговь, Дорнод, Ховд, Хэнтий зэрэг аймаг болон томоохон сумдын нисэх онгоцны буудлуудын хүчин чадлыг нэмэгдүүлнэ.

### **2.3.5 Барилга, хот байгуулалт**

“Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл”-ийг боловсруулна.

Монгол Улсын нутаг дэвсгэрийг бүрэн зурагжуулах, шинэчлэх, геодезийн нэгдсэн сүлжээг бий болгох ажлын хүрээнд 1:25000 масштабтай байр зургаар зурагжуулах, геодезийн сүлжээний эхлэл цэгийг байгуулах, өндрийн II дугаар ангийн сүлжээний хайгуул, судалгааны ажлуудыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинэчлэх ажлын хүрээнд цэвэрлэх байгууламжийн барилга угсралтын ажлыг эхлүүлнэ.

Ногоон сууц загвар төслийг хэрэгжүүлж, 2020 онд төслийн хүрээнд 80 айлыг хамруулна.

### **2.3.6 Аялал жуулчлал**

Тогтвортой аялал жуулчлалын дэд бүтэц, бүрэлдэхүүн, үйлчилгээний чанарыг сайжруулах цогц бодлого хэрэгжүүлж, тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх хүрээнд аялал жуулчлал, мэдээлэл сурталчилгааны хөгжлийн Соёмбо цогцолбор төв /Хөвсгөл, Мөрөн сум/, Шихихутаг нууц товчоо түүхэн аялал жуулчлалын цогцолборын барилга /Хэнтий, Норовлин сум/, Дарьганга зусланг орчин үеийн стандартад нийцсэн амралт, аялал жуулчлалын цогцолбор болгон шинэчлэх /Сүхбаатар, Дарьганга сум/, Хар нуурын орчмын аялал жуулчлалын дэд бүтэц төсөл/ Завхан, Улиастай сум/ зэрэг хөрөнгө оруулалтын төслүүдийг хэрэгжүүлнэ.

### **2.3.7 Мэдээлэл, шуудан, харилцаа, холбоо**

“Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, “Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, “Төрөөс мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлого (2017-2025)”-д тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Мэдээлэл, харилцаа холбооны салбарын хэмжээнд 2020 онд Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор зарим сумдад төрийн цахим үйлчилгээний "Хур" системийг нэвтрүүлэх, алслагдсан сумдыг өргөн зурvasын шилэн кабелийн сүлжээнд холбох ажлыг үргэлжлүүлэх, төрөөс цахим хэлбэрээр хүргэх үйлчилгээний нэр төрөл, хүртээмжийг нэмэгдүүлж, цахим албан хэрэг хөтлөлтийн нэгдсэн системийг хөгжүүлэх, хиймэл дагуулын болон газрын сүлжээний радио давтамжийн автоматжуулсан систем нэвтрүүлэх зэрэг арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Мэдээлэл, харилцаа холбооны үзүүлэлт 2020 онд 21 аймгийн 322 сум шилэн кабельд холбогдож шилэн кабелийн нийт урт 39.3 мянган км болохоор байна.

## **2.4 ХҮНИЙ ХӨГЖИЛ**

### **2.4.1 Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбар**

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр 6 хөтөлбөр хэрэгжүүлнэ.

Бичил аж ахуйн нэгж, иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг зээлийн бодлогоор дэмжинэ.

Монгол залуусаа сургаж дадлагажуулан ажлын байраар хангаж, гадаадаас авах ажиллагчдын тоог 50.0 хувиар бууруулна.

Инфляцийн түвшинтэй уялдуулан төрийн албан хаагчдын цалинг нэмэгдүүлнэ.

Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлнэ.

Хүүхдийн хөгжил, хамгаалал, Θсвөр үе, залуучуудын хөгжлийг дэмжих, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих бодлого хэрэгжүүлнэ.

Нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөжүүлэх, тэтгэврийн даатгалын тогтолцоог шинэчлэх болон Нийгмийн халамжийн эрх зүйн орчинг боловсронгуй болгоно.

Инфляцийн түвшинтэй уялдуулан Нийгмийн даатгалын сан болон Нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлнэ.

Мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв, Политехникийн коллежид элсэн суралцагчдын тоог нэмэгдүүлж, төгсөгчдөд мэргэжил, ур чадварыг эзэмшигүүлэн, суралцагчдад 100 мянган төгрөгийн тэтгэлгийг сар бүр олгоно.

#### 2.4.2 Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спорт

Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтыг нэмэгдүүлж, шинээр 42 цэцэрлэгийг ашиглалтад оруулж, боловсролын үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлнэ.

Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын ая тухтай сурч боловсрох орчин нөхцөлийг бүрдүүлж, шинээр 66 сургуулийн барилгыг ашиглалтад оруулж, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн онцлог, хэрэгцээнд тохирсон сургалтын орчин, дэд бүтцийг бүрдүүлнэ.

Судалгаанд суурилсан их сургуулиудыг хөгжүүлж, дээд боловсролын сургалтын байгууллагын багшийн хөгжлийг дэмжинэ.

Шинжлэх ухаан, технологийн салбарыг хөгжүүлж, судалгаа боловсруулалтын ажлын эдийн засаг, нийгмийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ.

Соёл, урлаг, спортын салбарын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, соёлын үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.

#### 2.4.3 Эрүүл мэнд

Зонхиолон тохиолдох өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх хариу арга хэмжээг чанартай, хүртээмжтэй зохион байгуулж, шинээр 37 эмнэлгийг ашиглалтад оруулж, тандалт эрт илрүүлгийн тогтолцоог бэхжүүлнэ.

Нөхөн үржихүйн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг дэмжих замаар эх, хүүхдийн эндэгдлийг бууруулна.

Хүн амын өвчлөл, нас барагтын тэргүүлэх шалтгаан болж буй зүрх судас, хорт хавдраас үүдэлтэй нас барагтыг бууруулна.

Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, дархлаажуулалтын үйл ажиллагааг өргөжүүлнэ.

Эрүүл мэндийн даатгалд хамрагддаг эмчилгээ үйлчилгээний хамрах хүрээг нэмэгдүүлж, Эмч эмнэлгийн мэргэжилтний чадавхийг бэхжүүлэн, Монгол Улсад оношлох, эмчлэх боломжгүй өвчнийг өөрийн эх орондоо оношилж эмчилдэг болгоно.

## **2.5 БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖИЛ**

### **2.5.1 Байгаль орчин, ногоон хөгжил**

Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг салбар дундын уялдаа, нэгдсэн зохицуулалттайгаар хэрэгжүүлж, түүхий нүүрсний хэрэглээг 2019 оны 5 дугаар сараас Улаанбаатар хотын гэр хорооллын бүсэд бүрэн халж, агаарын бохирдлын эх үүсвэрийг багасгаж, хөтөлбөрт туссан ажлуудыг холбогдох яамдын оролцоотойгоор үе шаттай хэрэгжүүлнэ. Энэ хүрээнд гэр хорооллын өрхийн шөнийн цахилгаан эрчим хүчний хөнгөлөлт үзүүлэх, урамшууллыг тогтоосон хугацаанд хэрэгжүүлнэ.

Агаарын бохирдлыг бууруулахад агаарын чанарыг сайжруулах бүсийн халаалтаа цахилгаанаар шийдсэн гэр хорооллын айл өрхөд шөнийн цахилгааны үнийн урамшуулал олгох, сайжруулсан түлш үйлдвэрлэж түгээх, иргэд худалдан авахад дэмжлэг үзүүлэх, гэр хорооллын айл өрхийг цахилгаан халаагуураар халаах техникийн боломжийг бүрдүүлэх, нийслэл хотод үйл ажиллагаа явуулж байгаа халаалтын зуухыг үе шаттайгаар буулгаж, хэрэглэгчдийг төвлөрсөн дулаан хангамжид холбох, Улаанбаатар хотын агаарын бохирдол ихтэй гэр хорооллыг сонгон “Бичил дэд төв”-үүдийг байгуулах, гэр хорооллын иргэдийг орон сууцжуулах ажлыг эрчимжүүлэн бага, дунд орлоготой иргэдийг урт хугацаатай, бага хүйтэй зээлд хамруулах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Ой хамгаалал, ойжуулалтын ажлыг чанаржуулж, ойн нөхөн сэргээлт хийж, байгалийн сэргэн ургалтыг дэмжих зорилтын хүрээнд 50 мянган га-гаас багагүй талбайд ойн хөнөөлт шавьжийн тэмцлийн ажил гүйцэтгэж, 12000-аас доошгүй га талбайд ойжуулалт, ойн сэргэн ургалтыг дэмжих ажлыг зохион байгуулж, ойн цэвэрлэгээг 30 мянгаас доошгүй талбайд хийж гүйцэтгэнэ

Хот суурин газрын хүн амын унд ахуй болон үйлдвэрлэлийн ус хангамжийг сайжруулах хүрээнд гидрологийн дунд масштаб /1:200 000/-ын зураглалын ажлыг хийж, 5-аас доошгүй суурин газрын унд ахуйн ус хангамжийн эх үүсвэрийн нөөцийг тогтоон баталгаажуулна. Усны нөөцийг зүй зохистой ашиглах хуримтлуулах, дахин ашиглах чиглэлээр бороо, цасны усыг хуримтлуулах хөв цөөрмийг орон нутагт 3-аас доошгүй газарт байгуулж, 100-аас доошгүй булаг шандын эхийг хашиж хамгаална.

## **2.6 ЗАСАГЛАЛ, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ШИНЭТГЭЛ**

### **2.6.1 Хууль, эрх зүйн шинэтгэл**

Цагдаагийн байгууллагын хэт богино долгионы радио холбоог шинэчилж, мэдээ, мэдээллийн нууцлал, аюулгүй байдал, үйл ажиллагааны шуурхай байдлыг хангана.

Хилийн салбарын парк шинэчлэл хийнэ.

Шүүхийн шинжилгээний байгууллагын дижитал судлалын шинжилгээний чадавхийг сайжруулна.

Визийн зөвшөөрөл, хувийн урилга олгох үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх программ хангамжийг нэвтрүүлнэ.

“ISM” системийн өргөтгөл, сайжруулалтын хүрээнд “APIS буюу APP” системийг холбож, мэдээлэл солилцох боломжийг нэмэгдүүлнэ.

Гадаадын иргэдэд үйлчилгээ үзүүлэхэд шаардагдах бичиг баримтуудын бүрдлийг онлайн хэлбэрээр бүрдүүлэх боломж бүхий төрийн байгууллагуудын хооронд холбосон дэд бүтэц, системийг бий болгоно.

Их сургуулийн шинжлэх ухаан, инновацийн чадавхийг нэмэгдүүлж, сургалтын хөтөлбөрийн агуулгыг шинжлэх ухаан, технологийн ололт, төрийн бодлоготой уялдуулан, багш судлаач, албан хаагч, сонсогчдын чадавхийг нэмэгдүүлнэ.

Төрийн архивуудын баримтыг цахим хэлбэрт шилжүүлнэ.

## 2.6.2 Төрийн өмчийн бодлого, зохицуулалт

Алдагдалтай ажиллаж байгаа төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа, эдийн засгийн байдалд судалгаа, дүн шинжилгээ хийж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлон хэрэгжилтийг хангаж ажиллана.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн талаар нэгдсэн удирдамж, бодлого зохицуулалтаар хангаж, төрийн өмчит үйлдвэрийн газар зөвхөн хувьцаа эзэмшигчийн эрх, үүргээ хэрэгжүүлдэг байх хууль эрх зүйн орчныг бий болгох чиглэлээр ажиллана.

Төрийн өмчийн хувьчлалын бодлогыг хэрэгжүүлэхдээ улс орны эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах зорилгоор хувийн хэвшлийн үр өгөөж бүхий хөрөнгө оруулалтыг татах, төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд төрийн оролцоог багасгах эдийн засгийн бүтцийг бий болгох, хувьчлалыг хууль эрх зүйн хүрээнд ил тод, нээлттэй хэрэгжүүлэх, төрийн өмчлөлөөр дамжуулан зохицуулж байгаа төрийн зохицуулалтыг багасгаж, зах зээлийн харилцаанд шилжүүлэх үндсэн зарчмыг баримтална.

## 2.6.3 Стандарт, хэмжил зүй

Экспортын тэргүүлэх салбарын бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих зорилтын хүрээнд ноос, ноолуур, арьс шир, оёмол бүтээгдэхүүн, аялал жуулчлал, хүнсний салбарын үндэсний стандартыг шинээр боловсруулж мөрдүүлэх бөгөөд ингэснээр олон улсын нийтлэг зарчим, практикт нийцсэн эрх зүйн орчин бүрдэж, үндэсний үйлдвэрлэлийг дэмжих, гадаад худалдааг хөнгөвчлөх өргөн боломж, нөхцөлийг бүрдүүлэх, худалдаан дахь саад тогторыг арилгах, иргэд, аж ахуйн нэгжүүдийн экспортыг дэмжинэ.

Орон нутгийн стандартын байгууллагын чадавхыг бэхжүүлэх хүрээнд Стандарт, хэмжил зүйн хэлтсийн барилгыг ашиглалтад оруулна.

Олон улсын түвшинд хүрсэн үндэсний стандартын эзлэх хувийг 37.0 хувьд хүргэх төлөвлөгөөтэй байна.

## 2.6.4 Улсын мэргэжлийн хяналт

Мэргэжлийн хяналт шалгалтын эрх зүйн орчныг боловсронгуй болгон, мэргэжлийн хяналтын байгууллагын эрсдэлийн удирдлагын стратегийг хэрэгжүүлэхэд нэгдсэн бодлого, арга зүй, зохион байгуулалтаар ханган хяналт, шалгалтын үр дүнгээр эрсдэлийг удирдах нөхцөлийг бүрдүүлж шалгуулагч этгээдийн хууль сахин мөрдөлтийн түвшинг дээшлүүлэх арга хэмжээ авч ажиллана.

Орон нутгийн мэргэжлийн хяналтын байгууллагын чадавхыг бэхжүүлэх хүрээнд 2 аймагт мэргэжлийн хяналтын хэлтсийн барилгыг барьж ашиглалтад оруулах арга хэмжээг тусгасан.

## **2.6.5 Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах**

Өрсөлдөөний тухай болон Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийг өөрчлөгдөн шинэчлэгдэж байгаа зах зээлийн шаардлагад нийцүүлж боловсронгуй болгох шаардлага байгаа тул Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газраас 2018-2020 онд Өрсөлдөөн ба хэрэглэгчийн эрхийн бодлого, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, Монгол Улсын зах зээлд шударга өрсөлдөөний орчин нөхцөлийг хангаж ажиллах чиглэл баримтална.

## **2.6.6 Онцгой байдал**

“Гамшигийн эрсдэлийг бууруулах Сендан үйл ажиллагааны хүрээг Монгол Улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги /2018-2030/”, Улсын Их Хурлын 2011 оны 22 дугаар тогтоолоор батлагдсан “Гамшигаас хамгаалах чадавхыг бэхжүүлэх үндэсний хөтөлбөр (2011-2020)”, Засгийн газрын 2015 оны 303 дугаар тогтоолоор батлагдсан “Гамшигийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөр (2015-2025)”-ийг салбарын хэмжээнд хэрэгжүүлнэ.

Онцгой байдлын байгууллагын үйл ажиллагааны хүрээнд 2020 онд гамшигаас хамгаалах мэргэжлийн байгууллагын чадавхыг бэхжүүлж, гамшигийн үеийн бэлэн байдлын түвшинг дээшлүүлэх зорилтын хүрээнд гал түймэр унтраах, аврах анги, эрэн хайх аврах салбар, бүлгийн чадавхыг бэхжүүлэх, онцгой байдлын албаны техник, тоног төхөөрөмжийн чадавхыг сайжруулах арга хэмжээг гадаадын зээл тусlamжийн эх үүсвэрээр хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

Хүн амын нягтрал, тохиолдож байгаа гамшигийн төрөл, давтамжийг харгалзан томоохон хот, сууринг түшиглэн гамшигийн голомтод шуурхай үүрэг гүйцэтгэх хүч хэрэгслийг нэмж байршуулах, бэхжүүлэх арга хэмжээг дэс дараатай авч хэрэгжүүлэн, бэлэн байдлыг хангулна. Төв орон нутгийн анги, байгууллагуудыг бие дааж ажиллах, шаардлагатай аврах ажлын зориулалттай машин техник, тусгай хувцас, багаж хэрэгслээр хангах ажлыг үе шаттайгаар хөрөнгө оруулалт, гадаад орон, олон улсын байгууллагуудын зээл, тусlamж, төсөл, хөтөлбөрөөр үргэлжлүүлэн шийдвэрлэнэ.

## **2.7 ГАДААД ХАРИЛЦАА, БАТЛАН ХАМГААЛАХ**

### **2.7.1 Гадаад харилцаа**

Гадаад харилцааны салбарт энхийг эрхэмлэсэн, нээлттэй, олон тулгуурт бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлж хөрш орнуудын эдийн засаг, нийгмийн хамтын ажиллагааг өргөжүүлэх хүрээнд ОХУ-тай тогтоосон стратегийн түншлэлийн харилцаа, БНХАУ-тай тогтоосон иж бүрэн стратегийн түншлэлийн харилцааны агуултыг баяжуулах, эдгээр орнуудтай тэнцвэртэй харилцааг хөгжүүлэх, хамтын ажиллагааны бодит үр өгөөжийг нэмэгдүүлэх, Монгол, Оросын стратегийн түншлэлийг хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөр болон Монгол, Хятадын Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх, гурван талын хамтын ажиллагааг хөгжүүлэх, “Эдийн засгийн коридор” байгуулах хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх тэргүүлэх зорилтыг дэвшүүлж ажиллана.

Гадаад худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, гадаадын хөрөнгө оруулалтыг татах, гадаад худалдааг хөнгөвчлөх, экспортыг дэмжих бүхий л боломжийг эрэлхийлж ажиллана.

НҮБ болон олон улсын бусад байгууллагын үйл ажиллагаа, олон талт яриа хэлэлцээнд дээд, өндөр түвшний төлөөлөгчид оролцуулж, олон улсын тулгамдсан асуудлаар байр сууриа илэрхийлэх, Зүүн хойд Азийн Аюулгүй байдлын асуудлаарх “Улаанбаатарын яриа хэлэлцээ” санаачилгыг бэхжүүлэх, Монгол Улсын санаачилсан аливаа санал, санаачилгыг урагшлуулах, ардчилал, засаглал, нийгмийн хөгжил, соёл, хүмүүнлэгийн асуудлаарх олон улсын байгууллага, механизмуудтай тогтоосон хамтын ажиллагаагаа өргөжүүлэх, олон улсын болон бүс нутгийн байгууллагын хурал зөвлөгөөнийг өөрийн оронд зохион байгуулна.

Хил орчмын дэд бүтцийг хөгжүүлж, хөрш орнуудтай хийх худалдааг өргөжүүлэх зорилтын хүрээнд хөрш орнуудтай хийх гадаад худалдааг өргөжүүлэх зорилгоор хил дамнасан эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулах ажлыг эрчимжүүлэх хүрээнд Замын үүд-Эрээний эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулж, үйл ажиллагааг эхлүүлэх, Монгол Улс-ОХУ-БНХАУ-ын “Эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх Хөрөнгө оруулалт, зураг төслийн хамтарсан төвийг байгуулах ажлыг эрчимжүүлэх, хилийн чанад дахь монгол иргэдийн эрх ашгийг хамгаалах, тэдэнд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, үйлдвэрлэл, экспортын таатай, тогтвортой орчин бүрдүүлэх замаар уул уурхайн бус бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний экспортыг дэмжих, экспортын бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, худалдааг хөнгөвчлөх, экспортын зах зээлийн хүрээг тэлэх арга хэмжээг шат дараатай авч хэрэгжүүлж Монгол Улсын эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах зорилготой “Монгол Экспорт” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

## 2.7.2. Батлан хамгаалах

Монгол Улсын батлан хамгаалах эрх зүйн орчныг төгөлдөржүүлж, улс орныг батлан хамгаалах чадавхыг бэхжүүлж, Зэвсэгт хүчний хөгжлийг эрчимжүүлэн батлан хамгаалах тогтолцоог боловсронгуй болгож, түүнийг хэрэгжүүлэх талаар батлан хамгаалах чадавхыг хөгжүүлэх “Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс”, “Төрийн цэргийн байгууллагын хөгжлийн стратеги-2030”, “Зэвсэгт хүчний байгуулалтыг 2020 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр”, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, батлан хамгаалах хэрэгцээ, шаардлагад нийцсэн, уян хатан, оновчтой батлан хамгаалах нэгдмэл тогтолцоог бүрдүүлэх, зорилтыг хэрэгжүүлнэ.

Энхийг сахиулах ажиллагааны чадавхийг нэмэгдүүлж, “Барилгын засвар” төслийг үргэлжлүүлэх зорилтын хүрээнд Зэвсэгт хүчний энхийг дэмжих үйл ажиллагааны чадавхыг нэмэгдүүлж, НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэх бие бүрэлдэхүүнийг чадавхжуулж, оролцуулснаар Монгол Улсын энхийг дэмжих ажиллагаанд оролцох үндэсний байнгын хүчний чадавхи нэмэгдэж, улс орныхоо тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг улс төр-дипломатын аргаар хангах төрийн бодлогыг хэрэгжүүлэхэд чухал алхам болно.

Зэвсэгт хүчний хээрийн хөдөлгөөнт холбооны зангилааг шинэчлэх, хээрийн удирдлагын байруудад сансрын холбооны бага оврын станцуудыг суурилуулах, зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллагуудыг шилэн кабелийн нэгдсэн сүлжээнд холбох, “Барилгын засвар” төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж Зэвсэгт хүчний анги,

салбаруудын зарим барилга байгууламжийн тохижилт, их засварын ажлыг гүйцэтгэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Олон улсын болон бус нутгийн аюулгүй байдлын орчны төлөв, өөрчлөлтийн хандлагад нийцүүлэн, үндэсний аюулгүй байдлыг хангахуйц батлан хамгаалах бодлогыг хэрэгжүүлж, улс орны хөгжлийн зорилго, үндэсний язгуур ашиг сонирхолд тулгуурласан уян хатан, оновчтой батлан хамгаалах нэгдмэл тогтолцоог төлөвшүүлэх үндсэн дээр улс орныхоо тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, хүний аюулгүй байдлыг найдвартай хангах зорилтыг ирэх жилүүдэд дэвшүүлэн ажиллана.

“Зэвсэгт хүчний байгуулалтыг 2020 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр”-ийн хүрээнд 119 арга хэмжээг хэрэгжүүлнэ.

## ГУРАВ. ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД УЧИРЧ БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛҮҮД

**Нэг.** АНУ болон БНХАУ-ын хоорондын худалдааны маргаан цаашид хэрхэх, БНХАУ-ын эдийн засгийн өсөлтийн сааралт түүхий эдийн эрэлтэд хэрхэн нөлөөлөх, мөн БНХАУ болон бусад томоохон орнуудын хэрэгжүүлж буй бодлого өөрчлөгдөх зэрэг гадаад орчны, тодорхой бус хүчин зүйлүүд нь экспортын түүхий эдийн үнэ, эрэлтэд нөлөөлөх эрсдэл байна.

**Хоёр.** Чингис, Мазаалай бонд, БНХАУ-ын төв банктай хийсэн своп хэлцэл, ХХБ-ны бонд, МИК-ын бонд зэрэг ирэх онуудад төлөгдөх хуваарьтай гадаад төлбөрүүд их байгаа тул валютын гадагшлах урсгал өндөр байхаар байна. Мөн Оюутолгой төслийн хоёр дахь шатны хөрөнгө оруулалт хийгдэж дуусахаар байгаагаас валютын дотогшлох урсгал буурч болзошгүй байна. Иймд Тавантолгойг цогцолбороор хөгжүүлэх зэрэг дараагийн томоохон төслүүдийг цаг алдалгүй хэрэгжүүлэхгүй бол төлбөрийн тэнцэл, валютын ханшид дарамт учирч эдийн засагт сөргөөр нөлөөлөх эрсдэл байна.

**Гурав.** Уул уурхайн бус салбарын экспортыг нэмэгдүүлэх хүрээнд махны экспортыг цаашид ч нэмэгдүүлэх шаардлага байна. Харин нийлүүлэлтийн сүлжээг сайжруулахад чиглэсэн зохион байгуулалтын арга хэмжээ шуурхай авахгүй бол экспортод гаргах махны хэмжээ нэмэгдэхийн хэрээр дотоодын зах зээлд хомсдол үүсэх, махны үнэ өсөх замаар инфляцыг өдөөх эрсдэл байна.

**Дөрөв.** Дэлхийн эдийн засгийн өсөлт эрчимжиж байгаа ч геополитикийн тодорхой бус нөхцөл байдал үргэлжилж байгаа нь манай улсын экспортын гол бүтээгдэхүүн болох зэс, нүүрс, алт, газрын тос зэргийн үнийн тогтвортгуй байдлыг бий болгох магадлалтай.

## ДӨРӨВ. МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2020 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ШААРДАГДАХ ХӨРӨНГИЙН ТООЦОО

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл нь Макро эдийн засгийн бодлого, Эдийн засгийн өсөлтийг дэмжих салбаруудын бодлого, Бүс нутаг, хөдөөгийн хөгжил, байгаль орчны бодлого, Хүний хөгжлийг дэмжих нийгмийн бодлого, Засаглал, эрх зүйн шинэчлэл, гадаад бодлого, батлан хамгаалах салбарын бодлого гэсэн нийт 5 бүлэг, 20 зорилт, 114 бодлогын арга хэмжээг тусгаснаас гадна зорилт, арга хэмжээ бүрийн шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин, шаардагдах санхүүжилт, хөрөнгийн эх үүсвэр, урт болон дунд хугацааны хөтөлбөр, бодлогын баримт бичгүүдтэй уялдсан байдал, хариуцан хэрэгжүүлэх байгууллагыг мөн тусгасан.

Салбарын яамд, агентлагуудаас ирүүлсэн арга хэмжээний саналуудыг үндсэн чиглэлийн төсөлд тусгахдаа бодлогын зорилт, арга хэмжээг улсын төсөв болон бусад хөрөнгийн эх үүсвэрийн боломжтой уялдуулан 20 зорилт 118 арга хэмжээний хүрээнд нийтдээ 10 их наяд 216.3 тэрбум төгрөгийг санхүүжүүлэхээс улсын төсвийн хөрөнгөөр 1 их наяд 325.5 тэрбум төгрөг, гадаад эх үүсвэрээс 2 их наяд 111.9 тэрбум төгрөг, төр, хувийн хэвшлийн түншлэл болон хувийн хөрөнгө оруулалтаар 6 их наяд 174.2 тэрбум төгрөг, бусад эх үүсвэрээс 604.7 тэрбум төгрөгөөр тус тус санхүүжүүлэхээр төлөвлөн тусгасан болно.

### ТАБ. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

*Хүснэгт 20. Макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд.*

Үзүүлэлтүүд	2014	2015	2016	2017	2018*	2019**	2020***	2021***
ДНБ, оны үнээр (тэрбум төгрөг)	22227.1	23134.1	23,935.9	27,895.5	32,149.9	36,310.6	40,681.2	45,826.2
Нэг хүнд ногдох ДНБ (мян.төгрөг)	7501.3	7642.9	7,747.9	8,856.1	9,761.4	10,785.1	11,823.0	13,057.1
ДНБ-ий бодит өсөлт (хувь)	7.9	2.4	1.2	5.3	6.9	8.0	6.0	6.0
Үүл уурхайн салбарын бодит өсөлт	19.4	14.1	0.2	-5.5	5.1	1.3	0.7	16.5
Үүл уурхайн бус салбарын бодит өсөлт	5.0	0.0	1.6	8.8	7.5	9.9	7.4	3.5
Хэрэглээний үнийн өсөлт (оны эцэст)	11.0	1.9	1.1	6.4	8.1	8.0	8.0	8.0

Эх үүсвэр: Сангийн яам

\* Урьдчилсан гүйцэтгэл, \*\* Хүлээгдэж буй гүйцэтгэл, \*\*\*Төсөөлөл

--ооОоо--

“Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн төслийг Улсын Их Хурлын нэгдсэн чуулган, байнгын хороодоор хэлэлцүүлэхтэй холбоотой Сангийн яамнаас оролцох ажлын хэсгийн нэрс:

Д/д	Нэр	Албан тушаал
1	Ч. Хүрэлбаатар	Сангийн сайд
2	Х. Булгантуяа	Сангийн дэд сайд
3	С. Наранцогт	Төрийн нарийн бичгийн дарга
4	Г. Батхүрэл	Эдийн засгийн бодлогын газрын дарга
5	И. Батхүү	Хөгжлийн санхүүжилтийн газрын дарга
6	Ц. Зоригтбат	Санхүүгийн бодлогын газрын дарга
7	М. Санжаадорж	Төсвийн зарлагын хэлтсийн дарга
8	Ж. Ганбаяр	Макро эдийн засгийн бодлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн
9	Х. Оюунцэцэг	Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн
10	Т. Дэлгэрнаран	Макро эдийн засгийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн
11	С. Сүхдэлгэр	Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн
12	Л. Түвшинжаргал	Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн
13	Д. Очирваань	Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн
14	Э. Билгүүн	Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

#### ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР